



МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН



*Эмэгтэйчүүд нийгмийн өөрчлөлтийн хөтлөгчид*

**ШИНЭ** СӨРИЛТ  
БОЛОМЖ  
**ЧУУЛГА УУЛЗАЛТ**

## Агуулга

<b>МЭНДЧИЛГЭЭ</b> .....	<b>4</b>
<b>НЭЭЛТИЙН ҮГ</b> .....	<b>5</b>
<b>“СОРИЛТЫГ БОЛОМЖ БОЛГОЁ” ИЛТГЭЛ</b> .....	<b>7</b>
<b>НЭГДСЭН ХУРАЛДААН: БИДНИЙ ЭРХ</b> .....	<b>15</b>
ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ .....	15
ОРОН НУТГИЙН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО, БОЛОМЖ, ШИЙДЭЛ.....	17
ОХИД, ЗАЛУУ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ .....	20
НИЙГМИЙН ОРХИГДСОН БҮЛГИЙН ЭМЭГТЭЙЧҮҮД БА ЭРХ МЭДЭЛЖҮҮЛЭЛТ .....	24
БЭЛГИЙН ЦӨӨНХИЙН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХҮНИЙ ЭРХ.....	26
САЛБАР ХУРАЛДААНЫ ДҮГНЭЛТҮҮД: ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ.....	29
1) <i>Жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт –Салбар хуралдааны дүгнэлт</i> .....	29
2) <i>Шийдвэр гаргах түвшин дэхь эмэгтэйчүүдийн оролцоо-Салбар хуралдааны дүгнэлт</i> .....	30
3) <i>“ОХИД, ЗАЛУУ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ” салбар хуралдааны дүгнэлт</i> .....	31
4) <i>Асуудал нь орхигдсон бүлэг: салбар хуралдаанаас гарсан санал дүгнэлт</i> .....	35
<b>НЭГДСЭН ХУРАЛДААН: ХӨДӨЛГӨӨНӨӨ БЭХЖҮҮЛЭХ НЬ</b> .....	<b>38</b>
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ЗАЛГАМЖ ХОЛБОО .....	38
ХӨДӨЛГӨӨНИЙ САН БҮРДҮҮЛЭЛТ .....	39
ДОТООД САН БҮРДҮҮЛЭЛТ .....	42
ХӨДӨЛГӨӨНИЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭХ НЬ.....	45
САЛБАР ХУРАЛДААНЫ ДҮГНЭЛТҮҮД: ХӨДӨЛГӨӨНӨӨ БЭХЖҮҮЛЭХ НЬ.....	47
1) <i>Хөдөлгөөнийн залгамж холбоо – салбар хуралдааны дүгнэлт</i> .....	47
2) <i>САН БҮРДҮҮЛЭЛТ Салбар хуралдааны дүгнэлт</i> .....	50
3) <i>“Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг бэхжүүлэх нь” салбар хуралдааны дүгнэлт</i> .....	51
<b>НЭГДСЭН ХУРАЛДААН: ХӨДӨЛГӨӨН ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭХ НЬ</b> .....	<b>55</b>
ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХӨДӨЛГӨӨН БОЛОН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ .....	55
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-ТУЛГАМДСАН АСУУДАЛ-ХАМТЫН ШИЙДЭЛ .....	57
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ДҮР ТӨРХ БА ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ.....	59
ХҮНИЙ ЭРХИЙН САЛБАРТ МОНГОЛЫН ТББ-ЫН ОРОЛЦОО.....	61
САЛБАР ХУРАЛДААНЫ ДҮГНЭЛТҮҮД: ХӨДӨЛГӨӨН ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ .....	63
1) <i>Хүүхэд хамгаалал ба эмэгтэйчүүдийн хөдөлгөөний хамтын ажиллагаа- Салбар         хуралдааны дүгнэлт</i> .....	63

2) Байгаль орчны болон эмэгтэйчүүдийн хөдөлгөөний хамтын ажиллагаа – Салбар хуралдааны дүгнэлт.....	65
<b>САЛБАР ХУРАЛДААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ:</b> .....	<b>68</b>
1) Хэвлэл мэдээллийн салбартай хамтын ажиллагааг хөгжүүлэх нь - Салбар хуралдааны дүгнэлт.....	69
2) ДҮГНЭЛТ.....	74
<b>НЭГДСЭН ХУРАЛДААН: БИД ХӨГЖЛИЙНХӨӨ ТӨЛӨӨ.....</b>	<b>78</b>
Эрх зүйн чадавхиа нэмэгдүүлэх нь.....	78
ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУСГАХ НЬ.....	81
ЦАХИМ ОРЧИНД АЖИЛЛАХ ЧАДАВХИА БЭХЖҮҮЛЭХ НЬ.....	84
<b>САЛБАР ХУРАЛДААНЫ ДҮГНЭЛТҮҮД: ХӨГЖЛИЙНХӨӨ ТӨЛӨӨ.....</b>	<b>86</b>
1) Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд нэгтгэх нь салбар хуралдааны дүгнэлт.....	86
2) Эрх зүйн чадавхиа бэхжүүлэх нь –салбар хуралдааны дүгнэлт.....	88
3) Цахим орчинд ажиллах чадавхиа бэхжүүлэх нь-Салбар хуралдааны дүгнэлт.....	89
<b>ЧУУЛГАНААС ГАРСАН БАРИМТ БИЧИГ.....</b>	<b>92</b>

## МЭНДЧИЛГЭЭ

Ш.Цэвэлмаа, МУ-ын Анхны Тэргүүн Хатагтай, МОНЭС-ийн Тэргүүн

Бидний урилгыг хүлээн авч “Эмэгтэйчүүд өөрчлөлтийг хөтлөгчид” уриатай “ШИНЭ СОРИЛТ, ШИНЭ БОЛОМЖ” ЧУУЛГА УУЛЗАЛТАД хүрэлцэн ирсэн хамтран ажиллагч, түншлэгч, найз нөхөд Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе.

Өнөөдрийн манай Чуулга уулзалтад тэтгэлэг авсан эмэгтэйчүүдийн 44 төрийн бус байгууллага, бүлгийн төлөөлөл, түүний дотор Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорнод, Дорноговь, Завхан, Ховд, Увс Төв аймаг, Багахангай, Багануур дүүргийн төлөөлөл 23 хүн, урилгаар 18 байгууллагын төлөөлөгч нийт 110 хүн оролцож байна.

Эмэгтэйчүүдийн чиглэлээр ажилладаг анхны байгууллагаас эхлэн үйл ажиллагаа явуулаад удаагүй шинэхэн байгууллага, бүлгүүд ч манай Чуулга уулзалтад оролцож байна. Тэгэхээр оролцогчид маань туршлага, хөдөлгөөнд нэгдсэн цаг хугацаагаараа, хийж байгаа ажлын чиглэлээр өөр өөр, ялгаатай. Жишээ нь, аймгийнхаа хэмжээний эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудыг нэгтгэн ажилладаг сүлжээнээс эхлээд 5-6 эмэгтэйтэй ажилладаг бүлгүүд байна. Хийж байгаа ажлын цар хүрээ янз бүр гэсэн үг. Олон янзын өнгө аястай, олон асуудлаар ажилладаг, байгууллага, бүлэг, хувь хүмүүс Чуулганд оролцож байгаагаараа онцлог юм.

Энэ ялгаатай байдлыг Чуулганы бэлэг тэмдэг болгосон юм. Олон асуудлаар тус тусдаа ажиллаж байгаа байгууллага, бүлгүүд нэгдэж нэг хүч болж ажиллаасай гэдгийг энэ бэлэг тэмдэг бэлэгдэж байгаа билээ. Мөн Чуулга уулзалтыг өндөрлөхөд оролцогчид маань нэгдэж нэгэн хүч болох чин эрмэлзлэл өвөрлөн буцаасай гэж хүсч байна.

Та бүхэн энэ 2 өдрийн турш өөрсдийнхөө эрх, хөдөлгөөнийхөө хөгжил, бусад хөдөлгөөнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх болон өөрсдийнхөө хөгжлийн асуудлыг ярилцах боломжийг Чуулга уулзалт олгохыг зорьж байна. Ийм учир энэ 2 өдөр та бүхэн бие биенээсээ суралцах, холбоо тогтоон ажиллах асар их боломж байна. Мөн өнөөгийн амжилтаараа бахархахын хамт, ямар туршлага сургамж хуримтлуулснаа эргэн харж, шинэ санаа авч, асуудлаа шинээр харж ажиллах, бусад хөдөлгөөнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх, өөрсдийнхөө хандлагыг өөрчлөх хэрэгцээ, шаардлагын шинэ нийтлэг эрмэлзлэл, арга замаа гаргаж ирэх боломжийг энэ Чуулга уулзалт олгоосой гэж хүсч байна.

Чуулгандаа идэвхтэй оролцож, цаашид хийх ажилдаа ганзага дүүрэн шинэ санаа, санаачилгатай буцаасай гэж хүсч байна.

**ЧУУЛГАНЫ АЖИЛД АМЖИЛТ ХҮСЬЕ!!!**

## НЭЭЛТИЙН ҮГ

*Н. Чинчулуун, МОНЭС-ийг үүсгэн байгуулагч, Зөвлөх*

Сайн байцгаана уу? Та бүхэндээ МОНЭС-ийн урилгыг хүлээн авч ажил албаа зохицуулан ирж байгаад гүнээ талархан Тавтай морилно уу? гэж хүсье.

Юуны өмнө энэ хурлыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах гэж өдөр шөнөгүй хичээн зүтгэсэн МОНЭС-ийн баг хамт олон, ялангуяа стаффын гишүүддээ УЗ болон хувиасаа чин сэтгэлээсээ талархаж байгааг хүлээн авна уу? Та бүхэн ч надтай санал нэгдэх байхаа.

Энд Монголын эмэгтэйчүүдийн хөдөлгөөний цөм болсон эмэгтэйчүүдийн байгууллагуудын удирдагчид болон бас л ихэнх нь эмэгтэй манлайлагчтай байгаль орчин, хүүхэд, боловсрол, хэвлэл мэдээлэлийн чиглэлээр явдаг хөдөлгөөнүүдийн манлайлагчид цугласан байна. Та бүхнийг нэг дор харж байгаадаа маш их баяртай байна. Та бүхний ихэнх нь МОНЭС-ийн хамтрагчид юм. МОНЭС-т хандив өргөж үйл ажиллагааг нь ямагт дэмждэг, МОНЭС-аас тэтгэлэг авч нийгмийн өөрчлөхийн төлөө хувь нэмэр оруулдаг бүлгүүдийн төлөөлөл цуглачээ. Мөн ирээдүйд ч бидэнтэй хамтрах шинэ бүлгүүд байгаа гэж бодож байна. Энэ утгаараа МОНЭС хэдийгээр эмэгтэйчүүдийн төлөө хөрөнгө босгож тэтгэлэг олгодог АНХНЫ ҮНДЭСНИЙ САН хэдий ч эмэгтэйчүүдийн хөдөлгөөний нэг гэж өөрсдийгөө илэрхийлдэг юмаа.

Хов хоосноос өөрөөр хэлвэл эмэгтэйчүүдийн төлөө хандив өргөдөг Филантропи үзлийг бий болгох, Эмэгтэйчүүдийн орхигдсон асуудлуудыг олж нээх, тэтгэлэг олгох болон эмэгтэйчүүдийн бүлгүүдтэй ажиллах арга барилд сурах, өөрсдийгөө гадаад дотоодгүй таниулах гээд бүх зүйлийг шинээрэхэлсэн МОНЭС өнөөдөр ийм олон сайхан хамтрагчидтай байгаа нь бидний хөгжлийг харуулах нэг үзүүлэлт ч гэж болох юм.

Энд цугласан Бид,эрх тэгш байдал, цэвэр тунгалаг нийгмийн төлөө өөр өөрсдийн талбар дээрээ, өөрийн үнэт зүйлс зорилгынхоо төлөө маш олон ээдрээтэй харгуй зам туулсан, их ч туршлага хуримтлуулсан. Зарим нь ОУ-ын түвшинд үнэлэгдэх хэмжээний чадавх хуримтлуулсан томоохон нэр хүндтэй байгууллагууд болсон байхад зарим нь өөр өөрийн хүрээндээ гайхамшигтай амжилтуудыг авчирсан. Энэ амжилтуудын талаар ярьвал хэдэн өдөр болох байх. Гэвч энэ 2 өдрийн хуралдаануудын үеэр заримаас нь дурьдагдах байхаа. Тэгэхээр бид энэ нийгмийг өөрчлөхийн төлөө зорилгодоо үнэнч, тууштай, олон сайхан өөрчлөлтүүдийг авчирсан ГАВЬЯАТНУУД төдийгүй НИЙГМИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТЛӨГЧИД мөнөөсөө мөн учраас бид өөрсөддөө баяр хүргэцгээе!!!

Бидэнд ШИНЭ СОРИЛТ-ууд тулгарч байна.

Дэлхий ертөнц тэр чигээрээ өөрчлөлтийг шаардаж байна. Бидний ертөнц улам нарийн төвөгтэй болж, олон төрлийн туйлшрал бүхий болж байна. Өлсгөлөн ядуурал, хүчирхийлэл, тэгш бус байдал, газар нутгаа алдсан, дүрэвсэн гээд олон асуудлууд улам бүр газар авч хүмүүс хохирсоор байна.



Дэлхийн эмэгтэйчүүдийн хөдөлгөөн ч БИД ДАХИН ӨӨРЧЛӨГДӨХ хэрэгтэйг удаа дараагийн хурал зөвлөгөөнүүддээ ярьж хэлэлцсээр байна. Бид дотроо асуудлаа тойроод түүнийгээ улам гүнзгийрүүлж нарийсгаад байх боловч өргөн хүрээнд нийгмийн бусад бүлгүүдийг хамруулж оролцуулж чадахгүй байна гэж үзэж байна. Бид ч бас ялгаагүй үүнтэй санал нэгдэх байх.

Бид өөр өөр сонирхол, олон ялгаатай байдал, арга барил хөгжлийн замналтай хэдий ч бидэнд үр дүнтэй хамтрах талбар байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

ШИНЭ СОРИЛТ-ууд зайлшгүй хаалга тогшиж байна. ... үүнд бид яаж оролцох вэ? Нэгдэх үү? Яаж огтлолцуулах вэ? Гэдгийг бид энэ 2 өдөр ярина.

ШИНЭ СОРИЛТ бол олон сайхан БОЛОМЖ-уудыг бидэнд нээж өгдөг. Шинэ арга барил, шинэ стратеги, шинэ туршлага, шинэ өөрчлөлтүүд бүгд ирнэ. Сайн тал маш ихтэй.

МОНЭС-д 8 жилийн өмнө шинэ өөрчлөлт хийх сорилт ирсэн. Үүний үр дүнд бид болж байгаа болохгүй байгаа өчнөөн зүйлээ тодруулж бүхий л хөтөлбөр, стратегиудаа шинэчилж, шинэ арга барилуудыг туршиж, хийж, ихээхэн амжилтууд ч гаргасан. Мөн саяхан дахин стратегийг шинэчилсэн.

ШИНЭ СОРИЛТ-нд анхаармаар зүйл их бий. МОНЭС энэ өөрчлөлтийн явцад олон эрсдэлүүдийг туулсан. Стафф тэр чигээрээ солигдсон. Олон хүн орж гарсан. Энэ таарна энэ таарахгүй гэх мэт их ч стресстсэн бас бүгд уйлсан.

Одоо 8 жилийн дараа ШИНЭ СОРИЛТ дахин бидэнд дээр ирж байна. МОНЭС бас дахин өөрчлөлтүүд хийж байна. Ингэхдээ Та бүхэнтэй хамтраад ...

Тэгэхээр юу гэх гээд байна гэхээр “нөгөө зовлон үзсэн чавганц” гэдгээр үүнийг бие махбоди сэтгэл зүрхээрээ туулж алдаж оносон учраас ШИНЭ СОРИЛТ зайлшгүй нь, СОРИЛТ-ын давуу болон сул талыг бодоорой. Ертөнцийн хурдыг гүйцэхийн төлөө харж байгаа хүмүүс гайхамшигтай ч бид зөрчилд орох вий салж бутрах вий, бие биенээ үзэн ядах хэмжээнд хүрэх вий. “Сайн судал, сайн тунгаа, сайн суралц, сайн хэлэлц, турш, нөөцөө зөв хувиарла” гэж зөвлөхийг хүсэж байна.

ШИНЭ СОРИЛТ эрт орой хэзээ нэгэн цагт “зайлшгүй” гэж дахин хэлье. Энэ 2 өдөр бидэнд олон сайхан мэдээ мэдээлэл, шинэ зорилго, боломж руу тэмүүлэх итгэл өгнө гэдэгт эргэлзэхгүй байна.

*Та бүхэндээ амжилт хүсье.*

## “СОРИЛТЫГ БОЛОМЖ БОЛГОЁ” ИЛТГЭЛ

*Б.Эрдэнэчимэг, МОНЭС-ийн Гүйцэтгэх Захирал*

Өнөөдөр энэ танхимд манай хөдөлгөөний тэргүүн эгнээнд явдаг 100 гаруй төлөөлөл цугларсан байна. Энд ирсэн хүмүүс нийт эмэгтэйчүүдийнхээ тэг мянганы хувийг төлөөлж байна гэж бодоход цаана нь хичнээн их хүч, нийгмийн өөрчлөлтийг хөтлөгчид байна вэ, бидэнд нийгмийг шударга болгоход бидний ар талд бэлэн ямар их нөөц байна вэ гэдгийг бид харж байна. **“Усыг эргүүлж уулыг нурааж ч чадна”**. Миний төсөл, манай байгууллага гэж өдөр тутмын ажлаа хийж гүйхдээ бид өөрсдийгөө нийгмийн том хөдөлгөгч хүч гэж харсан бил үү? Хоорондоо дотно ярилцаж, туршлагаа солилцож, суралцаж, бие биенээсээ цэнэг авч, ухаанаа тэлж, уран аргаа хурцлах цаг, боломж олгох гэж бид энэ удаа цугларлаа. Бие биенийхээ мөрийг түшиж, өөрсдийгөө, бие биенээ өргөмжилж, хүндэлж, бахархах гэж энэ чуулж. Улмаар хийдэг ажилдаа улам гарамгай, чадамжтай болох гэж, туулсан арван жилээ үнэлж, цаашдын арван жилийнхээ бас нэг том түүхийг бичих гэж гэж бид энд цугларлаа.

Ингэж цэнэглэгдсэнээр л бидний зорилго болох **эмэгтэйчүүдийн амьдралын чанарыг сайжруулах, сайн сайхан аж байдал, эрх тэгш байдал, шудрага тунгалаг нийгмийн орчин бүрдүүлж чадна**. Энэ хүсэл **мөрөөдөл, эрмэлзлээрээ бид жигүүрлэн, тэмцэж, амьсгалж, ажиллаж** байна. Бид өөр хоорондоо олон байдлаараа ялгаатай учир энэ ажлаа олон янзын арга барилаар хийж, олон янзын замыг сонгож ажиллаж ирсэн. Бие биендээ ярьж, хэлэлцэж, улам сайжруулж, боловсронгуй болгох олон санаа, зүйлийг бид хуримтлуулсан. Тэр баялгаа гарган ил тавьж, түгээн дэлгэрүүлье.

**Бүгдээрээ нийгмийн өөрчлөлтийг хөтлөгчид болж ирсэн түүхээ эргэн нэгэн санацгаая!!** Бид бүлэг, хөдөлгөөнөөрөө өнөөдрийг **хүртэлх амжилт, бүтээлээр дүүрэн, сорилтонд бөхийлгүй, бэрхшээлийг даван туулж, олон сайхан амжилт гаргаж, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн хөдөлгөөн болж ирсэн өөрсдийгөө өргөмжилье, өөрсөддөө талархал илэрхийлье. БИД МУНДАГ, БИД ХҮЧИРХЭГ!!** Энэ бол баярлах том учир шалтгаан. Өөрсөддөө баяр хүргэе!!

Нөгөө талаар бидний хийж байгаа ажил, үр дүнтэй харьцуулахад нийгэм, олон нийтэд яаж хүрсэн вэ гэдгийг эргэцүүлэн бодъё. Бид өөрсдөөрөө бахархах төдийгүй олон нийт биднээр сайн байна, ингэж ажиллах ёстой шүү, эд нар шиг л байх хэрэгтэй гэж яриад бахархаад эхэлвэл бидний ажлын үр дүн гарч эхэлж байна гэсэн үг. Гэтэл бид өнөөдөр шалаа шүүрдэж байхад өөр хүмүүс шүүрдсэн хогийг минь тараагаад ширээн дээр гарч бүжиглэж өөрсдөө хийсэн ажил болгоод харуулах явдал энүүхэнд. Бид яахав дээ асуудал шийдэгдэж байвал боллоо гээд л орхидог. Үүнтэйгээ эвлэрээд суух уу эсвэл ажиллаж байгаа байдлаа өөрчлөх үү? Өөрөөр хэлбэл бид хамтарч, хийсэн нэгнээ хүндэлж, түүнийг нөгөө нэг хэсэг нь ахиулж, алсыг харж, харилцан ажиллах хэрэгтэй байна. Ийм учир эдгээр асуудлаа ярих боломжийг олгохын тулд Чуулга уулзалтыг зохион байгуулж байна.

**Энэ 2 өдрийн Чуулга уулзалтаас ямар үр дүнг хүлээж байгаа вэ?**

Шинэ өнцгөөс өөрийгөө, бусдыг харах

**Орчныхоо талаар** /ялангуяа гадаад/ илүү ойлголттой болж, ирээдүйд хийх ажлаа тодорхой, тоймтой болгох, тэр орчинд ажиллаж, үр дүнд хүрч чадна гэсэн итгэлээ улам баталгаажуулах

Илүү мэргэшсэн түвшинд, чанартай ажил хийдэг болоход шаардагдах арга барил, хандлага, ур чадварын талаар шинэ санаа олж авах

Эдгээр санаа оноог хэрэгжүүлэхэд дэмжиж, хамтрах олон шинэ найз/түнштэй болох учраас илүү эрч хүч, баялаг туршлагатай болсон гэсэн итгэлтэй болох Энэ итгэл нь биднийг илүү олон сайн, хэрэгтэй зүйлд хөтлөх нь дамжиггүй.

Хийсэн ажил, туулсан замнал, хүрсэн үр дүндээ тулгуурлан, сургамж, сайн туршлагыг нь ашиглан, хөдөлгөөн, салбар, чиглэлийн ялгаатай байдалтай хэдий ч бие биенээ түшиж хоршин, хамтран ажиллах санаачилга гарна итгэж байна.

### Та бүхнээс бид юу хүсч байна вэ?

Чуулганы үеэр гарсан/сонссон шинэ санаа, шинэ арга хэлбэр, шинэ сэтгэлгээ, шинэ илэрхийлэл, шинэ холбоо, шинэ стратеги, шинэ найз зэрэгт та чин сэтгэлээсээ ярилцаж, юу билээ гэж эргэцүүлэн нэг бодож, өдөр тутмынхаа орчноосоо гарахыг нэг оролдоод үзээрэй.

Өдөр тутмын ажилдаа түүртээд орхигдуулсан **боломж, мэдээллээ олохыг** хичээгээрэй. **Өөртөө хэвшмэл зүйл/хандлага/ байгаа биш биз** гэж нэг шүүмжлэлтэй хандаад үзээрэй.

Дараагийнхаа үе шатанд зориулж өөрсдийгээ эрчлэх. Бие биенээсээ эрч хүч авъя. Шаардлагатай өөрчлөлтийг өөрсдөөсөө эхлүүлэх, Зохистой арга барилаа олох, стратегиа нийцүүлэх, тактикаа тохируулах. Ингэж цэнэглэгдээд бид тэмүүллийнхээ төлөө дараагийн 5-10 жилийн зорилгоо харж, өөрсдийгөө бэлтгэх

### Бид яагаад энэ тухай ярих вэ?

МОНЭС бол эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээрхи ажлыг санхүүжүүлдэг цорын ганц үндэсний сан. Бид 16 жилийн баялаг түүхтэй. Эмэгтэйчүүдийн хөдөлгөөндөө өөрийн гэсэн байр суурь, нэр хүндтэй. Тэтгэлэг авагч нартайгаа хамтдаа бид чухал нийгмийн хөдөлгөөний доторхи хөдөлгөөн болсон.

Та нартайгаа хамтран нийгмийн ийм хүчин болоход бидэнд тусалсан нэг зүйл бол МОНЭС –ын стратеги юм. Стратеги бол орчин, асуудал, арга барилаа эргэн харж, оновчтой замыг тодорхойлдог суурь баримт бичиг. Бид МОНЭС саяхан стратегиэ шинэчилж 2016-2020 оны хооронд баримтлах чиглэлээ баталсан. Энэ удаагийн хөтөлбөрийн стратегийн онцлог бол бид өөрчлөгдөж байгаа өнөөгийн нөхцөл байдалдаа нийцүүлэхийг эрмэлзсэн. “2030 хүртэлх тогтвортой хөгжлийн зорилт”-ын дагуу ажлынхаа агуулгыг гүнзгийрүүлж, үр дүнгийнхээ хүрээг тэлж, зорилтоо шинээр томъёолсон.

Яагаад вэ гэвэл боломж, нөөц, бэрхшээл, сорилт **өмнөхөөс өөр**, учир шалтгаантай болсонтой холбоотой эмэгтэйчүүдийн эрхийн төлөө үйл ажиллагаагаа нийцүүлэх шаардлагатай болсон. Хурдацтай өөрчлөгдөж байгаа нийгэмд нөгөө л асуудлаа, хуучин арга хандлагаараа л хийсээр байвал оновчтой, зохистой юу гэж бид өөрсдөөсөө асуусан. Дэлхийн, олон улсын эмэгтэйчүүдийн сангуудаас сургамж санаа авсан. Зорьсноо тусгаж, өөр хүрээ, хандлагаар гаргаж ирэхийг эрмэлзсэн.



Энэ стратегиа, шинэчлэх учир шалтгаанаа бид юуны өмнө та нартайгаа хуваалцахаар зорьсон юм. Хүрч чадахгүй байгаа болон ажиллах ёстой бүлгүүдийн хүрээг нэмэгдүүлье гэсэн. Тухайлбал, бэлгийн цөөнхи, түүний дотор ЛБТ, залуу охид эмэгтэйчүүдийн эрхийн асуудал. Цаашид бид өргөн хүрээнд ажиллах хэрэгтэй болж байна. Учир нь хүрэх ёстой цаана нь маш олон эмэгтэйчүүдийн бүлэг үлдээд байна. Малчин, гэрийн үйлчлэгч, айлын мал харж байгаа эмэгтэйчүүд, биеэ үнэлэгч эмэгтэйчүүдийн эрхийн асуудлууд.

Нөгөө талаар бид стратегидаа түншлэлийнхээ хүрээг өргөжүүлэх хашгирч шаардах бус, харин хариуцлага тооцох аргаар ажиллана гэсэн. Бодлого, хууль, хөрөнгийн зарцуулалтыг үр ашигтай хэрэгжүүлэхэд төр, орон нутаг, холбогдох бусад талуудтай түншлэж, илүү нарийн хамтран ажиллахаар тусгалаа.

Эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн эрх тэгш байдлын эрх зүй, бодлого харьцангуй сайжирсан. Тэгвэл цаашид энэ талын ажлын тэргүүлэх чиглэл юу байх вэ гэж эрэгцүүлээд, хэрэгжилтийг хангах асуудал гэж тусгалаа. Ингэхийн тулд юуны өмнө хууль, бодлогын орчин, нөхцлийг, тэргээрийн бий болгосон арга механизм, үүрэг хариуцлагыг бид өөрсдөө ойлгож, тохирсон өөр арга зам, өөр хандлага, өөр ур чадварыг олж ажиллахад хүч нөөцөө төвлөрүүлэхээр болж байна. Ингэж ажиллахын тулд шаардлагатай чадавхийг нэн тэргүүнд нэвтрүүлж, дэлгэрүүлэхэд МОНЭС манлайлна гэсэн үүрэг авлаа. Ийм учраас эрхийнхээ төлөө цуцалтгүй ажиллаж, ихийг сурч, бүтээсэн та бүхэнтэйгээ хамт энэ Чуулга уулзалтыг зохион байгуулж байна.

Энэ шинэ стратегид манай хөдөлгөөн нэгдэж, өргөмжлөн авч түгээн дэлгэрүүлнэ гэж найдаж байна.

Бид шинэ стратегийг хэрэгжүүлэхийн тулд хараагаа тэлж, хүрээгээ өргөжүүлэн, түншүүдээ нэмэгдүүлж, арга барилаа баяжуулж, хөгжүүлэхийг зорьж байна. Ингэж ажиллах нь бусад байгууллагуудтай түншлэх боломжийг нэмэгдүүлэхийн хамт олон улсын доноруудаас авах санхүүжилтийг нэмэгдүүлж эхэллээ.

Бид энэ оноос **Яг одоо эмэгтэйчүүдийн эрх, байгаль орчны шударга ёсыг бэхжүүлэн нэгтгэх**” алсын хараатай **“Жендэр болон Ногоон үйл ажиллагааны төлөө дэлхийн альяанс”**–ын нэг хэсэг болж, дэлхийн 43 оронд эмэгтэйчүүдийн ус, хүнсний аюулгүй байдал, цэвэр, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах нийгмийг бүтээхийн тулд эмэгтэйчүүдийн эрхийн болон байгаль орчны хөдөлгөөнүүдийг нэгтгэн, хамтарсан нэгэн хүчин болохын төлөө хөтөлбөрт оролцож байна.

Бидэнд хөндөн ярилцах, хамтын ажиллагааны хүрээгээ тодорхойлох маш олон асуудал байна. Бидэнд хөндөж ярилцах олон чухал зүйл байгаа хэдий ч энэ 2 өдрийн хугацаанд багтаахын тулд бид цөөн хэдэн асуудалд төвлөрнө. Чуулга уулзалтын хөтөлбөрийн дагуу бид дараахь асуудлыг сонгож авч хэлэлцэхээр шийдвэрлэсэн юм:

Бидний эрх

Бидний хөдөлгөөн

Хөдөлгөөн хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь

Бид хөгжлийнхөө төлөө.

Ийм үр дүнг ямар байдлаар хандаж, шийдвэрлэж болох вэ гэсэн санал бодлоо та бүхэнтэй хуваалцая. Өнөөдөр бид “эмэгтэйчүүд” гэж ярихгүй. Өөрсдийнхөө тухай гурав дахь биенээс ярихаа больё.

**Ажлынхаа арга барил, хандлага ямар байгаа вэ гэдгээ эргэн нэг харъя.**

Дээрх бүх асуудлыг хэлэлцэхэд бидний хандлага, ажлын арга барил Чуулга уулзалтын туршид хөндөгдөж, яригдана. Асуудал хэлэлцэхэд хандлага, арга барилаа ярилцана. Даяаршиж байгаа өнөөгийн нөхцөлд **бидний хандлага, арга барил одоогийн орчин нөхцөл** байдалдаа тохирч байна уу гэдгээ дахин нэг эргэн харъя. Тэрхүү шинэ орчин бидэнд ямар шинэ боломж, сорилт гаргаж ирэх бол гэж эрэгцүүлэн бодъё, сонсьё, ярилцъя. Хүрээгээ тэлж, мэдлэгээ баяжуулж, арга барилаа тохируулъя. Ийм замаар л бид илүү сайн, илүү тогтвортой үр дүнд хүрнэ гэдэг үүднээсээ бусад оролцогчидтой саналаа идэвхтэй солилцъё. Бид хандлага, арга барилаа өөрчлөхгүй бол боломжоо сорилт болгон хувиргана.

Улам даяаршиж буй нийгэмд олон зүйл хурдан өөрчлөгдөж, гадаад дотоод хүчин зүйлсийн нөлөө, харилцан үйлчлэл бидний ажилд олон **шинэ асуудлууд, сорилтуудыг гаргаж тавьж байна.** Тэдгээрийн хэрхэн ойлгож мэдсэнээс бидний үр дүн, амжилт ихээхэн хамаарна. Бидний ертөнц илүү нарийн төвөгтэй болж, олон төрлийн туйлшрал бүхий болж байна. Тэгшбус байдал, хүчирхийлэл хэвээр байгаа ч бидний хөдөлгөөний ачаар өнөөдөр бас олон боломж, олон үүд хаалга нээгдэж байна.

**Бидний эрхийн асуудлын харилцан хамаарал нэмэгдэж байна.**

Ажлынхаа хүртээмж, далайцыг нэмэгдүүлэхгүй бол тулгараад байгаа, шийдэх ёстой асуудалдаа хүрч ажиллаж чадахгүй. Учир нь **бидний эрх олон асуудлыг хамардаг**, тэдгээр асуудлаар бид ажиллаж ирсэн, арвин туршлага хуримтлуулсан, мэргэшсэн. Гэхдээ одоо эрхийн олон асуудлын харилцан хамаарал улам бүр нэмэгдэж байна. Өнөөдөр тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх ажил эрчимтэй эхэлж байна. 2030 он хүртэл дэлхий нийтээрээ хүрэх ёстой 17 зорилтыг дэвшүүлэн тавьсан. Эдгээр 17 зорилт бүгд бидний эрхтэй холбоотой. Эдгээр зорилтууд дотор бидэнд хамаагүй гэж хандах нэг ч асуудал байхгүй. Жишээ нь: бидэнд хамаатай гээд зөвхөн 5-р зорилтыг аваад үзье: **Жендэрийн эрх тэгш байдлыг хангах** асуудал. Энэ нь **нэн тэргүүнд бид нарын барьж ажиллах ёстой асуудал хэдий** ч ядуурлыг устгах, баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах гээд бүх зорилгын цаана бидний эрх хөндөгдөж байна. Тэгэхээр бидний ажлын талбар, орон зай улам нэмэгдэж, эрхийн асуудал салбар хоорондын уялдаа, холбоотойгоор шийдэгдэх болж байна.

Өөр нэгэн жишээ дурдая, Өөрсдийнхөө эрхийг эдийн засгийн эрх, эрх мэдлийн хуваарилалттай холбож авч үзье. Ялангуяа өмч, хөрөнгө, мэдлэг чадвар, арга чадвар зэрэг олон шинж, ангиллаар нь цогцоор ханддаг болж байна.

Дагнан хандвал тогтвортой үр дүн, үр нөлөө гарахгүй гэж үздэг болж байна. Иймд бид өнөөдөр маргаашийн турш эдгээр гаднах орчны зүйлс, өөрчлөлт юу билээ, бидэнд хэрхэн нөлөөлөх, бидэнд юу хэрэг болох, тэдгээрийг хэрхэн тусгах талаар ярина. Ийм цэнэг бидний цаашдын ажилд амжилт болон гарч ирнэ гэж хүлээж байна.

Хэдийгээр нэг удаа уулзалтаар бүх зүйл хялбар амархан биеллээ олохгүй ч арай болоогүй, ингэж ажиллах хэрэг байна уу, амраар нь өөрсдийнхөө хийдэг ажлыг хийе гэж бодвол бид хөгжлөөсөө хоцорч, бидний хийх ёстой ажлын орон зай, талбар хоосон байсаар байна. Бидний асуудлыг биднээс өөр хэн ч шийдэхгүй.

## **СӨРИЛТӨӨ БОЛОМЖ БОЛГОН АЖИЛЛАЯ.**

### **Бидний хөдөлгөөн**

Манай хөдөлгөөн, бидний амжилт, сургамж баялаг, их. Гэхдээ бид хөдөлгөөнөө энгийнээр харж болохгүй болсон цаг. Хөдөлгөөнөө бид машин гэж төсөөлье. Машины эрэг шураг, боолт, эд анги байр байрандаа, тосолгоотой, зэврээгүй байж машин хөдөлнө, ямар нэгэн доголдолгүй байж хүчээ авдаг. Бидний хөдөлгөөн яг түүнтэй адил. Тэгэхээр энд цугларсан та бүхэн бүгд хөдөлгөөний эд эс, нэг хэсэг. Харин танд энд яриад байгаа асуудал нь өдөр тутам хийж байгаа ажилтай хамаарал нь бага мэт санагдаж болох хэдий ч Та энэ олон асуудлын зөвхөн нэгийг барьж ажиллаж байгаа учир энд ярьж байгаа асуудал танд ч хамаатай. Ганцаараа асуудлаа шийдвэрлэх гээд явж байснаас бүлэг болон асуудлын төлөө явбал үр дүнтэй гэдгийг бид бүгд мэднэ. Машин нь жижиг олон эд ангиас бүрддэгтэй адил бидний хөдөлгөөнийг бүрдүүлж байгаа хүмүүс/бүлгүүд ялгаатай, байр суурь ч ялгаатай, заримдаа эсрэг тэсрэг байр суурьтай хүмүүсээс ч бүрдэж байна. Тэдгээр ялгаатай хүмүүс, бүлгийг бид төсөл ажилдаа хэрхэн нийцүүлж, тэдний өөр мөн чанар, шинж, ашиг сонирхол, эрмэлзэл, сэдэл, харгалзан, түшиглэж ажиллаж байна вэ гэдгээс бидний амжилт хамаарах болж байна. Иймд бид бие биенээ нэгд нэгэнгүй ойлгож, нэгддэг сөрдөг талуудаа нарийн тодорхойлж, нэгдлээ бэхжүүлэхийн тулд түншлэгчдээ өргөжүүлэх шаардлагатай.

Өөрчлөгдөж байгаа орчноо илүү сайн ойлгож ажиллах шаардлагатай болжээ. Орчныхоо талаар ялангуяа донорууд хэрхэн өөрчлөгдөж байгаа, ямар үйл ажиллагааг илүү анхаардаг болж байгаа талаархи мэдлэг ойлголтоо сайжруулахгүй бол санхүүжилтээ ч олж авч чадахгүй, эрхэм зорилгоо хэрэгжүүлж чадахгүй болж магадгүй. Өнөөдөр амжилттай ажиллана гэдэг нь амжилттай хөрөнгө босгогч байна гэсэн үг. Энэ чухал талбарт байдал хамгийн их өөрчлөгдсөн. Эмэгтэйчүүдийн эрхийн асуудлыг шийдвэрлэхэд санхүүжилт өгдөг донорын тоо цөөрсөөр байна Цаашдаа ч хамгийн их өөрчлөлт гарна. Санхүүжилт бол ширүүн тулалдааны салбар – та бүгд сайн мэднэ. **Нэг муу мэдээ бол хөгжлийн санхүүжилт их буурсан**, цаашдаа бүүр их буурна. Тэр хөрөнгийн доторх ТББ-уудад гэж хуваарилдаг байсан хэсэг бүүр ч багасч байна. Гэтэл тэрхүү санхүүжилтийг гадны, олон улсын байгууллагууд илүү ур чадвартайгаар авдаг. Цөөн үгээр хэлбэл дундарсаар байгаа тогооноос маш түрэмгий араатантай өрсөж хуваалцах болж байна. Пүүс, компаниуд хөгжлийн, ялангуяа тодорхой орон нутгийн тодорхой асуудлаархи санхүүжилтээ илүү ихээр гаргадаг болж байна. Эл байдлыг эерэгээр харья гэвэл, бидэнд ашгийн төлөө хэвшилд орох бололцоо нээгдэж байгаа, ингэвэл өөрсдийнхөө хүч хөдөлмөрийг арилжааныхантай адил үнэлүүлдэг болох боломж бүрдэнэ.

**Сайн мэдээ бол тусгай зориулалтын санхүүжилтийн сан өсөн нэмэгдэж** байгаа. Тэдгээр тусгай сангийн тоонд юуны өмнө Ногоон өсөлтийн сан – 2020 он хүртэл \$100 тэрбум босгохоор засгийн газрууд Риод амласан. Гэхдээ эндээс санхүүжих төсөл онцгой шаардлагатай. Бидний уламжлалт маягийн, энгийн, өнгөц, заримдаа өрөөсгөл хүрээ агуулгатай төсөл санхүүжилт авах магадлал тун хомс.

Голдуу салбар хоорондын цогц, орхигдуулсан бүлгүүдийг доороос дээшээ, эрх мэдэлтэй, эрх тэгш, утга агуулгатай хамарч оролцуулсан төслүүд батлагдаж чадна. Ийм төслүүд гол төлөв урт хугацааны, асуудлыг давуу талаас, хэмжигдэхүйц, хариуцлагатай, сул талыг хүртэл гаргаж өгсөн өөрөөр хэлбэл хүчтэй төслүүд байдгаараа онцлог.

### **Хөдөлгөөнүүдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх нь**

Өргөн хүрээнд, манай хөдөлгөөн бусад хөдөлгөөнтэй хамтран ажиллах тухай сэдэв чиглэлээр ярья. Өөр өөр хөдөлгөөнүүдээс нийгэм бүрдэх ба тэдгээрийн хоорондын харилцаа, харилцан ажиллагаанаас дэвшил гардаг. Бид тэдний адил, бүгд нийгмийн хүчин зүйлс. Тэгвэл тэдгээр хөдөлгөөн яагаад чухал, ямар ажлыг ямар орчинд яаж хийдэгийг бид мөн дээрхийн адил илүү сайн мэдэж, ойлгох шаардлагатай. Бидэнтэй холбоотой, хэрэгтэй, ашигтай, сургамжтай зүйл олон байгаа. Өөрөөр хэлвэл, тухайн орчинд ажиллаж буй хүчин зүйлс, тэдгээрийн мөн чанар, ашиг сонирхол, үндэслэл сэдэл зэргийг хэлж болно.

Яагаад бид бусад хөдөлгөөнтэй хамтрах билээ? Ийм хэрэгцээ шаардлага нэгэнт тулж иржээ. Гэхдээ нийгмийн эдгээр хөдөлгөөнөөс бидний холбоотон хэн бэ? Тэдэнтэй бид ямар чиглэл, асуудлаар нийлэх вэ? Хэрхэн хамтран ажиллах вэ? Энэ талаар ярилцаж, хоорондоо танилцаж, нөхөрлөх орон зайг удаах хоёр өдөр бидэнд олгоно. Ямар замналаар өдий хүрч, ямар туршлага сургамж хуримтлуулснаа хуваалцаж, нийтлэг эрмэлзэл, арга замаа гаргаж ирэх боломжийг энэ чуулган олгоно гэж бид итгэж байна.

Өнөөдөр бүх асуудал **салбар хоорондын зохицуулалтыг** шаардаж байна. Ялангуяа байгаль орчны, сайн засаглал, салбарын асуудлууд бидэнд ч бас хамаатай гэдгийг улам илүү ойлгож байна. Ийм учир тэдэнтэй хамтарч, хүчээ нэгтгэж, аргаа хослуулвал үр дүн улам сайн болно. Бусад хөдөлгөөнтэй хамтрах нь хамтраарай гэж зөвлөх биш заавал нэгдэх ёстой гэсэн шаардлага болжээ. Гэхдээ хэрэв бид өөрчлөгдөж, өөрсдийгөө боловсруулахгүй бол эдгээр боломж бидэнд сорилт болно.

Ингэхийн тулд бид хоорондоо мэдээлэл, мэдлэг, туршлагаа солилцож – өөрсдийгөө боловсронгуй болгодог - оновчтой суваг, арга барилтай болох ёстой. Хамгийн гол нь эв нэгдэлтэй байх ёстой “Түүний энэ ажилд энэ тустай” гэж ханддаг байх. Ингэж байж бид өөрсдийгөө хөгжүүлнэ, хүссэндээ ч илүү дөт, илүү үр дүнтэй хүрнэ. Үүний “аль нь ч хожих”, “хоёул хожих” гэж хэлдэг байна. Бид ч бас үүнд зорих ёстой. СӨРИЛТОО БОЛОМЖ БОЛГОЁ.

### **Бид хөгжлийнхөө төлөө**

Бид “тулгаа тойроод” байдгаасаа нэг удаа холдож, **өргөн хүрээнд харъя**. Төслийнхээ хүрээнд байгууллага дотроо ихэнхдээ эргэлддэг бидэнд ингэж ярих, хэлэлцэх боломж ховор олддог. Биднийг өдөр тутмынхаа ажлаа хийж байх хооронд бидний мэргэжил, ажилладаг салбарын онол, практик хөгжөөд, олон ололт, чухал шинэ зүйлс тогтмол гарч байна. Тэдгээрийг нэг багцлан харъя. Хөгжил гэдэг салбарт бидний үйл ажиллагаа багтдаг. Энэ салбар өөрөө мэргэжил. Энэ мэргэжлээр ихээхэн ахиц өөрчлөлт гарсан. Эдгээрээс сурч нэвтрүүлж байж л бид нийгмийн ач холбогдлоо батлах юм. Мөн дэлхий, бусад оронд бидэнд хэрэгтэй олон зүйлс шинээр нэвтэрч, хүний практик, арга хандлага өөрчлөгдөж байна. Тэдгээрийг мэдэж, сонгон хэрэглэж, буруугаа засч, сайныгаа улам сайжруулъя. Бид

даяаршсан хөдөлгөөний хэсэг, тэр хөдөлгөөн нь орчлонгийн өнгө, хэв маягийг өөрчилдөг хүчтэй, тийм түүхтэй. Бид өөрсдийнхөө ажлыг мэргэшсэн түвшинд хийхийг даяаршсан нийгэм биднээс шаардаж байна.

Эмэгтэйчүүдийн хөдөлгөөний ачаар нийгэм, улс төр, засгийн газрууд, банк, бизнесүүдэд хичнээн их өөрчлөлт гарч, хичнээн их эерэг зүйл нийгэмд түгээн дэлгэрсэнийг саная л даа. Мэдээж дэвшилтэт үзэлтэй өөр олон хөдөлгөөн, олон засгийн газар, институц /жишээ нь НҮБ/ олон зүйлээр дэмжиж ирсэн. Зуун жилийн өмнө аль нэгэн оронд охидыг хүчиндсэн хүнийг шоронд суулгадаг байсан бол? Эмэгтэй сайд, хууль тогтоогчид, төрийн тэргүүн байсан билүү? Энэ том замнал бол бидний түүхэн замнал. Хорин жилийн өмнө гэж энэ түүхэн замналын хэсэг гэж өөрийгөө хардаггүй байсан. Одоо бол тэр өөр, энэ түүхэн замналын нэг хэсэг гэж өөрийгөө харах. Тэндээс бид мэдлэг, чадвар, эрч хүч авна. Түүнд бид өөрсдийнхөө мэдлэг, чадвар, эрч хүчийн нэмэрлэнэ.

Энэ бол маш их нэр хүнд. Маш том хариуцлага. Түүнийг даах чадал бидэнд бий.

### **Эцэст нь бид энэ 2 өдрийн турш ямар зарчмыг барьж ажиллах вэ?**

Энэ асуудлуудыг бид өмнө нь сонсож байсан, ярьж ч байсан. Харин энэ удаа бид арай өөр өнцгөөс харж ярина. Ерөнхий зарчим – манай төсөл, манай байгууллага гэж ярихгүй. Бидний төсөл, байгууллагын, хөдөлгөөний амжилт, ололт гэхээсээ илүү бидний зорьж ажилладаг зорилтот бүлэг, хүмүүсийнхээ нийгмийн байдлыг сайжруулах зорилгынхоо тухай ярья. **Өөрөөр хэлбэл эцсийн үр дүнгийнхээ тухай, хүмүүст, нийгэмд тусалдаг ажлаа хэрхэн сайн хийх тухай ярина.**

Бас нэг ерөнхий зарчим бол **бид хэр оновчтой, сайн, мэргэжлийн түвшинд, нээлттэй, оролцоо, хамралттай ажиллаж байгаа билээ** гэдэг талаар ярина. Өөрсдийгөө хөгжүүлэх, ажлаа мэргэжлийн түвшинд илүү сайн хийх тухай. Ингэхийн тулд өөрчлөгдөж буй орчинд, шинээр гарч ирж байгаа шаардлагад өөрсдийгөө илүү нийцүүлж, бэлтгэх тухай. Өөрөөр хэлбэл, өөрсдийнхөө өргөн мэдлэгтэй, ирээдүйд ч ач холбогдолтой байлгах мэдлэг, мэдээлэл, чадварынхаа тухай ярилцая. Бид түнш болох ёстой хүнтэйгээ түншилж чадаж байна уу? Хамруулах ёстой хүмүүсээ хамруулж чадаж байна уу? Орхигдуулсан хүн/бүлэг байгаа биш биз? Сонсох/ойлгох ёстой хүмүүсээ сонсож/ойлгож чадаж байна уу /доороос дээшээ/, эсхүл оронд нь өөрсдөө ярьж тэднээр сонсуулж /дээрээс доошоо/ байна уу? Ажлынхаа арга барилыг эргэж харна, сайн арга туршлагаас сурна, ингэхийн тулд өөрсдийнхөө дотроос сайныг хайж, муугаа мэдэж орхино.

Гуравдахь зарчим **бол өргөн өнцгөөс, өргөн утгаар ярина.** Бодит үр нөлөө хүргэх талаар, тэрхүү үр нөлөө нь байнгын, урт хугацааны байх тухай – тогтвортой хөгжлийн тухай ярина. Асуудлаа өргөн, бодит утгаар харж, холбоотой ...

Дөрөвдэх зарчим бол **санхүүжилтийн шинэ орчин.** Манай хөдөлгөөн яаж ажиллавал өөрчлөгдөн буй энэ орчинд санхүүжил олож авах, хэнтэй яаж ажиллах вэ, хүчтэй сайн төсөлд ямар хөдөлгөөнтэй хамтран орох вэ. Эрхийнээ аль асуудлыг ямар өнцгөөс харвал эргэлдэж байгаа тэр их мөнгөний урсгалаас олж авах вэ? Зөвхөн хөдөлгөөн дотроо эргэлдэх нь биш өргөн хүрээнд харьяа.



Хэдийгээр Чуулга уулзалт бидний эрх, хөдөлгөөн, хөдөлгөөн хоорондын хамтын ажиллагаа, хөгжил гэсэн 4 сэдвийн хүрээнд явагдах хэдий ч сэдэвт бүү баригдаасай гэж бид хүсч байна.

Та бүхнийг миний энэ илтгэлдээ дурдсан асуудлуудын талаар эрэгцүүлэн бодож Чуулга уулзалтдаа идэвхтэй оролцоно гэдэгт эргэлзэхгүй байна. Та бүхэнд амжилт хүсье. Их баярлалаа.

## НЭГДСЭН ХУРАЛДААН: БИДНИЙ ЭРХ

### ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

*С.Дондов, Иргэдэд туслах хүний эрхийн төвийн тэргүүн*

Жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалтын /ЖСЯГ/ асуудал нь нийгмийн бүхий л салбарт түгээмэл гардаг сөрөг үзэгдлүүдийн нэг юм. Энэ асуудал ИНБ-дын анхаарлын төвд байсаар ирсэн, цаашид ч анхаарах чухал асуудлын нэг гэж үздэг. Энэ сөрөг үзэгдэл нь улс төр, эдийн засаг, хөдөлмөрийн харилцаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, бэлгийн чиг баримжаа, гэр бүл гэх мэт олон бүлгүүдэд муугаар нөлөөлдөг зүйл. ЖСХ-ийг бууруулах, таслан зогсоох зорилго бүхий олон улсын гэрээ, НҮБ-ын зөвлөмжүүд, хууль тогтоомжууд, судалгаануудын санал зөвлөмжүүд олон байдаг. Үүнд ч ИНБ-д бас тодорхой хэмжээгээр хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Ялгаварлан гадуурхахгүй байх асуудлын тухайд төрийн бүх тогтолцоо, нийгмийн амьдралд өнөөдрийг хүртэл бид төлөвшүүлж амжаагүй байна. Олон хүмүүс бүлгүүд ялгаварлан гадуурхагдаж үндсэн хуулиар олгогдсон хүн бүр нийгмийн харилцаанд тэгш оролцох боломжоо алдаж байна.

**ЖСХ-с хамгаалагдахын тулд бидэнд юу дутагдаж байна вэ** гэдгийг ярихын тулд бид дараах зүйлийг зайлшгүй анхаарах хэрэгтэй байна. Үүнд:

**Зохицуулалт** хийх хэрэгтэй. Үүний тулд бид хамтран ажиллаж олсон мэдлэг туршлага дээрээ тулгуурлан алдаа оноогоо дүгнэж, санаа бодлоо ярьж бусдын сайн туршлагаас суралцаж өөрт тохирох хувилбарыг сонгон энэ асуудлыг шийдвэрлэх боломжтой.

**Олон нийтийн мэдлэг, ойлголтыг байнга дээшлүүлж** байх нь чухал юм. Илүү чанартай оновчтойгоор олон нийтийг гэгээрүүлэх, хүчирхийллийн эсрэг явуулж буй үйл ажиллагаа, төрийн бодлогын талаар зөвлөлдөн ярилцаад хамгийн энгийн үр дүнтэй хувилбар юу байж болох асуудлаар тогтмол санаа бодлоо солилцох нь чухал.

**Бодлого, хууль эрх зүйн дүн шинжилгээг** ИНБ-га байнга хийж дүгнэлтээ гаргаж байх нь олон ач холбогдолтой. Хууль, бодлогын шинж чанартай бичиг баримтуудад ИНБ –д өөрсдийн санал бодлоо тусгаж чаддаг хэдий ч хэрэгжилтэд төдийлөн хяналт тавьж, хэрэгжүүлэх үр дүнтэй болгох арга механизмийг бий болгож чадаагүй байна.

**Мониторинг, хяналт, үнэлгээ** байнга хийгдэж байдаг зүйл. Бодитой дүн шинжилгээ, судалгаа, хяналт үнэлгээний үндсэн дээр бид үндэслэл бүхий санал, гарцуудыг төрийн байгууллагуудад тавьж байх ёстой. Үндэслэл бүхий саналыг хэрэгжүүлэх, хуулийг биелүүлэх шаардлагыг байнга тавьж, хийж хэрэгжүүлэхгүй байгаа тохиолдолд хариуцлага тооцохыг шаардах нь эрүүл тогтолцооны эхлэл болно. Өнөөдөр бидэнд хамгийн бэрхшээлтэй зүйл бол төрийн байгууллагууд аливаа асуудалд хариуцлага тооцохгүйгээр өнгөрдөг явдал чөдөр тушаа болж байна.

**Зөрчигдсөн эрхийг сэргээх** гэдэг нь хэн нэгний асуудлыг хуулийн дагуу шийдээд орхих биш, тэр хүний эрх яаж хохирсон юм сэтгэл санаа, эд материалын хувьд, түүнийг нь нөхөн сэргээж хохилыг бүрэн барагдуулж хэвийн байлгах тэр боллоцоог өнөөдөр хууль тогтоомж, арга туршлагын хувьд ч хараахан тогтоож чадаагүй байна.

Бид өөрсдийнхөө чадавхийг сайжруулж, оюун бодлоо уралдуулан улс орнуудын хөгжилтэй үргэлж хөл нийлүүлэн явах шаардлагатай болж байна. Хүн бүрйн тэгш эрхийг хангаж ялгаварлан

гадуурхагдахгүй, хүчирхийлэлд өртөхгүй байх боломжийг бүрдүүлэхийн тулд төрөөс батлагдан гарч байгаа бодлого, хөтөлбөрүүд хэрэгжих баталгаатай байх ёстой. Үүний тулд мэдээж **санхүүжилт** хэрэгтэй. Тийм учраас гарч байгаа бодлогын шинжтэй баримт бичгүүдийн санхүү нь тов тодорхой, тэр нь төсөвт тусгагдаж олон нийтэд ил тод байснаар төрийн болон ИНБ-ын үйл ажиллагаа үр дүнтэй болно.

Өнөөдөр бид ЖСХ-н асуудлыг хэрхэн шийдэж байна вэ?

Эмэгтэйчүүдийн эрхээ эдлэхэд хамгийн чухал боломж, бололцоог хангасан жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлагдан гарсан. Гэсэн хэдий ч өнөөдрийг хүртэл хэрэгжүүлж, үр дүнг нь амсч чадахгүй байсаар байна. Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулинд зааснаар “Хэн нэгэнд АББД учруулсан, хэн нэгэн ямар нэг байдлаар ялгаварлан гадуурхагдсан бол хүний эрхийн үндэсний комисст хандан асуудлаа шийдвэрлэх боломж энэ хуулиар нээж өгсөн”. Гэтэл бид энэ хуулиа хэрэгжүүлээд хэдэн эмэгтэйн хохирлыг бүрэн барагдуулсан бэ гэдэг дээр хэлэх тоо баримт төдийлөн хангалттай биш байна. Өмнөх парламентаар батлагдан 2016 оны 9-р сарын 1-нээс хэрэгжүүлэх байсан хуулиудыг шинээр бий болсон парламент дахин шинэчлэн найруулж батлана гэж хойшлуулж байгаа нь хууль тогтоох байгууллагын хариуцлага ямар хэмжээнд байгааг бидэнд тодорхой харуулж байна.




**Судалгаа, сургалт:** ЖСХ болон ЯГ-н талаар чанартай, хүнд хүрсэн сургалтуудыг байнга хийж ерөнхий боловсролын болон их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт тусган энэ талын мэдлэг мэдээллийг хүүхдүүдэд бага залуугаас нь төлөвшүүлэх явдал нэн чухал байна.

**Төр, Иргэний нийгэм** хамтран хөгжилд хүрэх гарцуудыг гаргаж, хүмүүсээ хөгжүүлж чадавхижуулснаар энэ нийгэм урагштай аятай сайхан хөгжинө.

**НҮБ-н хүний эрхийн** хорооноос гаргаж байгаа зөвлөмжүүдийг ЗГ нэгэнт хүлээн авсан бол үйл ажиллагаандаа удирдлага болгох, тэдгээрийг сайн мэддэг байх, үүнийг хэрэгжүүлэхийн төлөө ИНБ –д ч засгийн газарт байнга шахалт шаардлага үзүүлж байх ёстой. Төр засгийн тодорхой асуудлыг

томъёолсон нэгдэн орсон конвенцийн заалтуудыг удирдлага болгон Монгол улсын тайлан илтгэлийг хянан хэлэлцээд ЗГ-т өгч буй НҮБ-ын хороодын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх нь чухал юм.



ЖСХ болон Ялгаварлан гадуурхалтыг бууруулах улмаар устгах ерөнхий үүрэг амлалт МУ-н засгийн газарт байгаа. Энэ асуудлыг мэдэхгүй байгаа хүмүүст мэдээлэл өгч, тэр хүмүүсийг чадавхжуулах, нөлөөлөх ажлыг зайлшгүй хийх шаардлагатай. Энэ бүхнийг ИНБ-га санаачилж, эрх мэдэл бүхий хүмүүст танилцуулж, шаарддаг байх хэрэгтэй төдийгүй, тэр бүхэн нь яаж хийж болох гарц гаргалгаатай, үр дүн нь тодорхой байх хэрэгтэй байна. Энэ асуудлыг хүний эрхийн ТББ-д л хийж чадна

## **ОРОН НУТГИЙН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО, БОЛОМЖ, ШИЙДЭЛ**

*М.Дуламжав- Завхан аймаг "Өрнөх хөгжил" Сүлжээний зохицуулагч,  
Нийгмийн удирдлагын менежер*

Би та бүхэнд дараахь асуудлын хүрээнд асуудлаа хөндөх гэж байна. Үүнд:

Шийдвэр гаргах түвшинд ажиллах Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны зорилго юу байв?

Улс төрд эмэгтэйчүүдийн оролцооны одоогийн хүрсэн түвшин

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны давуу тал сургамж

Бидний амьдралын зорилго их энгийн. Ердөө "хүний дайтай явж, айлын дайтай амьдран үр хүүхдээ өсгөх" гэсэн бодол. Энэ хоёр хүсэл нийлэхээрээ нийгэм маань шударга, ариун байж, амьдрах орчин эрүүл тунгалаг, эх орон маань цэцэглэн хөгжиж, улс орон маань "улсын дайтай улс" байгаасай гэх нийтийн эрмэлзэлд нэгддэг. Эрх мэдлийг хэрэгжүүлэгч нь зөвхөн төр биш гэдэгтэй бид бүгд санал

нэгддэг. Иргэд ашиг сонирхлоо илэрхийлэх, дуу хоолойгоо нэгтгэж эрхээ хэрэгжүүлэх “Нийгмийн өөрчлөлтийг хөтлөгчид” байхад хамтран ажиллах хэрэгцээ шаардлага байна гэж үздэг.

**Улс төр, шийдвэр гаргах оролцооны хэлбэрүүд ийн талаар өөрсдийн туршлагаасаа та бүхэнд танилцуулъя:**

Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцооны олон хэлбэрүүд байна. Үүнийг дүгнэх хамгийн гол оролцоо бол тооноос илүү чанарт анхаарах өөрөөр хэлбэл **“Тамга барих”** гэдэг гол чухал оролцоо.

Бид өмнөх жилүүдэд УИХ болон аймаг, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгчдийн тооных нь хувьд маш их анхаарч ирсэн. Одоо чанарт анхаарах хэрэгцээ бий болж байна. Төсөв санхүү захиран зарцуулагч хэн байхаас хамаарч асуудал шийдэгдэх болсон

**УИХ болон аймаг, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгч болох төлөөлөлийн оролцоо:**

Төлөөлөлөөр дамжуулан дуу хоолой хүргэхээр тооны талаасаа анхаарч ирсэн нь ямар шийдвэрт хүргэхэд бид нөлөөлж чадах бэ? гэдэг нь бидний өмнө тулгарч байгаа шинэ сорилт болсон.

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо хоёр нь өөр өөр ойлголт болж, өөрсдийн оролцоотойгоор өөрсдийн төлөөлөлийг гаргах хэрэгцээ шаардлага бидний өмнө тулгарч байгаад бид дүгнэлт хийх шаардлагатай байна. /Сул гишүүн, цөөнхийн төлөөлөл бидний төлөөлөл болж чадаж байна уу гэдэг асуудал/

**Иргэдийн дуу хоолой, эмэгтэйчүүдийн байгууллагын хамтын ажиллагааы оролцоо:**

Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо бий болгоход иргэд биднийг хүлээн зөвшөөрч байна уу? Эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээ дэмжиж байна уу? гэдэг нь бидний өмнө бас нэг сорилт болж байна. Бид нэг зорилго дор эмэгтэйчүүдээ дэмжинэ гэдэг нэг зорилт рүү чиглэж нэгдэж чадаж байна уу гэдэг нь мөн бидний өмнө шинэ сорилт, шинэ боломж болж байна. Өөрсдийн төлөөлөлийг өөрсдийн оролцоотой гаргаж байж бид үр дүн хүлээх ёстой. Иргэний нийгмийн байгуулагуудын хамтын ажиллагаа, эв нэгдэл, нэгдсэн нэг зорилготойгоор ажилласнаар бидний дуу хоолой нийгэмд хүрнэ, зорилгоосоо ухрах байх нь чухал.

**Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцооны 2000 оноос хойшхи үзүүлэлт / Аймгийн ИТХ-д /**

№	Сонгуулийн жил	Төлөөлөгчийн тоо	Жендерийн тоон үзүүлэлт	
			Эрэгтэй / хувь	Эмэгтэй / хувь
1.	2000 он	35	29 / 84.4 %	<b>6 / 15.6 %</b>
2.	2004 он	30	24 / 80 %	<b>6 / 20%</b>
3.	2008 он	31	22 / 70.9 %	<b>9 / 29.1 %</b>
4.	2012 он	41	31 / 75.6 %	<b>10 / 24.4 %</b>
5.	2016 он	41	31 / 73.2 %	<b>10 / 24.4 %</b>



Энэ тоон үзүүлэлтээс харахад нэг түвшиндээ байгаад дүгнэлт хийж, цаашид хэрхэн ажиллах яаж арга барилаа өөрчлөх бэ? гэдэг нь бидний өмнө том сорилтыг бий болгож, гарцыг хайх хэрэгтэй болж байна. 2016 оны УИХ-ын сонгууль, аймгийн ИТХ-ын сонгуультайгаа хамт явсан нь Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын ач холбогдлыг бууруулж, орон нутагт нэр дэвшигчдийн төлөө ажиллах, тэднийг олон нийтэд таниулах боломжийг хаасан нь эмэгтэйчүүдийн сонгогдох эрхэд тодорхой нөлөөлөл болсон

## 24 сумын ИТХ-ын төлөөлөгчдийн бүрэлдэхүүн

№	Сонгуулийн жил	Төлөөлөгчийн тоо	Жендерийн тоон үзүүлэлт	
			Эрэгтэй / хувь	Эмэгтэй / хувь
1.	2000 он	480	405 / 82.9 %	<b>75 / 17.1 %</b>
2.	2004 он	435	355 / 81.6 %	<b>80 / 18.4 %</b>
3.	2008 он	458	330 / 72.1 %	<b>128 / 27.9 %</b>
4.	2012 он	448	336 / 75.0 %	<b>112 / 25.0 %</b>
5.	2016 он	441	335 / 76.0 %	<b>106 / 24.0 %</b>

Сумын иргэдийн 441 төлөөлөгчийн ¼ нь л мөн эмэгтэйчүүд. Үүн дээр ч мөн шийдэх боломж, сорилтууд байна.. Энэ жил Сонгууль болохоос нэг сарын өмнө өөрчилсөн хуулийн өөрчлөлтөөр хувь хүн, иргэний нийгмийн байгуулага нэр дэшигчийн төлөө эмэгтэйчүүдийн төлөө явах боломжуудыг хаасан. Үүн дээр бид цаашдаа яаж ажиллах вэ? ямар өөрчлөлт хийх талаар ярилцах хэрэгтэй байна.

## Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо

Он	Аймгийн удирдлага	ЗДТГ-ын хэлтэс		ЗДТГ-ын харьяа агентлаг		Сумын ИТХ		Сумын Засаг дарга			
1.	2000 он	6 / 2	<b>33.3%</b>	5 / 2	<b>40%</b>	10 / 2	<b>20%</b>	24 / 4	16.4 %	24 / 3	12.5 %
2.	2004 он	6 / 1	16.6 %	5 / 1	<b>20%</b>	10 / 2	<b>20%</b>	24 / 1	4.2 %	24 / 2	8.3 %
3.	2008 он	6 / 2	<b>33.3%</b>	5 / 2	<b>40%</b>	10 / 3	<b>30%</b>	24 / 4	16.4%	24 / 5	<b>20.8 %</b>
4.	2012 он	6 / 0		5 / 0		10 / 5	<b>50%</b>	24 / 1	4.2%	24 / 5	<b>20.8 %</b>
5.	2016 он	6 / 2	<b>33.3 %</b>	6 / 3	<b>50 %</b>	10 / 3	<b>30%</b>	24 / 0		24 / 4	<b>16.6 %</b>

Аймгийн ЗДТГ-ын дарга, Засаг даргын орлогч эмэгтэй хүн болсон байгаа. Орлогч бол орлогч л байдаг гэдэг үгийг та бид бүгд сонсож байсан. Тэгэхээр шийдвэр гаргах түвшинд бол "Тамга барих" гэдэг бидний бодох ёстой асуудал / Толгойн өвчин /, бодох зүйлүүд зөндөө байгаа. Энэ Засгийн газар аймгийн Тамгын газрын бүтцийг 6 хэлтэстэй болгосны 3 хэлтэсийнх нь дарга эмэгтэй болсон. Жаахан ахиц байна. Цаашдаа чанартаа илүү анхаарч, тамга барина гэж ажиллах ёстой юм болов уу? гэдгийг та бүхэндээ санал болгож байна.

## Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцооны давуу тал сургамж юу байна вэ? гэвэл:

1. **Эмэгтэйчүүд маш их чадавхиж байгаа.** Эмэгтэйчүүд удирдсан байгууллагуудын үйл ажиллагаа сайн байна гэдэг итгэл үнэмшил бий болсон. Эрчүүд ингэж дуугардаг болсон нь бид

- хүлээн зөвшөөрөгдөж байгаагийн нэг илрэл болж итгэл өвөрлөж байгаа. Гэхдээ хэлсэн амандаа хүрч байна уу? Эмэгтэйчүүдийг томилогдох албан тушаалд олноор бас болоогүй байгаа.
2. **Бид / эмэгтэйчүүд / өөрийгөө өөрөө нээх, асуудалд мэдрэмжтэй хандах, дуу хоолойгоо зөв цагт зөв гаргах гэдэг нь маш их том асуудал гэж боддог.** Бид чадна гэсэн итгэл бий болж байна гэж харж байна. Өмнө нь аймаг, сумдын хуралд өрсөлдөх эмэгтэйчүүд олддоггүй байсан. Одоо бол олддог болсон байна. Өмнө нь эмэгтэйчүүд эмэгтэйчүүдтэйгээ өрсөлдөхгүй гэсэн зарчмыг барьж байсан бол энэ жил бол өрсөлдсөн. Эндээс эмэгтэйчүүд өөрсдөдөө итгэх итгэл бий болсон байнаа гэдгийг харж болохоор байна.
  3. **Нийгмийн төлөө иргэдийн дуу хоолой болж олон нийтэд зөв танигдах нь маш чухал байна.** Ингэснээр олонхийн дэмжлэг авах, нийгмийн массад хүлээн зөвшөөрөгдөх боломж бий болдог. Бид хамт олны дэмжлэг авч чаддаг, хамт олныг дэмжиж чаддаг байх нь гол асуудал боломж гэж харж байгаа.
  4. **Бидэнд нам дотроо идэвхтэй байх, лидер байх, намын сонгуульт ажил хийх, үүнд эр зориг** гаргах шаардлага байна. Энэ оны сонгуульд эмэгтэйчүүдийн байгууллагын төлөөлөл, иргэний нийгмийн төлөөлөл болж, бие даан нэр дэвшиж байгаа хүнийг орон нутгийн сонгуульд гаргах гээд менежер хийгээд явж үзсэн. Гэхдээ гараагүй. Тэгэхээр бие даагаад эмэгтэйчүүд өрсөлдөнө гэдэг бол маш хүнд асуудал юм байна гэдгийг мэдэрсэн. Тиймээс нам дотор байх, нам дотроо лидер байх гэдэг нь гол чухал асуудал юм.

### ОХИД, ЗАЛУУ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

*Ч.Ундрах, Охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах "ГҮНЖ" төвийн үүсгэн байгуулагч*

Дэлхий дахинаа эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх, өөрөөр хэлбэл эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахын төлөөх хөдөлгөөн өрнөөд даруй 100 гаруй жил өнгөрчээ. Гэвч бид өнөөдөр "эмэгтэйчүүдийн эрх" гэдгийг бүх насны эмэгтэй хүйсийн хүнд хамаатуулж ярих, ажиллах, асуудалд хандах боломжгүй болжээ. Өөрөөр хэлбэл эмэгтэйчүүдийг нэг бүхэл хэмээн авч үзэж, ажиллах нь өрөөсгөл юм.

Бид охидын эрхийн асуудал, залуу эмэгтэйчүүдийн эрхийн асуудлыг тусад нь авч үзэж, тэдний насны онцлогт тохирсон шинэлэг арга барил, шинэ алсын хараатайгаар ажиллах цаг иржээ. Үүнтэй уялдаатайгаар охидын эрхийг хамгаалах нь, тэднийг чадваржуулах нь, хүчирхэг насанд хүрсэн эмэгтэй болгож төлөвшүүлэх нь дэлхий нийтийн зорилт болоод зогсолгүй, дэлхийн олон орныг хамруулсан, эгнээндээ нэгтгэсэн хөдөлгөөн болон өрнөж байна. Яагаад охидын эрхийн тухай, залуу эмэгтэйчүүдийн эрхийн тухай асуудлыг онцгойлж, тусгайлан ярих шаардлагатай байна вэ гэхээр эмэгтэйчүүдийн эрхийн зөрчил, тэр тусмаа жендэрт суурилсан хүчирхийллийн золиос болсон хохирогчдын, даван туулагчдын дийлэнх хувийг олон сая насанд хүрээгүй буюу бага насны охид эзэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл өөрсдийнхөө эрхийн төлөө тэмцэх чадварт хараахан суралцаагүй байгаа, дуу хоолой нь чанга биш байгаа, өөрт нь тулгарч буй аливаа бэрхшээлийг хүний эрхийн зөрчил хэмээн ойлгож, харж чадахгүй байгаа олон сая охид хүчирхийлэлд өртөж, эрх нь ноцтойгоор зөрчигдөж буйд асуудлын гол

оршиж байгаа юм. Энэ асуудал Монголд ч гэсэн байгааг хэлэхэд харамсалтай байна. Бид охидоо хамгаалах нэн шаардлагатай байна.

### Охидод тулгамдаж байгаа асуудал

Охидод ямар бэрхшээлтэй асуудлууд тулгараад, тэднийг эрхийг зөрчиж байна вэ? Юуны түрүүнд **бага насны охидыг хүчээр гэрлүүлж буй асуудал дэлхийн хэмжээнд гамшгийн түвшинд хүрчээ** гэж хэлж болохоор байна. Тоо баримт дурьдвал дэлхий дээр 110 улс орон хуулийн дагуу насанд хүрээгүй буюу 18 наснаас доош насны охидыг гэрлүүлдэг байна. Харин манай улс ийм соёлыг өөгшүүлээгүй, гэрдэх насыг хуулиараа 18 хэмээн тусгаж өгсөн нь нэн сайшаалтай хэрэг юм. Нэг жишээ дурьдахад бидний хамгийн сайн мэдэх АНУ гэхэд 16 настай охидыг эцэг эхийн зөвшөөрөлтэйгээр гэрлүүлдэг байна. Мөн Пакистан тэргүүтэй исламын шашинтай улс орнууд бага насны охидыг буюу 5, 7, 8 настай охидыг насанд хүрсэн эрэгтэйтэй гэрлүүлдэг уламжлал соёлоо бэхжүүлэн хадгалсан хэвээр байна.

Охин хүүхэдтэй болохыг хүсэхгүй байгаа хүмүүс, гар бүлүүд маш их байна. Эмэгтэй ураг учраас үр хөндүүлэх, охин төрсөнд нь сэтгэл хангалуун бус байх, охин хүүхэд төрүүлснээр нь эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах соёл, уламжлал хүчтэй хэвээр байна. Энэ соёл манай улсад ч гэсэн хүчин төгөлдөр оршсоор байгаа нь харамсалтай юм. Бидний сайн мэдэж байгаачлан дараалан 3 эрэгтэй хүүхэд төрүүлсэн эмэгтэйг “дархан бэр” хэмээн хүндэтгэн өргөмжилдөг бол дараалан 3 охин төрүүлсэн эмэгтэйг хэрхэн нэрийддэг билээ? Үүнээс гадна охидыг “эмэгтэй” учраас сургуульд сургахгүй байх, боловсрол эзэмших эрхийг нь зөрчих, хөвгүүдтэй адил тэгш боломжоор хангахгүй байгаа асуудлыг анхаарах хэрэгтэй. Тухайлбал, сургууль завсардсан нийт хүүхдүүдийн 70%-ийг охид эзэлж байна. Яагаад гэвэл охин учраас, эмэгтэй учраас сургуульд сурах шаардлагагүй, боловсрол эзэмших хэрэггүй гэсэн эмэгтэй хүйсийн хүнд хандах уламжлалт үзэл хандлага бат бөх байна. Охид бол гэр бүлдээ үйлчлэх, бусдад үйлчлэх, бусдын сайн сайхны төлөө үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй халамжит хүн юм гэдэг байр сууринаас дэлхий нийт охидыг харж байна. Түүнчлэн охидын эсрэг хүчирхийлэл, ялангуяа бэлгийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл газар авсан хэвээр байна. Үүнээс гадна эхийн эндэгдлийн дийлэнх хувийг буюу 18-аас доош насандаа хүүхэд төрүүлсэн охид эзэлж байгаа нь харамсалтай юм.

Хэдий тийм боловч 18 хүртэлх насны охидын эрхийг хамгаалах, тэдний эрхийг зөрчигдөхөөс сэргийлэх явдал нь эмэгтэйчүүдийн хөдөлгөөний адил өргөн цар хүрээтэй “хөдөлгөөн”-ий түвшинд хүрчээ. Охидын эрхийн тодорхой асуудлуудад тууштай чиглэсэн үйл ажиллагаа, компанит ажлууд болон нийгмийг өөрчлөх санаачлагууд дэлхийн хэмжээнд идэвхтэй өрнөж байна. Түүнчлэн энэхүү хөдөлгөөн нь охидыг хүчирхэгжүүлсэн, тэднийг уриалан дуудсан, утга учиртай оролцоог нь хангасан хөдөлгөөн болж чадаж байгаагаараа онцлог юм.

Харамсалтай нь ‘охидыг тусгайлан авч үзэх шаардлагагүй’, ‘охид бол хүүхэд эсвэл өсвөр насныхан хэмээх хүн амын бүлэгт харъяалагдахад л хангалттай’ гэх үзэл бодолтой шийдвэр гаргачид, хууль тогтоочид манай нийгэмд цөөнгүй байна. Өөрөөр хэлбэл охидын эрхийн асуудалд анхаарах, өөрчлөлт авчрах улс төрийн сонирхол бага байна гэж хэлэх үндэслэл байна.

Ийм учир охидын утга учиртай оролцоог хангасан хүчирхэг хөдөлгөөн өрнүүлж, дэлхийтэй хөл нийлүүлэн алхах, асуудлаа хэлэлцэх, шийдвэрлэх, өөрчлөлт бий болгох шаардлагатай байна. Эмэгтэйчүүдийн эрхийн асуудлуудыг насанд хүрсэн эмэгтэйчүүдтэй ярилцахаас илүүтэйгээр охидыг бага наснаас нь чадваржуулж, өөрийгөө хамгаалах, өөрөө хүчирхэг байх, өөрөө дуу хоолойгоо гаргах үйл явцад сургаж, охидыг зоригжуулах нь нэн чухал юм. Насанд хүрснийх нь дараа “чи өнөөдөр хүчирхэг байх ёстой”, “чи мэддэг байх ёстой” гэж ярихаас илүүтэйгээр бид 2, 3, 4, 5 наснаас нь эхлэн ярьж, ойлгуулж, хүчирхэгжүүлж, оролцуулж чадвал магадгүй өнөөдрийн эмэгтэйчүүдийн эрхийн асуудлыг арай өөр түвшинд яригдах болно.

Охидын манлайлал гэдэг бол маш том соёл юм. Бид өнөөдөр охидоо манлайлагч болгон өсгөж чадаж байгаа юу, охидоо хэн болгон хүмүүжүүлж байгаа вэ гэдэг асуудал асуултын тэмдэг хэвээр байна. Энэ салбарт байгаа эмэгтэйчүүд бид өөрсдөө охидоо хэрхэн ханддаг вэ? Эмэгтэй болохоор чи гэрээ цэвэрлэх ёстой, хоолоо хийх ёстой, гэр бүлээ халамжлах үүрэгтэй гэдэг утгаар бус амьдарч буй орчноо эмх цэгцтэй, цэвэр цэмцгэр байлгах, гэр бүлдээ анхаарах нь хувь хүний хариуцлага хийгээд амьдрах ухаанд суралцаж буй хэрэг юм гэдэг утгаар нь бид охидоо хүмүүжүүлэх хэрэгтэй юм. Бид юуны түрүүнд охидоо хандах хандлагаасаа эхлээд өөрчлөлтийг бий болгомоор байна.

## **Туршлага**

Дэлхийн хэмжээнд охидын эрхийн асуудал сүүлийн 10 орчим жилийн хугацаанд хурцаар хөндөгдөх болсон төдийгүй үүнтэй холбоотойгоор олон эерэг өөрчлөлтүүдийг бий болгосон. Тухайлбал 2012 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблей жил бүрийн 10-р сарын 11-нийг Олон Улсын Охидын Эрхийг Хамгаалах Өдөр болгон тунхагласан явдал нь охидын эрхийн хөдөлгөөнд бий болсон ололт амжилтуудын нэг юм. Ингэснээр охидод хөрөнгө оруулалт хийх замаар дэлхийн хүн амын ядуурлыг бууруулах боломжтой хэмээн үзсэн бөгөөд охидын эрхийг хамгаалах, тэдний оролцоог нэмэгдүүлэх, охидын эсрэг ялгаварлан гадуурхалтыг арилгах шаардлагатай болохыг улс орнуудад уриалсан юм. Түүнчлэн охидын эрхийг хамгаалах нь зөвхөн тухайн чиглэлээр ажилладаг байгууллага юмуу, эсхүл охидын эрх ноцтойгоор зөрчигдөж буй улс орнуудын асуудал биш юм. Охидын эрхийг хамгаалах нь бидэнд бүгдэд хамаатай төдийгүй бид бүгд хамтран анхаарлаа хандуулах ёстой асуудал юм.

Мөн түүнчлэн охидын эрхийг хамгаалах өдөр бол охидын аж амьдралыг сайжруулах, жендэрийн тэгш бус байдлыг арилгахын тулд бид юу хийв, цаашид юу хийсээр байх уу гэдгийг бүтэн жилийн турш эргэцүүлдэг өдөр юм.

Охидтой холбоотой зарим тоон мэдээлэл дурьдвал, манай улсын хувьд 0-18 насны охид нийт эмэгтэйчүүдийн 35%-ийг эзэлдэг байна. Өөрөөр хэлбэл охидын эрхийн асуудал нь хүн амын 560,000 – д хамаатай асуудал юм.

ЦЕГ-аас гаргасан мэдээллийн дагуу 2016 оны 8-р сарын байдлаар бэлгийн хүчирхийлэлд өртсөн нийт хохирогчдын 10%-ийг 0-18 насны охид эзэлж байгаа ба тэдний 56%-г өсвөр насны охид эзэлж байна. Гэвч энэхүү статистик тоо баримтыг бодитой гэж үзэхэд хэцүү. Учир нь хүчирхийлэлд өртсөн охид эрхээ хамгаалуулахын тулд цагдаагийн байгууллагад хандах ёстой гэдгийг мэдэхгүй байна, улмаар нуун дарагдуулж байна. Түүнчлэн хохирогч охид эрхээ хамгаалуулах эрхтэй юм байна, миний эрхийг

хамгаалдаг хүмүүс байдаг юм байна гэдгийг мэдэхгүйгээсээ болоод өөрийнхөө эрхийг хамгаалах алхмыг хийж чадахгүй байна. Цаашилбал бэлгийн хүчирхийлэлд өртөж буй охидын. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа нийт эмэгтэйчүүдийн 5%-ийг охид эзэлж байгаа. Охидын төрөлт мөн манай улсын анхаарал хандуулах ёстой асуудлуудын нэг байдаг бөгөөд сүүлийн жилүүдэд төрөлт нэмэгдэж буйтай холбоотойгоор өсвөр насны буюу 15-19 насны охидын төрөлт нэмэгдэх хандлагатай байна.

Монгол дахь охидын эрхийн хөдөлгөөн ямар түвшинд байна вэ? Бид ямар асуудалд гол төлөв анхаарч ажиллаж байна вэ?

Охидын эрхийг зөрчиж буй дараах асуудлуудад анхаарч ажиллаж байна гэж үзэхээр байна.

1. Бэлгийн хүчирхийлэл, түүний хэлбэрүүд (ураг төрлийн хүчин, гудамж талбайн хүчин, болзооны хүчин)
2. Охидын жирэмслэлт, төрөлт
3. Гэр бүлийн хүчирхийлэл
4. Хөгжих эрхийн асуудал буюу охид өөрөө өөртөө хөрөнгө оруулалт хийх асуудалд тодорхой түвшинд анхаарч ажиллаж байна.

Охидын эрхийн асуудлыг орчны хувьд дараах байдлаар анхаарч авч үзэж байна.

1. Сургуулийн орчин дахь охидын эрхийн асуудал
2. Гэр бүлийн орчин дахь охидын эрхийн асуудал
3. Олон нийтийн газар гэсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа.

Дараах хүн амын бүлэгт чиглэсэн үйл ажиллагааг явуулж байна.

1. Хүчирхийллийн хохирогч, даван туулагч охид
2. Өсвөр насны ээжүүд
3. Тусгай хэрэгцээ бүхий охид

Харин бид хөгжлийн бэрхшээлтэй охид, бэлгийн цөөнх болон үндэсний цөөнх охидын эрхийг хамгаалах чиглэлээр ажиллаж чадахгүй байна

Бидэнд чамлалтгүй ололт амжилтууд, хуримтлуулсан туршлага бий. Тухайлбал, охидын эрхийн асуудлыг нийгэм, олон нийт ойлгож эхэлж байна. Тодорхой зан үйлийн өөрчлөлтүүд бий болж, охид өөрөө өөрсдийгөө хамгаалах хэрэгтэй юм байна, хөдөлгөөнд өөрөө оролцож, дуу хоолойгоо хүргэх хэрэгтэй юм байна гэдэг ойлголт сууж эхэлж байгаад бид баяртай байгаа. Охидын эрхийн хөдөлгөөн дэх охидын оролцоо жилээс жилд нэмэгдэж байна. Хэдий тийм боловч **бодлогын өөрчлөлтийн хувьд бид дорвитой алхам хийж чадаагүй** хэвээр л байна. Түүнчлэн охидын **эрхийн хөдөлгөөн нь өргөн хүрээтэй, үндэсний хэмжээний, алсын хараатай, урт хугацааны стратегитай хөдөлгөөн болж өргөжөөгүй** байгаа төдийгүй санаачлага нь цөөн хэдэн иргэний нийгмийн байгууллагын түвшинд байна. **Хөдөлгөөний хамтын ажиллагаа нь байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааны түвшинд** л байна. Бидэнд хүрч ажиллаж чадахгүй байгаа орхигдуулсан олон асуудлууд байна. Түүнчлэн **охидын эрхийн асуудлаарх үндэсний хэмжээний суурь судалгаа, нарийвчлалтай, нотолгоонд суурилсан тоо баримт маш дутмаг байна.** Илүүтэйгээр бид өөрсдийн хуримтлуулсан туршлага, ажиглалт дээр суурилж ажиллаж байна. Охидын эрхийн асуудал нь олон нийт, түүнчлэн шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчдын анхаарлын төвд хүрч чадахгүй байна.



Үүнтэй холбоотойгоор охидын эрхийг хамгаалах асуудлууд бодлого, хөтөлбөрт тусгагдаагүй байгаагаас дорвитой бодлогын өөрчлөлт хийж чадаагүй байна.

## **НИЙГМИЙН ОРХИГДСОН БҮЛГИЙН ЭМЭГТЭЙЧҮҮД БА ЭРХ МЭДЭЛЖҮҮЛЭЛТ**

### *Б. Чулуундолгор Тэргэнцэртэй иргэдийн Үндэсний холбооны Тэргүүн*

Бидэнд тулгамдаж байна асуудлыг 3 хэсэгт хувааж авч үзлээ.

#### **Асуудал 1.**

Нийгмийн үйлчилгээнд ижил тэгш хамрагдаж чадахгүй байна. Тухайлбал:

- Шилжин суурьшигчид-Бичигбаримтын зөрчил, аюулгүй орон гэрт амьдрах
- Казак, цаатан, тува эмэгтэйчүүд-Үндэсний цөөнхд хандсан мэдээлэл, соёлын үйлчилгээ байхгүй буюу эрүүл мэнд, боловсрол, хувь хүний хөгжилд чиглэсэн үйлчилгээнүүдийг уугуул хэл дээрээ авч чадж чадахгүй багагүй..
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд- Нийтийн тээвэр, барилга байгууламжийн хүртээмж, тэгш хамрагдах, мэдээллээр хангагдах мэдээлэл авах бэрхшээл.

#### **Асуудал 2.**

Оролцоо

- Гэр бүлийн харилцаанд хамтын шийдвэр гаргах эрхтэй оролцож чаддаггүй
  - 1) *Ажилгүй орлогогүй байх нь эмэгтэйчүүдийн гэр бүл дэхь эрх мэдлийг багасгадаг*
  - 2) *Эрх мэдэлгүй, орлогогүй байгаа нь өөрөө бие дааж шийдвэр гаргах, бие дааж бусадтай харилцах, өөрийн хүрээллийг бий болгох боломжийг нь хаадаг*
- Боловсролын болон хэлний соёлын ялгаанаас хамаарч тулгамдаж буй асуудлаа бусдад ойлгуулах илэрхийлэх боломж, чадвар сул
  - 3) Ялгаварлан гадуурхалтанд өртөх, олон нийтийн газар үг хэлээр дайрч дормжлуулах
  - 4) Ажил олгогчид болон зарим хүмүүс хүндэтгэлгүй харьцах, дорд үзсэн хандлага Хэлний бэрхшээлээс хамааран эрүүл мэнд болон бусад нийгмийн үйлчилгээг бүрэн дүүрэн авч чаддаггүй
- Улс төрийн болон шийдвэр гаргах түвшний оролцоо бараг байхгүй
  - 5) Их дээд, сургуульд элсэн суралцах, хангалттай боловсрол эзэмших боломж бага
  - 6) Хөгжлийн бэрхшээлтэй тэр дундаа хараа, сонсголын бэрхшээлтэй хүмүүс чанартай боловсрол эзэмших сургалтын орчин, зохицуулалт байдаггүй

### Асуудал 3.

#### Хандлага

- Олон нийтийн хандлага – Орлого багатай тул нийгмийн дундаж болон түүнээс дээш давхаргын эмэгтэйчүүдтэй ижил түвшинд харагдаж чаддаггүй
- Хангалттай эмэгтэйлэг харагдаж чаддаггүй -Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бие эрхтний гэмтэл, өөрчлөлт буюу хүний ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч чадахгүй байгаа олон нийтийн хандлага
- Хэл соёлын ялгааг хүлээн зөвшөөрөхгүй байх -Казак, цаатан, тува, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг нийгмийн харилцаанд оролцогч субъект гэхээсээ илүү халамж хүртэгч объект гэж хардаг. –Хэт халамжилсан нийгмийн хамгааллын бодлого нь хөгжлийн бэрхшээлтэй Эмэгтэйчүүдийн идэвхи, санаачлага, оролцоог багасгадаг.
- Эмэгтэйчүүд өөртөө итгэлгүй, идэвхгүй – Зорилго тэмүүлэлгүй, урсгалаар хүлцэнгүй амьдрах

#### Юуг хийвэл асуудал сайжрах вэ?

- Охид эмэгтэйчүүдийг хүртээмжтэй мэдээллээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх /брайль, аудио, казак, тува, цаатан хэл дээр эсвэл тэдний соёлын онцлогт нийцсэн/
- Хувьхүний хөгжлийг дэмжсэн сургалт, олон нийтийн арга хэмжээг шилжин суурьшигчид, үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглүүлэх
- Шилдэг байгууллага, TOP аж ахуйн нэгж, онцлох хүн гэх мэт оны шилдэгүүдийг шалгаруулахдаа нэг шалгуур нь хөгжлийн бэрхшээлтэй, шилжин суурьшигч, үндэсний цөөнх эмэгтэйчүүдэд ажлын байр үүсгэсэн, эсвэл тэдэнд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулсан байх
- Магистр, докторын зэрэг горилогчдын судалгааны сэдэв дээрх зорилтот бүлгийн эмэгтэйчүүд рүү чиглэсэн байвал илүү өндөр оноотой өгч байх зохицуулалтыг хийх
- Хөгжлийн бэрхшээлтэй, шилжин суурьшигч, үндэсний цөөнх эмэгтэйчүүдийг орлоготой болох, хөдөлмөр эрхлэх боломжийг нь дэмжсэн бодлого, хөтөлбөрийг тусгайлан бий болгох
- Асуудал нь орхигдсон бүлгүүдийн эмэгтэйчүүдэд зориулсан “Эмэгтэйчүүдийн хөгжлийн төв”-ийг бий олгох. Төв нь
  - Эмэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудлуудаар судалгаа хийдэг,
  - Олон нийтийн анхаарлыг эмэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудал руу хандуулах сурталчилгаа, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлдэг
  - Хэл соёлын ялгаатай эмэгтэйчүүдийн онцлогт тохирсон мэдээллийн үйлчилгээг үзүүлж, хүртээмжтэй гарын авлага материалаар хангах үйлчилгээг хүргэдэг
  - Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, өмгөөлөлийн үйлчилгээ үзүүлэх, хамгаалах байраар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байх

**Энэ бүлгийн эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэхийн тулд**



**БЭЛГИЙН ЦӨӨНХИЙН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХҮНИЙ ЭРХ**

*Д. Мөнхнасан-“Саяанаа Сайн Сайхны Нийгэмлэг”ТББ-ын Гүйцэтгэх Захирал*

Би илтгэлээ хүний эрхийн асуудлын талаас хөндөж, хүний эрхийн асуудлыг Хүний эрхийн түгээмэл Тунхаглал болон Үндсэн хуульд юу гэж заасан талаар дахин нэг хөндөх асуудлаас эхэлье.

Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүсийн ёсоор харилцах ёстой. /Хүний эрхийн Түгээмэл тунхаглалын нэгдүгээр зүйл/ Хүний эрх бол таныг хүний зэрэгтэй амьдрахад шаардагдах наад захын баталгаа юм. Хүмүүс ихэнхдээ амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрлөх зэрэг эрхийг л мэддэг. Гэтэл үнэндээ эдгээрээс гадна маш олон эрхийг хуулиар баталгаажуулсан.

Энэ нь хүн бүрт хамааралтай. Өөрөөр хэлбэл, хүн бүр ямар ч ялгаваргүйгээр эрх, эрх чөлөөгөө эдлэх ёстой. Хүний эрх түгээмэл учраас дэлхийн хаана ч ижил дээдлэгдэх учиртай.

**Үндсэн хуульд:** Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүй этгээд байна гэж заасан байдаг.

Тэгэхээр **бэлгийн цөөнхийн эмэгтэйчүүдийн эрх хэрхэн хангагдаж байна вэ?** 1990-ээд онд бэлгийн цөөнхийн асуудлаар ярьдаг хүмүүс цөөхөн байсан бол өнөөдөр ЛГБТИ активистуудаас авахуулаад зарим улс төрчид, залуу эрдэмтэд, иргэний нийгэм, оюутан залуус гээд олон талаас нь хэлэлцдэг болсон нь өнгөрсөн 20 жилийн хугацаанд өрнөж байна. Бид нийгмийн энэ асуудлыг харилцан ярилцаж байж нэгдсэн нэг мөр ойлголтонд хүрнэ. Энэ бол хөгжилд хүрэхэд зайлшгүй туулах үйл явц юм. Үүний зэрэгцээ эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш эрх, гэр бүлийн хүчирхийлэл гээд олон асуудалд хамтран дуу хоолойгоо илэрхийлж оролцох шаардлага гарч байна.

**Саянаа Сайн Сайхны Нийгэмлэг ТББ** хэрхэн байгуулсан асуудлаар хөндөж ярьяа. 2014 онд үүсгэн байгуулагдсан. 2 үүсгэн байгуулагчтай.

### **Байгууллага үүсгэн байгуулах шалтгаан юу байв?**

**Асуудал:** Дэлхий нийтийн чиг хандлагыг харахад өмнө нь эрэгтэй эмэгтэй хамаагүй бэлгийн цөөнхийн асуудлыг ярьдаг байсан. Энэ дундаасаа ЛБТ \Лесбиян, Бисексуал, Трансжендэр\ эмэгтэйчүүд илүү их ялгаварлан гадуурхалтад өртөөд байгаа, эмзэг байдалд орчихсон, ажилгүйдэл, ядууралд өртсөн. Иймээс эмэгтэйчүүдийн асуудалд илүү анхаарах ёстой юм байна гэдэг үүднээс байгуулахаар шийдсэн.

**Бэрхшээл:** Бичиг баримт авахаас авахуулаад бэрхшээл гарч байсан. Охид эмэгтэйчүүдийн эрхийн төлөө үйлчилнэ гэж авч байсан.

**Амжилт:** Хүний эрхийн форумын гишүүн болж хүний эрхийн хэрэгжилтийн асуудлаар НҮБ-ын Хүний эрхийн хорооны өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр сүүдэр илтгэлийг бичихэд оролцосон

**Ялгаварлан гадуурхалт:** Энэ асуудалд анхаарлаа хандуулахгүй бол болохгүй байна. Ялгаварлан гадуурхалт нь энгийн наад захын харилцаанаас эхлээд байдаг. Далд болон ил хэлбэрээр, бие болон сэтгэлзүйн дарамт, үг хэлээр гутаан доромжлох зэрэг хэлбэрээр явагдаж байгаа.

**Эмэгтэйчүүдийн хөдөлгөөн дэх оролцоо:** Иргэний нийгмийн байгууллагууд, хүний эрхийн төрийн бус байгууллагууд, эмэгтэйчүүдийн хүний эрхийн байгууллагуудтай нилээд өргөн хамтын ажиллагаатай явж ирсэн. Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнтэй нэгдэх, хамтрах шалтгаан нь юу байсан бэ гэхээр эдгээр хөдөлгөөнд нэгдэж өөрсдийн дуу хоолойгоо илэрхийлж, гадаад харилцаагаа өргөжүүлэх, гадны доноруудтай холбогдоход боломж олгож байдаг.

**Бэлгийн цөөнх эмэгтэйчүүдийн эрх хангагдаж байна вэ:** Хүн болж төрсөн учраас эрхээ хамгаалуулах ёстой. Зөвхөн суурь эрхүүд болох сурч боловсрох эрх, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, хөдөлмөрлөх эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь хэрхэн хангагдаж байна вэ?

**Лесбиян эмэгтэйчүүдийн хувьд** энэ үндсэн 4 эрх нь өөрөө бэлгийн баримжаагаа илэрхийлэхгүй бол аливаа нэг ялгаварлан гадуурхалтад өртөхгүй байх боломжтой. Хэрвээ илэрхийлсэн тохиолдолд ялгаварлан гадуурхалтад өртөж, эрх нь зөрчигдөж байна. **Трансжендэр хүмүүсийн** хувьд суурь эрх нь хангагдахгүй байна. Өнөөдөр сурч боловсорсон хүн байхгүй, эрүүл аюулгүй орчинд амьдарч чадахгүй. Тэр ч бүү хэл гэр орондоо амьдарч чадахгүй байна. Ураг төрлийн холбоо тасарч байна. Гадна харагдах байдлаасаа болоод хөдөлмөр эрхлэх ямарч боломжгүй болж байна. Хууль эрх зүйн талаас авч үзвэл Монголд ялгаварлан гадуурхсан хууль тогтоомж байхгүй. Мөн дэмжсэн ч хууль байхгүй. Хүн болж төрснийхээ хувьд эрхээ эдлэх, хамгаалуулах, шаардах эрхтэй.

Бид дараахь асуудалд анхаарах хэрэгтэй байна. Үүнд:

- 1) Монголын хүн ам дахь ЛБТ эмэгтэйчүүдийн тоо хэмжээ чухал биш, харин тэдний иргэн хүний хувьд ямар орчинд амьдарч байгааг бодитоор авч хэлэлцэх нь чухал;

- 2) ЛБТ эмэгтэйчүүдийг нийгэмд хүлээн зөвшөөрөх эсэх талаар маргах биш, ЛБТ эмэгтэйчүүдийн эрхийг хангаснаар бид эв нэгдэл, зэрэгцэн оршихуйд үндэслэн хамтдаа хөгжих асуудлыг ярилцах нь чухал;
- 3) ЛБТ эмэгтэйчүүдийн асуудал Монголд гэнэт саяхан гарч ирсэн асуудал бус, хөгжлийн энэ үе шатанд ЛБТ олон нийт өөрсдийн дуу хоолойг илэрхийлэх боломж бололцоо бүрдсэн нь төр засаг, нийгэм энэ тал дээр анхаарлаа хандуулах цаг болсныг харуулж байгаа юм. 20 жилийн өмнөхтэй харьцуулахад ахиц дэвшил гарсан ч, цаашид хийх, шийдвэрлүүлэх ажил их байна.

Өнөөдөр бид энд чуулж ЛБТ буюу бэлгийн цөөнхийн эмэгтэйчүүдийн талаар ярилцсанаар үнэн зөв мэдээлэлтэй, эерэг хандлагатай болоосой гэж хүсч байна. Цаашид шинэлэг байдлаар хамтран ажиллах үндэс суурь тавигдах гэсэн хүлээлттэй байна.

## САЛБАР ХУРАЛДААНЫ ДҮГНЭЛТҮҮД: ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

### 1) Жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт –Салбар хуралдааны дүгнэлт

*Чиглүүлэгчид: С.Дондов, Д.Мөнхнасан*

Жендэрт суурилсан хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалтын асуудлаар өөрчлөгдөж байгаа орчинд шинэ сорилтыг хэрхэн шинэ боломж болгох талаар бидэнд зайлшгүй хэрэгтэй шинэ арга барил, туршлага, хандлага, мэдлэг, ур чадварыг гарган санал болгоход бэлтгэсэн танилцуулга, салбар хуралдааны зорилго чиглэгдэж байв.

Энэ ажлын хүрээнд нэгдсэн хуралдаанд жендэрт суурилсан хүчирхийлэлийг бууруулах, таслан зогсооход зайлшгүй анхаарвал зохих асуудлыг хөндсөн танилцуулга бэлтгэж танилцуулла. Мөн жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтын асуудлаар салбар хуралдаанд идэвхжүүлэгчээр ажиллав. Манай салбар хуралдаанд УБ хотын болон орон нутгийн 18 оролцогч оролцсон. Салбар хуралдаанд оролцогчдын оролцоог хангах зорилгоор багт хуваагдан бүлгээр ажиллаж урьдчилан бэлтгэсэн бүлгийн ажлын зааварчилгааг танилцуулж баг тус бүр 25 минут багаар ажиллаж оролцогч бүр санаагаа гаргаж хүн бүрийн оролцоог ханган ажилласны дараа баг бүр өөрсдийн төлөөлөө сонгож 5 минутын танилцуулга тавьж багуудын танилцуулгыг нэгтгэн дүгнэж ажиллаа.

Бидний бүлгийн ажлын танилцуулга дараах агуулгатай байсан.

Өнөө үед ЖСХ-лэл болон ялгаварлан гадуурхах явдал нэмэгдэж байна уу? буурч байна уу? Гэсэн ерөнхий дүр зургийг гарган төсөөлөхийг оролцогчдоос хүссэн.

1. Нэмэгдэж байгаа бол асуудлын суурь шалтгаан юу? Нөлөөлөгч хүчин зүйл болон сөрөг үр дагавруудыг нэрлэнэ үү?
2. Энэ асуудлыг өргөн хүрээнд харвал хэний эрх ашгийг хөндөж байна вэ?
3. Энэ асуудлыг шийдвэрлэх үүрэг хүлээсэн хүмүүс байгууллага хэн бэ?
4. Өнөөдрийг хүртэл ИНБ-ын зүгээс ЖСХ-ийг багасгах чиглэлээр хийсэн ажлуудын ололттой болон сул талуудыг дүгнэн гаргана уу?
5. Дээрхи дүн шинжилгээнд үндэслэн ЖСХ-ийг бууруулах таслан зогсоох, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хамгийн үр дүнтэй аргуудыг тодорхойлон гаргаж ирэх зорилготой байлаа.

Нийт оролцогчид 3 багт хуваагдан ажилласан. 1 багт 6 хүн оролцсон болно.

Багууд маш нухацтай ажиллаж асуудлыг гаргаж ирэхэд хүн бүрийн идэвхтэй оролцоог хангаж анхааралтай ажиллаа. Жендэрт суурилсан хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалтыг бууруулах таслан зогсооход анхаарах асуудлуудыг багууд гаргаж ирсэн. Үүнд:

- Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг бууруулах улмаар зогсооход нэн түрүүнд тогтолцоог бий болгох жендерийн үндэсний хороо болон тахарын албыг татан буулгасан нь ЖСХ-ийн гэрч хохирогчийн эрх зүйн байдлыг дордуулсан үйл ажиллагаа болсныг



эргэн харж анхаарал хандуулах шаардлагатай. Ерөнхий сайдын дэргэдэх Жендерийн Үндэсний Хороог өөрчлөн цомхтгож нэг яамны дэргэд хүн хүчээр дутмаг ажлын алба болгон ажлуулж байгаа нь тогтолцоог бий болгох ажлыг сайжруулахад сөрөг үр дагавар бий болгож хүний эрхийн байдлыг улам дордуулсан үйл ажиллагаа болж байна гэж дүгнэв.

- ЖСХ, Ялгаварлан гадуурхалтанд өртсөн охид эмэгтэйчүүд гомдол гаргаж холбогдох байгууллагуудад хандах болоход ажлын газар тэр бүр ойлгодоггүй чөлөө зав муутай байдгаас цаг хугацааны хувьд алдагдаж гомдлоо шийдвэрлүүлж чаддаггүй иймд хүчирхийлэлд өртсөн хүнд ажлаас нь чөлөө олгож, нууцлалыг нь хангадаг байх шаардлагыг тусгасан дүрэм журам байгууллагуудад хэрэгтэй байна.
- Батлагдсан хууль, олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн зөвлөмжүүд хэрэгжихгүй байгаа нь том ухралт болж байна. Иймд эдгээр хууль, зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх тал дээр тусгайлан анхаарах шаардлагатай байна.
- Нэн даруй шинэ хөдөлмөрийн хуулийг батлуулах ингэхдээ АББД-с урьдчилан сэргийлсэн заалт, зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээг тодорхой болгож, аж нэгж байгууллагын гүйцэтгэх үүргийг өндөржүүлсэн заалт оруулах
- Төрийн албанд болон хувийн хэвшилд ажилд орох гэж буй хүмүүсийн шалгуурт ЖСХ, ялгаварлан гадуурхалтын талаархи мэдлэгтэй эсэхийг харгалзан үзэх шаардлагатай.
- Ялгаварлан гадуурхалтын асуудлаар бие даасан судалгаа хийж ямар түвшинд байгааг богино хугацаанд илрүүлэн гаргах
- ЛБТ хүмүүсийн онцлог хэрэгцээнд тулгуурлан сургалт мэдээллийг тогтмол хийх, ялгаварлан гадуурхалтын талаархи олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлж зөв ойлголтыг төлөвшүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлтийг хийлээ.

## **2) Шийдвэр гаргах түвшин дэхь эмэгтэйчүүдийн оролцоо-Салбар хуралдааны дүгнэлт**

*Чиглүүлэгч: М.Дуламжав*

Эмэгтэйчүүд / бид / улс төрд яаж үр дүнтэй оролцох бэ? Улс төрд үр дүнтэй оролцоноор шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх ямар боломж, шинэ арга зам байна? Үүний тулд бид хэрхэн хамтарч ажиллах бэ? Хэнд, ямар туршлага байна гэдэг талаар салбар хуралдааны хэлэлцүүлгээр ярилцаж 20 гаруй эмэгтэйчүүд санал бодлоо хуваалцаж дараах шийдэлд хүрлээ. Үүнд:

Нэг: Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх боломж:

- Эмэгтэйчүүдийн байгуулага, хөдөлгөөнүүдийн үндэсний хэмжээний сүлжээ байгуулж ажиллах
- Лидер эмэгтэйчүүдийн зөвлөлдөх уулзалт зохион байгуулах
- Эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, төрийн бус байгууллагуудын цахим уулзалтуудыг зохион байгуулах
- Сэтгүүлчдийн оролцоог нэмэгдүүлэх
- Залуу эмэгтэйчүүдийг нийгэмд таниулж, бэлдэх
- Эмэгтэйчүүд, эмэгтэйчүүдээ дэмждэг гэдэг мессежийг нийгэмд хүргэх

- Эмэгтэйчүүдийн чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх

Хоёр: Эрх зүйн шинэтгэлийн чиглэлээр дуу хоолойгоо өргөх

- Сонгуулийн хуулинд өөрчлөлт оруулах санал боловсруулан дуу хоолойгоо хүргэх / Квотыг 30 болгох, орон нутгийн сонгуульд квот оруулах, УИХ, орон нутгийн сонгуулийг салгах, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх заалт оруулах г.м /
- Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр санаачилж батлуулах ажлыг зохион байгуулах
- Сонгогчдын боловсролыг дээшлүүлэхэд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, хамтран ажиллах

Гурав: Улс төрийн намын шинэчлэлд идэвхтэй оролцох

- Дүрмийн шинэчлэл, улс төрийн соёл бүрдүүлэхэд эмэгтэйчүүд манлайлж оролцох
- Намуудын дэргэдэх / ахмад, эмэгтэйчүүд, залуучууд /-тай хамтран ажиллах
- Намын харьяалалаар намайг битгий хараач хөдөлгөөн өрнүүлэх
- Эмэгтэйчүүд нам дотроо байр суурь эзлэх, өөрийгөө таниулах

Дөрөв: Төрийн үйл ажиллагаанд хяналт тавих оролцоо

- Иргэний хуулиудын хэрэгжилтийг үнэлэх, зөвлөх
- Ил тод байдлын судалгаа хийх, дүгнэлт гаргах
- Ажлын хэсэг, хороо зөвлөлд ажиллаж, мэдээлэл авах, дуу хоолойгоо гаргах
- Жендэрийн хөтөлбөрт үнэлгээ хийж, хуулийн хэрэгжилтийг хүчтэй шаардах

Дүгнэлт:

1. Эрх мэдлийг хэрэгжүүлэгч нь зөвхөн төр биш. Иргэд ашиг сонирхлоо илэрхийлэн дуу хоолой хүчээ нэгтгэж, хөдөлж шаардсанаар эрхээ эдэлж, эрх мэдлээ хэрэгжүүлэх боломжтой.
2. Зөвхөн сонгогдох томилогдох биш улс төрийн оролцоонд иргэдийн / бидний / идэвхтэй оролцоо дуу хоолой чухал гэдэгтэй санал нэгдлээ
3. Иргэний нийгмийн байгуулагуудын хамтын ажиллагаа, эв нэгдэл, нэгдсэн зорилго зорилт чухал гэж үзлээ.
4. Өөрсдийн төлөөлөлийг өөрсдийн оролцоотой улс төрд оруулах, шийдвэр гаргах түвшинд ажиллуулах хэрэгцээ шаардлага улам бүр нэмэгдэж байна гэж үзлээ.

Бид / эмэгтэйчүүд / улс төрийн, эдийн засгийн, төсөв санхүүгийн, хуулийн, иргэний эрхийн талаарх чадавхаа сайжруулах шаардлагатай

### 3) “ОХИД, ЗАЛУУ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ” салбар хуралдааны дүгнэлт

Чиглүүлэгч: Ч.Ундрах

Хуралдаанд МОНЭС-гаас тэтгэлэг авагч, эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эмэгтэйчүүдийн бүлгүүд, ТББ-уудын төлөөлөл болсон 30 орчим оролцогчид (100%

эмэгтэйчүүд) оролцож охид, залуу эмэгтэйчүүдэд тулгамдаж буй бэрхшээлтэй асуудлууд болон цаашид шийдвэрлэх шинэлэг гарцуудыг хамтдаа эрэлхийллээ.

Салбар хуралдааны гол зорилго нь Монгол дахь охидын эрхийн өнөөгийн байдалд чуулганы төлөөлөгчдийн оролцоотойгоор дүн шинжилгээ хийхийн сацуу нэн тэргүүний анхаарч ажиллах шаардлагатай охидын эрхийг зөрчиж буй асуудлуудыг хамтдаа тодорхойлохыг эрмэлзсэн. Түүнчлэн охидыг хүчирхэгжүүлж, охидын дуу хоолойг чангатгаж тэдний утга учиртай оролцоог хангах замаар эрхийг нь хамгаалах үйл хэрэгт нэн шинэ хандлага, шинэлэг арга барил, академик мэдлэг болон практик туршлагыг ашиглан охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг байгууллага, бүлгүүд хэрхэн хамтарч ажиллах боломж байгааг эрэлхийлсэн. Үүнээс гадна олон улсын болон дотоодын сайн туршлагыг хуваалцаж, түүнээс хамтдаа суралцаж, цаашид хэрхэн түгээн дэлгэрүүлэх арга замын талаар нээлттэй хэлэлцэхийг зорьж ажилласан. Тухайлбал, охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийн хүрээнд олон нийтийн анхаарал, хэлэлцүүлгийн төвд байдаг хэдий ч төдийлөн ахиц, дэвшил гарахгүй байгаа нийгмийн асуудлуудыг хамтдаа олж харахыг хичээсэн болно.

Салбар хуралдааны чиглүүлэгчээр Охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах “ГҮНЖ” төвийн Үүсгэн байгуулагч Ч. Ундрах ажиллалаа.

### **ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ**

ОХИД, ЗАЛУУ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ салбар хуралдаанаар дараах 3-н асуудлын хүрээнд нээлттэй хэлэлцүүлэг өрнүүллээ.

- Охид, залуу эмэгтэйчүүдэд тулгамдаж буй бэрхшээлтэй асуудлууд
- Охид, залуу эмэгтэйчүүдэд тулгамдаж буй бэрхшээлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд эерэг нөлөө үзүүлэхүйц, амжилт гаргасан тэргүүн туршлага
- Шинэ санаа, шинэлэг аргачлалд суурилсан асуудлыг шийдвэрлэх бодит арга зам

Охид, залуу эмэгтэйчүүдэд тулгамдаж буй бэрхшээлтэй асуудлуудыг салбар хуралдаанд оролцогчдын утга учиртай оролцоонд тулгуурлан гаргаж ирэхийн тулд бүлгээр, өртөөчилсөн байдлаар ажиллалаа. Ингэснээр бүх оролцогчдын саналыг тусгах боломжтой болсон юм. Хэлэлцүүлгийн үр дүнд дараах асуудлуудыг охид, залуу эмэгтэйчүүдийн насны бүлэгт тулгуурлан гаргаж ирсэн.

- **0-10 насны охидод тулгамдаж буй асуудлууд**

Энэхүү насны бүлгийн охидын эрхийн асуудлуудыг хэлэлцэхдээ 0-5 нас буюу сургуулийн өмнөх нас, 6-10 нас буюу сургуулийн нас гэсэн 2 ангилалаар авч үзсэн.

Хуралдаанд оролцогчид 0-5 насны охидыг ХҮЙСЭЭР ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ хандлага нийгэм, олон нийтийн дунд түгээмэл байна гэж үзсэн. Тухайлбал, эрэгтэй хүүхдийг илүүд үзэх, олон эрэгтэй хүүхэд төрүүлсэн эмэгтэйг илүүд үзэх, дэвшилтэт бус үзэл санаа, хандлагад суурилсан охидыг хүмүүжүүлэх арга барил эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгч нарын дунд түгээмэл байна гэж үзсэн.

Сургуулийн бага ангийн буюу 6-10 насны охидыг хүйсээс нь хамаарч ялгаатай үүрэг хүлээлгэх, үнэлэмж багатай гэрийн хөдөлмөр эрхлүүлэх байдлаар хөгжих эрхийг нь зөрчих явдал нийтлэг байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй, дотуур байранд амьдарч буй, хараа хяналтгүй, гэр оронгүй, асран

хамгаалах насанд хүрсэн хүнгүй охидын эрхийг хамгаалах, тэдэнд чиглэсэн дэмжлэг туслалцаа үзүүлэх, тэднийг чадавхижуулах үйл ажиллагаа бүхэлдээ орхигдсон байна. Цаашлаад бага насны охидыг хүчирхийлэх явдал хүрээгээ тэлж байгаад онцгой анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байгааг хэлэлцсэн.

### **10-19 насны буюу өсвөр насны охидод тулгамдаж буй бэрхшээлтэй асуудлууд**

Өсвөр насны охидын бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн асуудлууд санаа зовоосон хэвээр байна. Тухайлбал, эрт жирэмслэлт, төрөлт, үр хөндөлт, бэлгийн замаар дамжих халдвар гэх мэт бэлгийн эрүүл мэндтэй холбоотой асуудлууд газар зүйн байршлаас үл шалтгаалан нийтлэг хэвээр байна. Түүнчлэн сургуулийн болон цахим орчин дахь охидын эсрэг үе тэнгийн дарамт сүүлийн жилүүдэд газар авч байгааг хуралдаанд оролцогчид онцолсон. Үүнээс гадна охид сонгох эрхээ чөлөөтэй эдэлж чадахгүй байна. Тухайлбал, ЕБС-ийн хөдөлмөрийн хичээл хүйсийн ялгаатай ордог (*охид, хөвгүүд тусдаа хичээллэдэг бөгөөд хүйсээс шалтгаалан өөр өөр зүйл хийж сурахыг заадаг нь жендэрийн уламжлалт үзэл хандлагыг боловсролын тогтолцоо, хичээлийн хөтөлбөрөөр дамжуулан бэхжүүлж байна гэж үзэж болно*), мэргэжил сонгох үйл явц дийлэнх тохиолдолд эцэг эхээс шууд хамааралтай байдаг бөгөөд цэргийн, цагдаагийн гэх мэт мэргэжил сонгох нь охидод бэрхшээлтэй, хаалттай байдаг.

### **Залуу эмэгтэйчүүд (20-35 нас)**

Энэ насны залуу эмэгтэйчүүд нь нөхөн үржихүйн үйл явцад идэвхитэй оролцдог насны эмэгтэйчүүд байдагтай холбоотойгоор бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн асуудлууд, тэр тусмаа жирэмслэлт, төрөлттэй холбоотой асуудлуудыг оролцогчид түлхүү хөндөж байлаа. Жирэмсний хяналтын үйлчилгээг чанаржуулах, хүүхэд төрүүлэх үйл явцыг эхэд ээлтэй болгох асуудлууд бүхэлдээ ахиц дэвшилгүй байна гэж үзсэн. Үүнтэй холбоотойгоор залуу эмэгтэйчүүд, залуу хосуудад чиглэсэн гэр бүлийн боловсрол олгох, эцэг эх байх тухай боловсрол олгох тогтолцоо манай улсад дутагдалтай байна. Мөн түүнчлэн 20-35 насны залуу эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх эрх нь ажлын байранд тавигдах шалгууртай холбоотойгоор зөрчигдөж байна гэж үзсэн. Тухайлбал, хүүхэд төрүүлсэн, тодорхой хугацаанд хүүхдээ гэртээ асарсан эмэгтэйчүүдэд ээлтэй ажлын байрны шалгуур алга байна. Үүнээс гадна залуу эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт ба төрөлттэй уялдуулсан ээлтэй бодлого, тогтолцоо шаардлагатай байгааг оролцогчид онцолсон. Хүүхдээ бие даан өсгөж буй залуу эмэгтэйчүүд (*өрх толгойлсон эмэгтэйчүүд*)-эд чиглэсэн дэмжлэгийн тогтолцоо дутагдалтай байна.

### **ШИНЭ САНАА ба ШИЙДЭЛ**

Охид, залуу эмэгтэйчүүдэд тулгамдаж буй дээрх асуудлуудаас гарах үр дүнтэй, шинэлэг арга замуудыг эрэлхийлэхдээ оролцогчдыг өөрийн хувь хүний, байгууллагын болон олон нийтийн нөөц боломж, чадавхид тулгуурлан эргэцүүлэхийг хүссэн. Ингэснээр хэн нэгэн хувь хүн, эсхүл байгууллага асуудлыг нааштайгаар өөрчлөхөд оролцох бус хуралдаанд оролцогчдын өөрсдийн оролцоог идэвхижүүлэхийг эрмэлзсэн.

Дараах шийдлүүд байгааг олж харсан.

- Охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар үндэсний хэмжээний суурь судалгаа (чанарын болон тоон) хийгдэх шаардлагатай байна.

- Охидод хандах нийгэм, олон нийтийн хандлагыг өөрчлөх тууштай, урт хугацааны стратегитэй үйл ажиллагаа (кампанит ажил) явуулах нэн хэрэгтэй байна. Туайлбал, ЕБС-ийн хичээлийн хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэй болгох чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаа явуулж, охидод ялгаваргүй ханддаг боловсролын тогтолцоог бий болгох нь чухал юм.
- Охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дотоодын болон гадаадын байгууллагуудын хуримтлуулсан сайн туршлагаас суралцаж, санаачлагыг үргэлжлүүлж ажиллахад анхаарах хэрэгцээтэй байна.
- Аль нэг байгууллага, бүлгийн гаргасан санаачлагыг дэмжиж, амжилттай хамтын ажиллагааг бий болгох нь нэн чухал юм.
- Охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр бодлогын нөлөөлөл хийхэд анхаарч ажиллах нэн шаардлага байна.

Дараах хэд хэдэн дэд шийдлүүдийн талаар хуралдаанд оролцогчид хэлэлсэн.

### МАНЛАЙЛАЛ

- Охидын манлайллыг хөгжүүлэх
- Залуу эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих
- Охидод зөв үлгэр дууриалал болсон эмэгтэйчүүдийн дүр төрх, түүхийг бий болгох, бүтээх
- Эхчүүдийн манлайллыг хөгжүүлэх асуудлаар ажиллаж, тэдний оролцоотойгоор ээлтэй эрх зүйн орчин бүхий дэмжлэгт тогтолцоог бий болгоход нөлөөлж ажиллах
- Охид, залуу эмэгтэйчүүдийн өөрсдийг нь идэвхижүүлж, оролцоог нь нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах

### ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ МЭДЛЭГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, ХАНДЛАГЫГ ӨӨРЧЛӨХ

- Эцэг эхчүүд болон багш нарын охидын эрхийн талаарх ойлголтыг нэмэгдүүлж, охидод ээлтэй, эрхийг нь дээдэлсэн, онцлог хэрэгцээг нь ойлгож хүндэтгэсэн хандлагыг төлөвшүүлэхэд анхаарч ажиллах
- Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэй болгоход нөлөөлөх замаар охидод ээлтэй болгох
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сэтгүүлчдийн хандлагыг өөрчлөх, дэвшилтэт үзэл санаатай болгоход түлхүү анхаарч ажиллах
- Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх

### ШИНЭЛЭГ АРГАЧЛАЛ

- Дэвшилтэт үзэл санаа, агуулга бүхий охидод зориулсан сэтгүүл гаргаж орон даяар түгээх
- Урлагт суурилсан аргачлалыг түлхүү ашиглах
- Дэлгэцийн урлагт охидын дүрийг эерэг болгох чиглэлээр ажиллаж, дэлгэцийн бүтээл туурвих
- Дэвшилтэт үзэл санаа бүхий телевиз, радиогийн нэвтрүүлэг бэлтгэж охидод хүргэх
- Уран бүтээлчид болон урлагийн байгууллагуудыг татан оролцуулах, нөлөөлөх

ЧАДАВХИ НЭМЭГДҮҮЛЭХ, ОЙЛГОЛТОО НЭГТГЭХ буюу НЭГ ЗҮГТ ХАРАХ

Эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээр ажилладаг байгууллагууд өөрсдийн ойлголтоо нэгтгэх, өөрсдөө чадваржих, суралцах, бие биенээ мэдээллээр хангаж байх шаардлагатай байгаа нь хуралдааны явцад ихээхэн ажиглагдлаа. Тухайлбал, оролцогчид охидын талаар өөр өөр үзэл хандлага, байр суурьтай байсан. Тиймээс охидын эрх, эмэгтэйчүүдийн эрх, жендэр, хүний эрхийн талаарх ойлголт мэдлэгээ шинэчилж, аливаад дэвшилтэт үзэл санаанаас хандах хандлагыг төлөвшүүлэх нэн хэрэгцээтэй байна.

Охид, залуу эмэгтэйчүүдийг мэдээллээр хангах, эрхийнх нь талаар ойлгуулах, улмаар оролцоог нь нэмэгдүүлж, дуу хоолойг чангатгах боломжтой болох юм.

Цаашлаад мэргэжилтнүүдийн болон охидыг тойрон хүрээлж буй хүмүүс, тухайлбал эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчдийн ойлголтыг нэмэгдүүлэх, чадавхижуулах чиглэлээр ажиллах шаардлага байна.

**4) Асуудал нь орхигдсон бүлэг: салбар хуралдаанаас гарсан санал дүгнэлт**

*Чиглүүлэгч: Б.Чулуундолгор*

Нийгэм судлаач Луис Вирт цөөнх, нийгмийн орхигдсон бүлэг гэдэгт “өөрийн гадаад байдал эсвэл соёлын онцлох шинжээс хамааран нийгэм дэхь бусад хүмүүсээс ялгаатай, тэгш бус харьцсан байдлаар амьдардаг, хамтдаа ялгаварлан гадуурхалтад өртөж болзошгүй хүмүүсийн бүлгийг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг. Үүнээс харахад тухайн цөөнхийн бүлэгт багтах эсэхийг нийгмээс тодорхойлдог ба хувь хүний онцлох шинжид тулгуурладаг байна. Эдгээр бүлэг хүмүүсээс дурдвал жендэрийн болон бэлгийн, угсаатны, хэлний, насны цөөнхөөс гадна хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нэрлэх боломжтой.

2016 оны 11 сарын 17-18-ны өдрүүдэд Эмэгтэйчүүд нийгмийн өөрчлөлтийг хөтлөгчид уриатай зохион байгуулагдсан “Шинэ сорилт, боломж, чуулга уулзалт”-ын 4-р салбар хуралдаанд Асуудал нь орхигдсон бүлгийн эмэгтэйчүүд болох хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнх, эрт тэтгэвэрт гарсан эмэгтэйчүүдийн төлөөлөлүүд нэгдэж хөдөлмөр эрхлэлт, орлогоо нэмэгдүүлэх, өөрсдийн асуудлаа төрийн үйлчилгээний ажилтанууд, олон нийт, гэр бүлийнхэнд зөвөөр ойлгуулах арга замыг хайхын зэрэгцээ, энэ чиглэлийн үйл ажиллагааг дэмжсэн бодлого шийдвэр гаргахад хамтдаа нөлөөлөх талаар хэлэлцлээ.

Хэлэлцүүлгийн үеэр эмэгтэйчүүд маань хамгийн их тулгамдаж буй асуудлаа тодорхойлон гаргасан бөгөөд 1-рт мэдээллийг цаг тухайд нь олж авах, 2-рт хөдөлмөр эрхлэлт, орлого нэмэгдүүлэхтэй холбоотой төрийн дэмжлэгийг авах, 3-рт эмэгтэйчүүд өөрсдөө идэвхтэй зорилго тэмүүлэлтэй байх асуудлуудыг нэн тэргүүнд авч үзсэн бол чанартай эрүүл мэнд үйлчилгээ авах, нийгмийн бүхий л үйлчилгээнд бусадтай адил ижил тэгш хамрагддаг байх, эмэгтэйчүүдийн гэр бүл ойр дотныхон болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн хариуцлагыг мөн дурдсан.

**Мэдээллийг хүртээмжтэй болгох чиглэлээрх санал.**



Мэдээлэл нь янз бүрийн чадавхи, соёл, хэл, насны ялгаатай хүмүүсийн онцлогт тохирсон олон төрлийн хэлбэр, агуулгатай байхын чухлыг оролцогч онцгойлсон. Жишээ нь төрийн үйлчилгээний байгууллагууд мэдээллийг түгээхдээ аль болох албаны үг хэллэг ашиглахгүй байх, зөвхөн бичгэн мэдээллээр биш уншиж, тайлбарлаж өгдөг, /face to face/, хялбар зурган өгүүлэмжээр илэрхийлсэн байх, соёлын онцлогт нь тохируулсан олон сонирхолтой хэлбэртэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохирсон брайль, дохионы орчуулгатай, том үсгийн фондтой хэвлэсэн байх зэргийг дурдаж байлаа. Мэдээллийг иргэдэд хүргэх, түгээх үүргийг төр зөвхөн өөртөө авахгүйгээр иргэдийн бүлгүүдээр өөрсдөөр нь хийлгүүлэх, иргэний танхимын үйл ажиллагааг зорилтот бүлгүүдэд ээлтэй хүртээмжтэй болгоход тусгайлан анхаарч, шинээр гарсан хууль тогтоомжийг сурталчилах тайлбарлан таниулах тогтмол цаг өдөртэй болгох зэрэг зохион байгуулалтыг хийх саналуудыг дэвшүүлсэн.

Мөн төрийн үйлчилгээний ажилтануудыг хүний эрхийн мэдлэгтэй болгох, тэр дундаа нийгмийн цөөнх болсон хөгжлийн бэрхшээлтэй, шилжин суурьшигчид, өндөр настан, үндэсний цөөнхийн **онцлог, хэрэгцээ шаардлагын талаар** гүн гүнзгий мэдлэг, мэдээлэлтэй болгох, эмч, эмнэлэгийн ажилтан бэлтгэдэг их дээд сургуулийн сургалтын цөм хөтөлбөрт хүний эрх, хүний ялгаатай байдлын тухай өргөн хүрээний ойлголтыг сургалтын цөм хөтөлбөрт тусгах замаар асуудалд хүний Эрхийн хандлагаар хандах чадварт сургах зайлшгүй шаардлагтайг сануулсан.

**Хөдөлмөр эрхлэлт, орлогыг нэмэгдүүлэх, өөрийн өмчтэй байх болон бусад нийгмийн дэмжлэгийг авахтай холбоотой саналууд.**

Оролцогчид төрийн дэмжлэг оновчгүй, хэт хавтгайрсан байгаад шүүмжлэлтэй хандаж байв. Тухайлбал өрх толгойлсон эмэгтэйчүүдэд үзүүлдэг нийгмийн хамгаалалын дэмжлэгт хөгжлийн бэрхшээлтэй өрх толгойлсон ээж яг ижил нөхцөлөөр хамрагдаж байгаа нь шударга бус байгаа, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ харж, асардаг ээжүүдийн болон эрт тэтгэвэрт гарсан эмэгтэйчүүдийн нийгмийн хамгаалалын асуудал орхигдсон, төрөөс олгогдож буй тэтгэвэр, тэтгэмж инфляцтай уялдаагүй, шилжин суурьшигчид өөрийн өмчтэй байх, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ авах асуудлууд хүндрэлтэй байгаа зэргийг дурдсан.

Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн тусгайлсан бодлого хөтөлбөр бий болгох, ажил олгогчид аж ахуйн нэгж байгууллагуудад дээрх бүлгийн эмэгтэйчүүдэд ажлын байр үүсгэсэн тохиолдолд дэмжлэг үзүүлдэг тогтолцоог бий болгох, хувь хүний хөгжлийг дэмжсэн сургалт, олон нийтийн арга хэмжээг шилжин суурьшигчид, үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглүүлэхийг бодлогоор дэмжих. Тухайлбал оюутнуудын дадлага болон сайн дурын ажлыг зорилтот бүлгийн эмэгтэйчүүд рүү чиглүүлж, оюутны кредит цагтай уялдуулах, оны шилдэг аж ахуйн нэгж байгууллагуудыг /Entrepreneur/ шалгаруулахдаа "...эмэгтэйчүүдэд ажлын байр үүсгэсэн, дэмжсэн гэсэн шалгууртай байх гэсэн саналуудыг эмэгтэйчүүд маань гаргалаа

Мөн одоог хүртэл дээрх эмэгтэйчүүдийн нийтлэг асуудал тэр дундаа ажил эрхлэлт, орлоготой байх асуудлаар хийгдсэн судалгаа тайлан байхгүй байгаа нь бодлого шийдвэрт асуудал тусгагдахгүй байх нэг томоохон шалтгаан болж байгааг оролцогчид дуу нэгтэй илэрхийлсэн. Цаашид нийгмийн цөөнх эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажилладаг ИНБ-ууд хамтдаа зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн асуудлыг тодруулж гаргаж ирэх үндэсний хэмжээний судалгаа хийх, гарсан санал дүгнэлийн дагуу шат дараалалтай нөлөөллийн ажлыг хийх замаар асуудлыг бодлогын түвшинд гаргаж ирж шийдвэрлүүлэх нэн шаардлагатай байгааг тодорхойлсон

### **Эмэгтэйчүүдийн идэвх, зорилго тэмүүлэл.**

Шилжин суурьшигчид, үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй, эрт тэтгэвэрт гарсан эмэгтэйчүүдэд амьдарлын итгэл үнэмшил бий болгох, зорилго тэмүүлэлтэй болгох олон нийтийн арга хэмжээг тэдний сонирхол чадварт тохируулан хийдэг, эрхийг таниулах, хууль эрх зүйн мэдлэг мэдээллээр хангах, хүчирхийлэлээс хамгаалах, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ хөдөлмөр эрхлэлт, орлоготой болох үйл явцад нь дэмжлэг үзүүлдэг, соёл мэдээллийн нэгдсэн төвийг бий болгох саналыг эмэгтэйчүүд гаргасан нь туйлын чухал байлаа.

Мөн эмэгтэйчүүд маань өөрсөндөө хамаатай бодлого шийдвэр үйл ажиллагаанд хяналт тавих чадварт суралцах зайлшгүй шаардлагатай байгаагаа илэрхийлсэн. Эмэгтэйчүүдийг идэвхжүүлэхдээ иргэдийн дунд байгаа идэвхтэй манлайлагч иргэдийн төлөөллөөр дамжуулж нөлөөлөл хийх нь илүү үр дүнтэй байдаг туршлагаа эмэгтэйчүүд хуваалцсан. Өөрөөр хэлбэл ижил асуудалтай хүмүүсийн дунд бүлэг үүсгэн улмаар манлайлагч идэвхтэй нэгнээр нь чиглүүлэн удирдуулж, бэрхшээлээ даван туулж ирсэн туршлагаас нь яриулах нь үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах нэлээдгүй үр дүнтэй байдаг байна

Эцэст нь дүгнэхэд эмэгтэйчүүдэд тулгарч буй олон асуудлыг шийдвэрлэхэд хамгийн их оролцоотой, идэвхтэй, санаачлагатай байх хүмүүс эмэгтэйчүүд бид өөрсдөө гэдгийг хэлэлцүүлэгт оролцогч эмэгтэйчүүд санал нэгтэй хүлээн зөвшөөрсөн. Мөн бид нэг нэгээрээ биш хамтын хүчээр ажиллаж чадвал амжилтанд илүү хурдан хүрнэ гэдгийг оролцогчид маань чухалчилж байлаа.

## НЭГДСЭН ХУРАЛДААН: ХӨДӨЛГӨӨНӨӨ БЭХЖҮҮЛЭХ НЬ

### ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ЗАЛГАМЖ ХОЛБОО

*Б.Оюундарь, Хөөрхөн Зүрхнүүдийн Аян ТББ*

Яагаад энэ асуудлыг ярих ёстой вэ?

- Жендэрийн тэгш байдал
- Нийгмийг эрүүлжүүлэх
- Жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох

Монголын эмэгтэйчүүдийн хөдөлгөөний түүхэн замналыг авч үзвэл анх эмэгтэйчүүдийн хөдөлгөөн 1924 онд үүссэн байна. (Холбоотой эх сурвалж: Mongolia grants suffrage to women. 1981: Mongolia ratifies CEDAW.) Мөн эмэгтэйчүүдийн хөдөлгөөний үүсэл хөгжлийн асуудлаар дараахь мэдээллээс тодорхой авч болно. (1993: Mongolia adopts a new constitution that prohibits sex-based discrimination and promotes equal rights for men and women. 2002: Mongolia ratifies the CEDAW Optional Protocol. 2004: The Parliament of Mongolia adopts a Domestic Violence Law. Women’s rights groups had been lobbying for this bill’s passage since 1996. 2005: Lobbying by women’s groups results in a quota mandating that 30% of a political party’s candidates must be women. 2008: This quota is rescinded shortly before the 2008 elections. 3 women (4%) are elected to the Ulsyn Ikh Kural (the single house), 2008: Report submitted to CEDAW identifies significant social marginalization of sexual minorities in Mongolia and the need to redefine the concept of human rights in Mongolia to include the LGBT community. Recommendations include revising the constitution and criminal law, implementing anti- discrimination legislation, and conducting human rights training, among others.)

Тэгвэл өнөөгийн нөхцөл байдал ямар байгаа вэ?

- Ахмад эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, залуу эмэгтэйчүүдийн хөдөлгөөнүүд тус бүр яг адилхан биш, ялгаатай
- Тус бүр өөрийн туулсан/туулах түүхтэй
- Эмэгтэй ХҮН БҮРИЙН өөр өөрийн онцлог, эрхэм чанар, туулсан түүхийг хүлээн зөвшөөрөх, ялгаатай байдлыг нэвтрүүлэх
- Эмэгтэйчүүдийн үе хоорондын хөдөлгөөнүүд бие биенийхээ олон талт байдлыг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх хэрэгтэй

Цаашид

- Үе хоорондын харилцааг Бэхжүүлэх
- Өмнөх үеэс харилцан суралцах, туршлага солилцох
- Өмнөх үетэй хамтарсан тогтолцоог бий болгох
- Үе бүрийн эмэгтэйчүүд бие биенээ дэмжих, урамшуулах, туслах

- Үе бүрийн ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЯЛГААТАЙ ОНЦЛОГ БАЙДЛЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, ойлгох, хандлагыг төлөвшүүлэх

Цөөнхийн асуудал: үүнд хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдийн асуудлыг маш дээгүүр авч үзэх хэрэгтэй. Яагаад гэвэл хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдтэйгээ хотын эмэгтэйчүүдийн хөдөлгөөний харилцаа холбоог яаж бэхжүүлэх үү гэдгийг ярилцах болно.

Бид хамтын хүчээр нийгмийн өөрчлөлтийн хөдөлгөгч хүч юм.

## ХӨДӨЛГӨӨНИЙ САН БҮРДҮҮЛЭЛТ

*Б.Батхишиг, Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан ТББ-ын Дэд Тэргүүн*

Дэлхийн Хүмүүнлэгийн туслалцаа (Global Humanitarian assistance) байгууллагын 2015 онд гарсан судалгаанд 2010-2014 оны хооронд гарсан санхүүгийн нийт ЗӨВХӨН 1.6% (US\$243 сая) нь хөгжиж буй орнуудын Иргэний Нийгмийн Байгууллагууд шууд хүрсэн байна

2014 онд 24.5 тэрбум долларыг хүмүүнлэг, хөгжлийн тусламжийн санг бүрдүүлсэн байна. Энэ тайлангаас харахад ОУ-ын хүмүүнлэгийн тусламж томоохон хэмжээний байгууллага, ОУТББ-дад хуваарилагдсаар байна. Тайланд томоохон хэмжээний байгууллага, олон улсын хэмжээнд хил дамнан ажиллаж байгаа олон улсын ТББ-ууд ихэнх хүмүүнлэгийн тусламжийг авсаар байна гэсэн дүгнэлт гарсан байна.

Энэ пирамидаас харахад хамгийн түрүүнд донор байгууллага байна. Донор байгууллага гэдэгт хувийн хэвшил, засгийн газар, засгийн газрын хоорондын байгууллагууд байна. Эдгээр байгууллагууд нь хаашаа мөнгөө чиглүүлдэг вэ гэхээр дундын байгууллага НҮБ, олон улсын ТББ-ууд руу тусламжаа явуулдаг. Ингэснээр бид НҮБ, олон улсын ТББ-уудаас санхүүжилт аваад ажиллаж байгаа.


Хөгжиж байгаа улс орнуудын засгийн газар болон үндэсний ТББ-ууд руу явж байгаа. Энэ нь цаашлаад орон нутгийн болон бүлэг нөхөрлөлийн хэмжээнд хүрч байна. Эдгээр 4 түвшинг харахад донор бол өөрөө шууд үйл ажиллагаагаа явуулдаггүй. Дундын байгууллагуудаар дамжуулан туслалцаагаа хүргүүлж байна.

### Тэгэхээр дундын тоглогчид гэж хэн юм бэ?

- Мэргэжлийн түвшинд бэлтгэгдсэн, голчлон хөгжсөн орнуудад төвтэй томоохон ТББ: Жишээлбэл: Дэлхийн зөн, салбар нь дэлхий даяар байдаг. НҮБ нь маш их хэмжээний тусламж, хөрөнгийг зарцуулж байдаг. Үүнд хамгийн их мөнгө зарцуулдаг байгууллага нь Дэлхийн хүнсний байгууллага FAO, дүрвэгсдийн байгууллага, НҮБ-ын Хүүхдийн сан гэх мэт.

- Хариуцлага өндөр, санхүү ба үйл ажиллагааны тайлангийн ур чадвар сайтай байгууллагууд байдаг
- Хяналт, үнэлгээ, гүйцэтгэлийг хангалттай хийдэг гэдэг шалтгаалаар донор байгууллагууд эдгээр байгууллагуудаар дамжуулан төсөв болон санхүүжилтээ өгөх сонирхолтой байдаг.

### **Яагаад дундын тоглогчид байх шаардлагатай вэ?**



ДОНОР (хувийн хэвшил, ЗГ)

НҮБ, ОУТББ

ЗГ  
ҮНДЭСНИЙ ТББ

ОРОН НУТГИЙН ТББ,  
БҮЛЭГ, НӨХӨРЛӨЛ

- Бага хэмжээний санхүүжилт = ЗАРДАЛ ӨНДӨР (удирдлага зохион байгуулалтыг нь хийхэд зардал өндөр байдаг.)
- Байнгын ЧИГЛҮҮЛЭГ, ХЯНАЛТ тавих тогтолцоо шаардлагатай
- Цөөхөн итгэмжтэй түншүүдээрээ дамжуулах нь ЭРСДЛИЙГ ДАВАХ, мөн дотоод дүрэм журмаа мөрдөх боломжтой.
- Эдгээрээс шалтгаалан олон улсын томоохон байгууллагуудыг сонгодог.

### **Гадаад тусламжийн бодлогын зарчмын чиг хандлага**

- “Хөгжил хүмүүнлэгийн туслалцааг үр ашигтай гүйцэтгэхэд орон нутаг ба үндэсний ТББ нэн чухал үүрэгтэй”
- “Үндэсний ТББ нь аливаа аюул гамшигт сая саяараа өртөх явдлыг урьдчилан сэргийлэх ажлыг явуулахад найдвартай түнш болох боломжтой”

### **Гадаад санхүүжилтийг татахад анхаарах зүйлс, сургамж**

- Тухайн хандивлагч байгууллагын бодлого, стратегийн ойлголттой байх
- Улс орон, орон нутгийнхаа нөхцөл байдалд тохируулан тавигдаж буй шаардлагыг хамгийн оновчтой аргаар хангасан байх
- Байнгын харилцаа холбоо, мэдээлэл тайлагналтын шаардлагыг хангах хэрэгтэй байдаг.

### **Танай ТББ улс орныхоо тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах гэсэн эрхэм зорилготой юу?**

2030 он хүртэл бүх л чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын эрхэм зорилго нь тогтвортой хөгжлийн зорилгод хувь нэмрээ оруулахад чиглэгдэн ажиллаж байгаа. Тэгэхээр бид энэ том алсын хараанд өөрсдийгөө чиглүүлэн, зүг чигээ тодорхойлох вэ гэдгийг байнга бодож, ажил хэрэг болгож байж санхүүжүүлэгч байгууллагуудад өөрийгөө бүрэн дүүрэн ойлгуулах хэрэгтэй.

Энэ тодорхойлолтын дагуу, тогтвортой байдал гэдэг нь юуг шаардаж байна вэ гэхээр хүмүүс өөрсдийн амьдралын хэрэгцээгээ одоо ба ирээдүйд хангаж байх явдал юм. Амьдралыг хэрэгцээ гэдэг нь сайхан амьдралын материаллаг хэрэглээ, эрх чөлөө ба сонголт, нийгмийн зөв харилцаа, хувийн аюулгүй

байдал. Тогтвортой байдлыг үнэлэх асуудал бол улс төр ба шинжлэх ухааны үйл явц юм. Тогтвортой байдлыг эрхэмлэсэн алсан хараа байгаль эх хүн төрөлхтнийг тэтгэх, хүний нийгэмд ашиг тусаа тогтмол үзүүлж байх гэсэн үзйл санаан дээр тогтоно.

Бидэнд:

- 1) ХӨРӨНГӨ БОСГОХ УУ?
- 2) НИЙГМИЙН БАЯЛАГ БҮТЭЭХ ҮҮ? Гэсэн асуудал гарч ирж байна.

Үндсэндээ нийгмийн баялаг нь хамгийн чухал нь. Бид байгалийн баялгийг биш, бүтээгдсэн баялгийг биш хүний баялгийг бүтээхэд хувь нэмрээ оруулах нь бидний тогтвортой хөгжилд оруулах хувь нэмэр болж байна.

Санхүүжилт босгохын тулд зайлшгүй бид өрсөлдөөнд орж байна.

### **САНХҮҮЖИЛТ БОСГОХ ӨРСӨЛДӨӨНИЙ сул тал юу вэ?**

- Ур чадвар, бололцооноос хэтэрсэн үйл ажиллагаа ба зорилтуудыг амлах
- Бүрэн сайн бичигдсэн хэмээх тайлан нь амласан үйл ажиллагааг биш харин донорын хэрэгцээг хангах төдий болсон
- Донорууд цалин, захиргааны зардлыг санхүүжүүлдэггүй тул ТББ-д өөрсдийнхөө үйл ажиллагааны зардлыг гаргах нь дарамт болдог

### **ГАДААД САНХҮҮЖИЛТИЙН УРСГАЛАА ТОГТВОРЖУУЛАХАД шаардлагатай ХҮЧИН ЗҮЙЛС юу вэ?**

- 1) Хэрэгцээнд тулгуурласан (Хэний? Ямар бодлогын?)
- 2) Эрэлтийг хангасан (Хэний? Ямар бодлогын?)
- 3) Удирдлага нь харилцаа хандлагын ур чадвартай
- 4) Ашиг хүртэж буй ба хамтрагч талуудынхаа хувирах хүсэл сонирхолд нийцүүлэх оролдлого чармайлттай
- 5) Хариуцлагатай, ил тод нээлттэй
- 6) Үр дүнд чиглэсэн төслийн менежмент

### **Ийм учир бид үр дүнд чиглэсэн төслийн менежментийг барих ёстой. Тодруулж хэлбэл үр дүнд чиглэсэн багийн удирдлага, зарчим**

Санал болгож буй зорилт нь тухайн салбарын ямар бодлогыг ямар арга механизмаар аль түвшинд хэрэгжүүлж байна вэ? гэдгийг хоорондоо маш сайн ойлголцох хэрэгтэй. Монгол улсын хэмжээнд ямар бодлого, олон улсын ямар конвенци, эсвэл тухайн орон нутгийн засаг даргын тамгын газрын мөрийн хөтөлбөр юм уу гэдгийг бодож байж, түүндээ үр дүнгээ чиглүүлэх хэрэгтэй.



## ДОТООД САН БҮРДҮҮЛЭЛТ

*П.Золзаяа, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвийн Дэд захирал*

Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвийг төрөөс санхүүжилт авдаг гэсэн ойлголт олон нийтийн дунд байдаг. Гэхдээ төрөөс авч байгаа санхүүжилт нь байгууллагын явуулж байгаа үйл ажиллагааны зөвхөн бага хэсгийг хангадаг учир энэ санхүүжилт нь хангалттай биш байдаг.

**Төрөөс авсан санхүүжилт**-сүүлийн 5 жилд төрөөс санхүүжилт авсан. Гэхдээ энэ санхүүжилт нь үйл ажиллагааны зардал 100% хангаж чадаж байна уу гэдэг нь асуудал. Тухайлбал 2012 онд Хүн ам, нийгмийн хамгааллын яам үйлчилгээний нийт зардлын 10 хувийг санхүүжүүлэх зардал өгсөн 2015 оын 05-р сараас хойш санхүүжилт аваагүй. Шалтгаан нь Засгийн газарт мөнгө байхгүй, төсөв хуваарилаагүй гэх мэт

Хүснэгт.2010-2015 оны хооронд авсан санхүүжилт:

Он	Хаанаас	Чиглэл	Хувь (үйлчилгээний нийт зардалд эзлэх)
2010-2012	ХАХНХЯ	Үйлчилгээ	10%
2012	ЖҮХ	Утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээ	60%
2014	ХЗЯ	16 аймагт сургалт Цагдаа нарыг сургах	
2011-2015 05-р сар	Халамжийн ерөнхий газар	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн түр байрлуулах үйлчилгээ	Гэрээт үйлчилгээ 45%

ХЭҮТ нь үйлчилгээ үзүүлдэг. Үйлчилгээгээ тасралтгүй, тасралтгүй, чанартай үзүүлэхийн тулд нөлөөлөл хийх, хөрөнгө босгох, төсөл бичих шаардлагатай байдаг. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв нь дэргэдээ хамгаалах байртай. Хамгаалах байр нь харъяалал харгалзахгүй үйлчлүүлэгчийг авч, аюулгүй байдлыг хангадаг. Төрөөс санхүүжилт авч чадахгүй болсон тэр үеэс хүндрэл гарч ирсэн. Холбогдох газруудтай уулзаад багагүй хугацаа өнгөрсөн. Засгийн газар бол мөнгөгүй гэсэн тайлбарыг байнга тавьж байсан. Төр санхүүжилт хийгээгүй юм чинь бид үйлчилгээгээ үзүүлэхгүй гэж хэлэх эрх бидэнд байхгүй. Яагаад гэхээр өмссөн хувцастайгаа хөөгдөөд гараад гүйсэн үйлчлүүлэгчид ирж байхад бид урдаас нь хаалгаа бариад зогсч байх эрх байхгүй.

Тэгэхээр төрөөс бидэнд тодорхой хэмжээний санхүүжилт өгч байсан, түүний сацуу бид төсөл бичиж байсан. Төрөөс санхүүжилт хийхгүй байх нь бас бидэнд цохилт, сорилт болж байна. Өөр ямар арга замаар тухайн нөхцөл байдлыг шийдэх вэ гэсэн асуудал гарч ирсэн. Бид үйлчилгээгээ чанартай, хүртээмжтэй, тогтвортой үзүүлэхийн тулд тасралтгүй явсаар л байгаа. Одоо хүртэл бодит шийдэлд хүрч чадаагүй л байна.

Төрөөс санхүүжилт зогсонгуут тухайн нөхцөл байдалд яаралтай шийдвэр гаргах хэрэгтэй болсон. Төсөл хэрэгжихэд тодорхой хугацаатай, хэдэн төгрөг зарцуулах уу гэсэн төлөвлөгөөтэй хийгддэг учраас бид бусад үйлчилгээндээ санхүүжилтээ яаж олох вэ? Хөрөнгөө яаж босгох вэ гэсэн асуудал гарч ирсэн.

Гэхдээ энэ сорилтын цаана бас боломж байсан. Хөрөнгө босгох ур чадвар илүү их шаардлагатай болсон. Тэгээд маш хурдтайгаар хөрөнгө босгож эхэлсэн. Өмнө нь бол нэг удаагийн хөрөнгө босголтын ажил хийдэг байсан. Үүнээс юу сурсан бэ гэхээр хөрөнгө босголтоо хамтрагч түншлэгч байгууллагуудтайгаа илүү урт хугацаад хамтрах юм байна гэж ойлгосон. Зөвхөн 1 удаа хөрөнгө босгоод дэмжлэг аваад зогсохгүй хамтын ажиллагаагаа өргөжүүлэх хэрэгтэй юм байна.

Өмнө нь хамгаалах байрыг нэг нэг өрөөгөөр нь байгууллагуудад очиж тохижуулах хөрөнгө босгох гэж ажилладаг байсан. Хамгаалах байранд ирж байгаад хүмүүсийг тохь тухтай хүлээж авах хэрэгтэй. Бид тэгээд зоригтойгоор хөрөнгө босгохоор уулзаж байгаа газартаа бүх асуудлыг танилцуулъя гээд Вагнер Ази тоног төхөөрөмж ХХК-д очиж танилцуулсан. Хөрөнгө босгох үйл явц нь удаан хугацаанд үргэлжилдэг. Зураг дээрх ажлыг хийхийн тулд бид 1 жил явсан. Тэгээд хамгаалах байрны доторх бүх өрөөнүүдийг бүрэн засварлаж тохижуулах ажлыг өнгөрсөн жил амжилттайгаар хийж дууссан.

Бидний авсан сургамж юу вэ гэхээр бид хүнээс зөвхөн авах биш өөрсдөө бас өгөх ёстой юм байна гэдгийг бодож, бидэнд өгөхөөр юу байна хайж эхэлсэн. Тухайлбал тухайн пүүс компаниудын ажилтнуудыг сургах хамтын ажиллагаа руу хөгжүүлж эхэлсэн. Хамгаалах байранд маш их хэрэгцээ шаардлага байдаг. Тэр бүрийг дотоодын компаниудаас хөрөнгө босгоод хийж байна. Цаашид бид илүү өргөн хүрээнд хөрөнгө босгох ёстой юу гэдгээ ярилцаад, хамгаалах байрны гал тогоог шинэчилж гээд 14 хоногийн аяны хүрээнд хөрөнгө босгож чадсан. Мөн байгууллагуудтай 1 жилийн гэрээ байгуулж хамтын ажиллагаа, түншлэлээ яаж тогтоон барих уу гэсэн стратегия боловсруулсан. Энэ маш чухал.


Бас нэг арга нь “Сүүдэр ший” жүжиг. 2012 оноос тасралтгүй жил бүр энэ жүжгийг тоглодог. Үүний онцлог нь хамгаалах байраар хамгаалуулаад, үйлчилгээ аваад, даван туулсан хүүхэд эмэгтэйчүүд маань өөрсдөө асуудлаа олон нийтэд ойлгуулах зорилгоор амьдралынхаа түүх дээр үндэслээд хөшигний ард жүжиглэж үзүүлдэг тийм онцлогтой байгаа. Энэ нь бид асуудлаа ойлгуулж байна. Үүний хажуугаар хөрөнгөө бас давхар босгож байдаг. Хөрөнгө босгох бусад боломжит арга замуудыг хайсаар байна. Хаана бидэнд боломж байна гэсэн хайгуул хийж, сувгуудаа маш сайн тодорхойлох хэрэгтэй. Очиж уулзаж, ойлголцож тэгээд урт удаан хугацаанд хамтран ажиллах хэрэгтэй. Бид **2015 он хойш 7.535.620.11** төгрөгийг босгосон бол **2016 онд** үүнийгээ 2-3 дахин нэмэгдүүлээд 24.673.579 төгрөгийг босгож чадсан байна. Бид тэгээд энэ замыг сонгоод явах уу цаашид яах уу гэдгээ бас харах хэрэгтэй болно.

### Үүнээс бидний авсан сургамж юу вэ гэхээр:

Бид асуудлаа, агуулгаа ойлгуулж бодлогод оруулж нөлөөлж чаддаг. Гэхдээ бидний нөгөө багана нь санхүү төсвийн асуудал байдаг. Үүнийгээ бид байнга орхигдуулж явдаг. Яг энэ бодлогод нөлөөлж хамтарч ажилладаг шигээ төсөвт ч гэсэн хамтдаа нөлөөлөх хэрэгтэй юм байна.

Төсвийг хэлэлцээд баталсны дараа биш, хэлэлцэх боловсруулах явцад нь оролцох ёстой юм байна. Бидэнд төсөвт дүн шинжилгээг хийх чадвар дутмаг байна. Энэ чадварт суралцах ёстой юм байна. Төсөвт нөлөөлөх нөлөөллийг ажлыг хэсэг хугацаанд биш үргэлж, тогтмол хийж байх хэрэгтэй юм байна.

Эргээд хяналт тавьж байх ёстой. Хөрөнгө босгох үйл явц нь биднээс илүү их маркетингийн ур чадварыг шаарддаг юм байна. Тэгэхээр бид бизнесийн байгууллагаас суралцах ёстой юм байна.



### Цаашид

Бид бүгдийн толгойны өвчин болж байдаг асуудал бол санхүүжилт байдаг. Бүгд ийм нийтлэг асуудалтай байгаа учраас хамтдаа нэгдэх хэрэгтэй юм байна. 1, 2 байгууллага очоод нөлөөллийн ажил хийснээс бидний асуудал энэ байна гээд хамтдаа нэгдэх хэрэгтэй байна.

Үүний тулд эхлээд бидэнд хамтын стратеги хэрэгтэй. Тэгээд хамтдаа зоригтойгоор, хүчтэйгээр нөлөөлөх ёстой юм байна гэдгийг ойлгосон. Ер нь бол бидэнд өөр өөрийн гэсэн арга туршлагууд байгаа, тэр арга туршлагаа нэгтгээд олон өнгийг хослуулаад өөрчлөлтийг хийх шаардлагатай юм байна гэсэн дүгнэлтэд хүрсэн.



## ХӨДӨЛГӨӨНИЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

*Д.Бүжин, Дорнод аймгийн Иргэний нийгмийн байгууллагуулын зөвлөлийн дарга*

Одоогоос 10 гаруй жилийн өмнөөс иргэний нийгмийн байгууллагууд маань нэгдэж, хамтарч ажиллаж эхэлсэн. Монголын Эмэгтэйчүүдийн сангаас орон нутагт эмэгтэйчүүдийн сүлжээ байгууллагуудыг байгуулж, өргөжүүлж ажилласан. Өнөөдрийн хувьд үйл ажиллагаа нь тогтвортой ажиллаж байгаа мөн хүрээгээ тэлж чадахгүй байгаа байгууллагууд ч байна. Иймээс бид эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг цаашид бэхжүүлж, өргөн хүрээнд яаж үйл ажиллагаагаа явуулах хэрэгтэй байна. Нийгмийн өөрчлөлтийг авчрахын тулд эмэгтэйчүүдийн хөдөлгөөнүүд хөдөлгөөнөөс хөдөлгөөнд явах хэрэгтэй. Ингэснээр бид нийгмийн өөрчлөлтийг авчирч чадна.

**Дорнод аймаг дахь Эмэгтэйчүүдийн ТББ-уудын сүлжээ** нь нийгмийн хөгжил дэвшил, өөрчлөлт шинэчлэлт, эмэгтэйчүүдийн тэгш эрх, эрх чөлөөний төлөө 2008 оноос хойш тогтвортой ажиллаж байна.

**Танилцуулга** МОНЭС-ийн дэмжлэгээр орон нутгийн эмэгтэйчүүдийн ТББ-уудын туршлага солилцох уулзалтын ажиллагааг 2008 онд зохион байгуулж, уулзалтын ажиллагааны үр дүнд эмэгтэйчүүдийн 12 байгууллага нэгдэж Дорнод аймгийн ЭТББ-уудын сүлжээ байгуулагдсан.

**Зорилго:** Нийгмийн сайн сайхан амьдралын төлөө эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг өрнүүлж харилцан бие биенээсээ суралцан хамтарч ажилласнаар орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулах явдал юм.

### ОРОН НУТГИЙН ЭТББ-ИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ЗОРИЛГО

- Жендерийн тэгш байдал, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
- Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бууруулах
- Эмэгтэйчүүдийн манлайлал
- Эмэгтэйчүүдийн эдийн засгийн эрх мэдлийг сайжруулах, орлого нэмэгдүүлэх
- Байгаль орчноо хамгаалах
- Иргэдийн оролцоотой хяналт, үнэлгээ
- Төсвийн хөрөнгийн зарцуулалт болон төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн хяналт, үнэлгээ

### ҮР ДҮН

- Бид жендерийн тэгш байдал, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, гэр бүлийн болон жендерт суурилсан хүчирхийлэл, Ажлын байрны дарамт, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд иргэдийн оролцоотой хяналт үнэлгээ хийх, эрсдэлт бүлгийн охид эмэгтэйчүүдийг ХДХВ, ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх, хараа хяналтгүй хүүхдэд халамж үйлчилгээ үзүүлэх зэрэг асуудлыг орон нутгийн бодлогын түвшинд шийдвэрлүүлэхийн төлөө ажиллаж, сайн дурын хөдөлгөөнийг өрнүүлж чадсан.

- Бид нийгмийн хөгжлийн асуудал дээр нам харгалзахгүйгээр, үзэл бодлоороо нэгдэж чадсан.
- Бид төсвийн хөрөнгийн зарцуулалтанд иргэдийн хяналт тавих аргачлалыг орон нутагт бий болгож, төрийн хариуцлагыг нэмэгдүүлж чадсан.
- Бид авилгалтай тэмцэх газрын үндэсний хэмжээний 9 сайн ажлын нэгээр шалгарч иргэний мониторингийн загварыг үндэсний хэмжээнд бий болгосон.
- Анх удаа орон нутагтаа 2013-2020 хүртэл хөгжүүлэх Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөрийг санаачлан хийж орон нутгийн эмэгтэйчүүдийн бодлогын баримт бичигтэй болсон.

### **ЮУ ХИЙХ ЧАДСАНГҮЙ, ЮУН ДЭЭР АЛДАВ**

- Орон нутагт эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг бүх түвшинд өрнүүлж чадаагүй
- Хүний эрх, ардчилал, шударга ёс, нийгмийн хөгжлийн асуудлаар иргэдийн ойлголт мэдлэгийг хангалтай түвшинд нэмэгдүүлж чадсангүй.
- Залгамж халаа болох залуу үеэ бэлтгээгүй.
- Орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд төрийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх талаас нь үр дүнтэй ажиллаж чадсангүй.
- Иргэний нийгмийн байгууллагууд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээсээ илүүтэй, өөрсдөө оршин тогтнохын тулд санхүүжилт олоход хамаг цаг заваа зориулж зорилго, чиглэлийнхээ хүрээнд илүү мэргэшсэн байгууллага болж ажиллаж чадсангүй.

### **ЦААШИД БИД ЮУ ХИЙХ ВЭ?**

- 1) Хүний эрх, ардчилал, нийгмийн шударга ёс, жендерийн талаарх иргэдийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлж уламжлалт зан хандлагыг өөрчлөх, залуу үеийг багаас нь төлөвшүүлэх ажлыг системтэйгээр зохион байгуулах
- 2) Эмэгтэйчүүдийн хөдөлгөөн буюу манлайлалыг бүх түвшинд өрнүүлэх, хөдөө сумдын эмэгтэйчүүдэд хүрч ажиллах
- 3) Нийгмийн сайн дурын үйлсэд залуу охид эмэгтэйчүүдийг бэлтгэх
- 4) Орон нутгийн тулгамдсан асуудлыг бодлогын түвшинд шийдвэрлүүлэх, төрийн үүрэг хариуцлагыг сайжруулах, асуудалд мэдлэг, мэдээлэлтэй оролцох
- 5) Нийгмийн шударга ёсны төлөө олон улсын эмэгтэйчүүдийн хөдөлгөөнтэй хүчээ нэгтгэх, хамтарч ажиллах

### **СУРГАМЖ**

- Хүн амьдралдаа сайн, муу бүх зүйлийг үзэж байж ухаан сууж, туршлагаждаг.
- Үүнтэй адил бид нийгмийн сайн сайхан амьдралыг бий болгохын төлөө өгсөж уруудаж, алдаа, оноог тойрч биш даван туулж, улам туршлагажиж, улам чадваржиж байна.
- Оргил өөд тэмүүлэн зүтгэсний үр дүнд амжилтанд хүрэх учиртай.

## САЛБАР ХУРАЛДААНЫ ДҮГНЭЛТҮҮД: ХӨДӨЛГӨӨНӨӨ БЭХЖҮҮЛЭХ НЬ

### 1) Хөдөлгөөнийн залгамж холбоо – салбар хуралдааны дүгнэлт

Чиглүүлэгч: Б.Оюундарь, Хөөрхөн Зүрхнүүдийн Аян ТББ-ын Зохицуулагч

Эмэгтэйчүүдийн хөдөлгөөний үе хоорондын Залгамж холбоо сэдвийн хүрээнд нэгдсэн хуралдааны тавигдсан илтгэлийг 5 минутад багтаан дахин ярилцан сэдэлжүүлснээр салбар хуралдааныг үргэлжлүүлсэн.

Салбар хуралдааныг SWOT дүн шинжилгээний аргачлалыг сонгож, нийт оролцсон 20 гаруй оролцогчдыг 4 бүлэгт хуваан Эмэгтэйчүүдийн хөдөлгөөний залгамж холбоог цаашид бэхжүүлэхэд:

- Давуу тал
- Сул тал
- Боломж, нөөц
- Аюул занал нь юу юу байгааг хэлэлцүүлж ӨРТӨӨЧИЛСӨН аргаар зохион байгууллаа. SWOT аргачлалаар дамжуулан Эмэгтэйчүүдийн хөдөлгөөний үе хоорондын харилцаа холбоо, хамтран ажиллаж буй нөхцөл байдал, цаашид залгамж холбоогоо бэхжүүлэн ажиллахад бидэнд байгаа сайн туршлага, алдаа оноо, бие биедээ байгаа нөөц бололцооны талаар хэлэлцүүлж, багуудыг 4 бүлэгт өртөөчлөн аялуулсан нь оролцогч тус бүрийн саналыг сонсох, оролцуулах ач холбогдолтой байлаа.



4 баг тус бүр өртөөчилсөн хэлбэрээр 20 минутын турш ажилласны дараа нийт оролцогчоос авсан саналыг нэгтгэсэн байдлаар танилцуулж жишээ, кейсээр баяжуулан танилцууллаа:

### ДАВУУ ТАЛ

- ✓ ИНБ-ын үйл ажиллагаа тогтвортой явагдаж байна.
- ✓ Чадварлаг хүний нөөц, боловсон хүчин үе үеүүдэд бий.
- ✓ Асуудлын гарцыг илүү олон өнцгөөр хардаг.
- ✓ Уламжлал болон шинэчлэл хосолсон шинэ арга барилыг бий болгож чаддаг
- ✓ Бэлтгэгдсэн боловсон хүчнүүдтэйгээ байнгын харилцаа холбоотой
- ✓ Техник технологийн дэвшилтэт талыг ашигладаг
- ✓ Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх индэр болдог
- ✓ Өсөж хөгжих боломж олгодог, Чадвар болон хөгжих боломж бий болгодог
- ✓ Уян хатан бие даасан талбарыг бий болгож чаддаг



## СУЛ ТАЛ

- ! Хөрөнгө санхүү тогтвортой бус
- ! Технологийн дэвшилтийг ашиглалт тэгш бус
- ! Өмнөх үеийнхээ гавьяа туршлагыг үгүйсгэх дэмжихгүй байх
- ! Бодлогоор залгамж халааг бэлтгэдэггүй
- ! Үзэл бодол, ойлголцол хандлагын зөрүүтэйгээс зөрчил бий болдог
- ! Хамтын үйл ажиллагааг чухалчилдаггүй
- ! Аливаа асуудалд чиглэж өмчилдөг
- ! Уялдаа холбоо муу / ялангуяа өмнөх үе шинэ үе хоёр харилцдаггүй, огтлолцдоггүй
- ! Хувь хүний нийгмийн наад захын асуудлууд зөрчигддөг
- ! Намын хараат бус байдал чөдөр тушаа болдог /орон нутагт/
- ! Өмнөх үе маань залуу хойч үедээ залгамж халаагаа хүлээлгэж өгдөггүй

## НӨӨЦ БОЛОМЖ

- ✓ Техник технологийн дэвшлийг ашиглах /Сошиал медиа/
- ✓ Нийгмийн чиглэлээр суралцаж буй оюутнуудын клуб байгуулах, сайн дурын ажилд кредит олгох,
- ✓ Зохион байгуулалттайгаар залуучуудад ИНБ-д ажиллахад зориулсан хөтөлбөр сургалт курс бий болгох
- ✓ Залуу манлайллын хөтөлбөр бий болгох
- ✓ Дотооддоо хөрөнгө босгох, урамшуулах механизм бий болгох
- ✓ Сургалт хөтөлбөрүүдэд хамруулах
- ✓ Өмнөх үе маань бидний нөөц боломж
- ✓ Сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх
- ✓ Өмнөх үеийн туршлагад тулгуурлаад бодлого стратеги боловсруулах

## АЮУЛ ЗАНАЛХИЙЛЭЛ

- ! Санхүүжилтийн хүрээ хумигдаж байгаа байдал
- ! Асуудлыг өөр өөр өнцгөөр хардаг
- ! Улс төрийн хараат байдал
- ! Мэдлэг мэдээлэл дутмаг
- ! Ёс зүйгүй \Үйл ажиллагаа, төслийн санаа хуулбарлах\
- ! Нийгмийн хандлага, хэвшсэн ойлголт,
- ! Орон нутагт залгамж халаа бэлтгэх

## ДҮГНЭЛТ

“Хөдөлгөөний үе хоорондын залгамж холбоо” сэдвийн хүрээнд нэгдсэн хуралдааны тавигдсан илтгэлээр оролцогчдыг сэдэлжүүлснээр салбар хуралдааныг SWOT дүн шинжилгээний аргачлалыг нийт 20 гаруй оролцогчдыг 4 бүлэгт хуваан Эмэгтэйчүүдийн хөдөлгөөний залгамж холбоог цаашид бэхжүүлэхэд:

- Давуу тал
- Сул тал
- Боломж, нөөц
- Аюул занал нь юу юу байгааг хэлэлцүүлж ӨРТӨӨЧИЛСӨН аргаар зохион байгууллаа. SWOT аргачлалаар дамжуулан Эмэгтэйчүүдийн хөдөлгөөний үе хоорондын харилцаа холбоо, хамтран ажиллаж буй нөхцөл байдал, цаашид залгамж холбоогоо бэхжүүлэн ажиллахад бидэнд байгаа сайн туршлага, алдаа оноо, бие биедээ байгаа нөөц бололцооны талаар хэлэлцүүлж, багуудыг 4 бүлэгт өртөөчлөн аялуулсан нь оролцогч тус бүрийн саналыг сонсох, оролцуулах ач холбогдолтой байлаа.

Хөдөлгөөний ДАВУУ ТАЛын хүрээнд: Салбар бүрийн эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын тогтвортой ажиллаж буй байдал харилцан адилгүй ч гэлээ, Хүний эрх, эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээрх байгууллагууд тогтвортой, залуу үеүүд ч шинээр байгуулагдан ажиллаж байна. Мөн дийлэнх тохиолдолд тухайн чадварлаг, мэргэшсэн, туршлагатай ажилтан нь ажиллаж байсан байгууллагаасаа гарсан ч Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнд өөр бүлэг, хамт олон үүсгэн ажилласан хэвээр байдаг, нөгөө талаараа байнгын харилцаа холбоотой байна. Хөдөлгөөний залуу үеийхэн инноваци буюу шинэлэг, технологийн дэвшилтэд талыг ашиглан үйл ажиллагаагаа таниулан, хамтын ажиллагаагаа өргөжүүлж байна. Хөдөлгөөний элс ширхэг болсноор эмэгтэйчүүдэд өөрсдөд нь өсөж дэмжих, хөгжиж, чадваржих боломжийг бий болгож байна. Түүнчлэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, ажиллах уян хатан талбарыг бий болгож өгдөг гэж оролцогчид саналаа илэрхийллээ.

Харин өмнө болон одоо бидний дунд ажиглагдаж буй СУЛ ТАЛ, АЮУЛ ЗАНАЛын талаар: Тогтвортой залгамж холбоогоо бэхжүүлэхэд хөдөлгөөний хувьд ч байгууллагын хувьд ч санхүүжилт, цалин, урамшуулал хамгийн түрүүнд нөлөөлж байна. Мөн жил ирэх тусам гадны болон дотоодын санхүүжилтийн хэмжээ, хүрээ хумигдаж байгаа нь хөдөлгөөний залгамж холбоог бэхжүүлэхэд томоохон аюул занал юм. Хөдөлгөөний ахмад үеийн бүтээж бий болгосон гавьяа, зүтгэлийн үнэлдэггүй бол өмнөх үеийн манлайлагчид шинэ залуу үедээ боломж олгодоггүй. Эсрэгээрээ тухайн нэг үйл ажиллагаа, төсөл, кампанит ажлыг санаачлан, эхлүүлсэн байгууллагаас зөвшөөрөл авалгүй ашиглах, зохиогчийн нэрийг дурдахгүй байх зэрэг ёс зүйгүй үйлдэл, хандлага нь хөдөлгөөнийг бэхжүүлж, зөрчлийг арилгахад чөдөр тушаа болж байна. Аливаа нэг асуудлыг өмчлөх хандлагатай, бусад байгууллагуудтайгаа хамтран ажилладаггүй бол хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдийн байгууллагын үйл ажиллагаа улс төрийн, намын хараат байдалд байдаг гэжээ.

Цаашид бид хэрхэн хөдөлгөөний залгамж холбоогоо бэхжүүлж, нэмэгдүүлэхэд ямар нөөц, боломж байгаа эсэхэд: Сошиал медиагаар дамжуулан хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, инновацийг чухалчлаж нийгмийн салбарын чиглэлээр ажиллаж буй оюутан, залуучуудыг эгнээндээ сайн дураар татан оролцуулах нь бидэнд боломж гэж зарим багаас санал гарсан бол Өмнөх үеийн манлайлагч

эмэгтэйчүүдэд байгаа мэдлэг, чадварыг бид нөөц гэж харах нь чухал юм гэсэн саналыг ч дэвшүүллээ. Залгамж холбоогоо бэхжүүлэн, амжилттай яваа байгууллагуудын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, ИНИЙГМИЙН залуу эмэгтэйчүүдийн Манлайлын хөтөлбөрийг бий болгож, хөдөлгөөний хэмжээнд бодлого, стратегитай ажиллах нь бидэнд байгаа томоохон боломж юм хэмээн оролцогчид дүгнэн хэлэлцлээ.

## 2) САН БҮРДҮҮЛЭЛТ Салбар хуралдааны дүгнэлт

Чиглүүлэгчид: П.Золзаяа, Батхишиг

Салбар хуралдаанд нийт 25 хүн оролцсон. Оролцогчдыг 5 бүлэгт хуваан дараах асуудалд төвлөрч хэлэлцэж, доорх саналыг гаргасан.

1. Эмэгтэйчүүдийн хөдөлгөөний санхүүжилтийн нөхцөл байдлаа эргэн харж, дүгнэлт хийх.
2. Бид цаашид яах вэ? Юун дээр анхаарах вэ? Ямар боломж байна вэ?

Эмэгтэйчүүдийн хөдөлгөөний санхүүжилтийн нөхцөл байдал:

Олон улсын донорууд иргэний нийгмийн байгууллага, эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг дэмжих шууд санхүүжилтээ эрс багасгаж, дэмжлэг үзүүлэхээ больсон. Бид өнгөрсөн хугацаанд донор байгууллагаас маш хамааралтай, энэ нь үргэлж үргэлжлэх мэт төсөөлж, ажиллаж байсан байна. Гэвч нөхцөл байдал өөр болж байна. Донор байгууллагууд Засгийн газартай гэрээлж байна. Мөн олон улсын байгууллагатай шууд гэрээлж, хамтран ажиллаж байна.

Иргэний нийгмийн байгууллагууд, эмэгтэйчүүдийн хөдөлгөөний хувьд санхүүжилтгүй болж байна. Санхүүжилтгүй учраас үйл ажиллагаа явуулах боломжгүй байдалд хүрээд байна. Бид энэ хэвээр байвал цаашид оршин тогтнох эсэх асуудал хүртэл яригдана.

Бид цаашид яах вэ?

Бид өнгөрсөн хугацаанд төрийн хийх ёстой ажлыг өмнөөс нь хийж, төрийн ачааг нуруун дээрээ үнэ хөлсгүй үүрч явсан. Харин бид одоо өөрсдийгөө үнэлэх цаг нь аль хэдийн болсон.

Үйл ажиллагаагаа тогтвортой явуулахын тулд бидэнд санхүүжилт хэрэгтэй. Мөнгө хаана байна төрд байна. Төр нэгэнт хийж чадахгүй, хүрч чадахгүй байгаа ажлаа иргэний нийгмийн байгууллагатай гэрээлэн гүйцэтгүүлэх ёстой. Санхүүжилт өгөх ёстой.

Гэвч төртэй бид ойр ажиллаж, нэвтэрч чадахгүй байна. Хамтын түншлэлээ хөгжүүлэхийн тулд өөрсдийгөө бэлтгэх, анхаарах зайлшгүй шаардлагатай байна.

1. Иргэний нийгмийн байгууллагууд, эмэгтэйчүүдийн хөдөлгөөн маш сайн чадавхижих шаардлагатай байна.

2. Бид маш их салангид ажиллаж байна. Нэг нэгнийгээ хүлээн зөвшөөрч, хамтран ажиллах шаардлагатай байна.
3. Аливаа асуудалд дүн шинжилгээ хийх чадвараа сайжруулах хэрэгтэй байна.
4. Нэгдсэн стратегитай байх хэрэгтэй байна.
5. Төрийн төсөвт чиглэл, чиглэлийнхээ дагуу хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.
6. Хариуцлагатай хандах хэрэгтэй байна. Санхүүжүүлэгчийн шаардлагыг хариуцлагатай биелүүлж, үйл ажиллагаа нь илүү үр дүнд чиглэсэн байх, мөн эргэх холбоотой ажиллах, гэрээлэн гүйцэтгэж байгаа үйл ажиллагаагаараа дамжуулж чадавхитай гэдгээ баталж харуулах, хариуцлагатай тайлагнах үйл явцад суралцах шаардлагатай байна.

Ямар арга зам, боломж байна вэ?

1. Хамгийн чухал нь иргэний нийгмийн байгууллагууд эвлэлдэн нэгдэх, хамтын шинэ стратегийг боловсруулан хэрэгжүүлэх;
2. Өөрсдийн сайн туршлагаа баримтжуулан баталгаажуулж, иргэний нийгмийн байгууллагууд хоорондоо төдийгүй төрд сурталчилан таниулж, хүлээн зөвшөөрүүлэх,
3. Шинэ Засгийн газар ажиллаж байгаа энэ цаг үед баталсан бодлого, хөтөлбөрүүдтэй танилцаж, дүн шинжилгээ хийх;
4. Бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баталсан төсөв, санхүүг судлах;
5. Үүний дагуу цаг алдалгүй төрд нөлөөлж, гэрээлэх, хамтын ажиллагааг эхлүүлэх;
6. Төртэй гэрээлэхдээ 3 жил хүртэл хугацаанд гэрээлэн ажиллахаар зөвшилцөж, гэрээгээр баталгаажуулах;
7. Тойргоос болон орон нутгаас сонгогдсон УИХ-ын гишүүдтэй уулзаж нөлөөлөл хийх;
8. Мөн төсвийг нийслэл болон орон нутагт шилжүүлж байгаа учраас "Бай"-гаа зөв онож, шийдвэр гаргах түвшний албан тушаалтай уулзаж, асуудлыг ойлгуулж, хамтран ажиллах;
9. Улс орон хямралтай байгаа энэ тохиолдолд бүтээгдэхүүн хоорондын солилцоог хөгжүүлэх;
10. Өөрсдийн хийсэн бүтээгдэхүүнийг бодитоор үнэлж, нийгмийн болон эдийн засгийн зах зээлд нийлүүлэх. Ингэхдээ социал медиаг жинхэнэ утгаар нь ажиглах;
11. Маркетингээ хөгжүүлэх;

### 3) "Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг бэхжүүлэх нь" салбар хуралдааны дүгнэлт

*Чиглүүлэгч: Д.Бүжин, Дорнод аймгийн ИНБ-уудын зөвлөлийн дарга, ЛЭОС-ийн удирдах зөвлөлийн гишүүн*

"Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг бэхжүүлэх нь" салбар хуралдаанд орон нутгийн эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллага, сүлжээ, бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо зэрэг байгууллагуудын төлөөлөл болох 19 хүн оролцсон.

Оролцогчдыг 3 багт хувааж доорхи асуудлын дагуу ярилцаж санал бодлоо солилцсон. Үүнд:

- Эмэгтэйчүүдийн хөдөлгөөний амжилт
- Эмэгтэйчүүдийн хөдөлгөөний тулгамдаж буй асуудал
- Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг шинэ шатанд гаргаж тавихад юу хийх вэ, яаж бэхжүүлэх вэ?

Эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд хүний эрх, эрх чөлөө, жендерийн эрх тэгш байдлыг хангахын тулд эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг газар бүр өрнүүлж, үйл ажиллагаа нь өргөжин тэлж, нийгэмд тодорхой хэмжээгээр танигдаж байна.

Хэдийгээр Эмэгтэйчүүдийн хөдөлгөөн газар бүр өргөжиж идэвхижиж байгаа боловч өнөөдөр Монголын нийгэмд охид, эмэгтэйчүүдийн эрхийн асуудал хангагдахгүй олон зөрчил, хүндрэлтэй асуудлууд хэвээр байна.

Ийм учраас салбар хуралдаанд оролцогчид эмэгтэйчүүдийн хөдөлгөөний өмнө тулгамдаж буй асуудлыг хамтдаа ярилцаж шийдвэрлэх арга зам, яаж хөдөлгөөнөө бэхжүүлэх талаар санал бодлоо солилцлоо.

### **1. Эмэгтэйчүүдийн хөдөлгөөний өмнө тулгамдаж буй асуудал:**

Үүнд:

- Зарим эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын хооронд улс төржсөн хандлага байдаг, эвсэж хамтарч ажиллаж чаддаггүй, бие биенээ үгүйсгэж өрсөлдөгч гэж үздэг
- Мэдээллийн сүлжээ хангалтгүй, мэдээллээ солилцдоггүй
- Төрийн өөрийнх нь байгуулсан болон кармааны төрийн бус байгууллагууд байдаг учраас төрийн зүгээс дэмжлэг тааруу байдаг
- Төрийн алба улс төржиж, сонгуулийн дараа халаа сэлгээ их хийгдэж байгаагаас төрийн байгууллагад ажиллаж буй албан хаагчдын ажлын байр тогтворгүй болж төр, ИНБ-ын хамтын ажиллагаа үр дүнгүй болдог
- Бизнес инкубатор шиг шинээр байгуулагдаж буй ТББ-ыг бойжуулдаг төвтэй байх
- ТББ-уудын үйл ажиллагаа тогтвортой биш, санхүүжилт олдсон үед төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, баяр ёслолын үйл ажиллагаа тэмдэглэхээс хэтрэхгүй байна
- Эмэгтэйчүүдийн ТББ-уудын салбарууд орон нутагт тогтвортой ажиллахгүй байна
- Эмэгтэйчүүдийн байгууллагууд бусад сайн дурын хөдөлгөөн, бүлэг, эвсэл, иргэний нийгмийн байгууллагууд хоорондын харилцаа холбоо тааруу байна
- Эмэгтэйчүүдийн хөдөлгөөн хот суурин газар болон аймгийн төвөөс алс хол зайд байгаа охид эмэгтэйчүүдэд хүрэхгүй байна
- Хийж буй ажлынхаа талаар бусад байгууллагуудад тайлагнах ажил хангалтгүй байна
- Зорилго чиглэлийнхээ хүрээнд үр дүнтэй, тууштай хамтарч ажиллах талаар сул байна.
- Охид эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар хөдөө суманд амьдарч буй эмэгтэйчүүдийн мэдлэг мэдээлэл хангалтгүй байдаг.
- Эмэгтэйчүүдийн хөдөлгөөний манлайлагч нар залуу үеэ бэлтгэх талаар хангалтгүй ажилладаг гэх мэт олон асуудлуудыг гаргаж тавьсан.

### **2. Салбар хуралдаанд оролцогчид эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг шинэ шатанд гаргах, яаж эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг бэхжүүлэх талаар доорхи саналуудыг гаргасан.**

Үүнд,

- Эмэгтэйчүүдийн хөдөлгөөн зорилго, чиглэлээ тодорхой болгож, зорилгодоо хүрэхийн тулд зөв төлөвлөлт хийх хэрэгтэй.
- Үндэсний хэмжээний болон орон нутгийн хөдөлгөөнүүд зорилго чиглэл, явуулах үйл ажиллагааныхаа хүрээнд ямар байгууллага, бүлэг, сүлжээ, холбоо, хувь хүнтэй ажиллах талаар судалгаа хийх
- Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнүүд өөрсдийн шийдвэрлэх гэж байгаа асуудлынхаа талаар үнэн зөв тоо баримт, судалгаа, хууль, дүрэм, журмын талаар мэдээлэлтэй байх, шаардлагатай тохиолдолд суурь судалгааг шинэчлэн хийх
- Хөдөлгөөнүүд хамтын ажиллагаагаа өргөжүүлж бусад байгууллагуудтай хүчээ нэгтгэх, зорилгодоо хүрэхийн тулд байнгын тасралтгүй ажиллагаатай байх
- Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнүүд охид, эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар илүү мэргэшиж ажиллах, сайн дурын ажилтан нарынхаа мэдлэг чадварыг дээшлүүлэх
- Төрийн байгууллагын чиг үүргийн дагуу хийх ёстой үйлчилгээний ажлуудыг авч хийхээсээ илүү өөрсдийнх нь үүрэг хариуцлагыг сайжруулах талаар нөлөөллийн ажлуудыг хийх
- Төсвийн хөрөнгийн зарцуулалт, хууль дүрэм, журмын биелэлтэнд байнгын хяналт үнэлгээний ажлуудыг хийж, холбогдох газруудын үүрэг хариуцлагыг сайжруулах,
- Төрийн байгууллагын бодлого төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлийн бүх шатанд орж ажиллах, хяналтаа тавих
- Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг бэхжүүлэхийн тулд төрийн болон ТББ, иргэдийн хөдөлгөөнтэй хүчээ нэгтгэж, хамтран ажиллах
- Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнд нэгдэж, үр дүнтэй ажиллаж буй хөдөлгөөний талаар бусдад түгээн дэлгэрүүлэх
- Дэлхийн эмэгтэйчүүдийн хөдөлгөөнтэй үйл ажиллагаагаа нэгтгэх, суралцах, хамтран ажиллах, туршлага судлах
- 

### **Дүгнэлт:**

Монгол оронд Иргэний нийгмийн байгууллагын үндэс суурийг тавихад эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. 1990 онд эхэлсэн ардчилсан өөрчлөлтийн үр дүнд олон арван төрийн бус байгууллагууд байгуулагдаж нийгмийн өөрчлөлтийн төлөө оруулсан хувь нэмрийг үнэлж баршгүй. Тэдний нэг хэсэг болох эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагууд нийгмийн өөрчлөлт, охид эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар үйл ажиллагаагаа явуулж, нийгэмд хэдийнээ танигдсан байна.

2008 оноос хойш эмэгтэйчүүд сүлжээ, бүлэг, холбоо, клуб зэргээр нэгдэж хамтран ажилласаар нилээдгүй хугацаа өнгөрч байна. Эмэгтэйчүүд хүчээ нэгтгэж тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхийн тулд үр дүнтэй олон ажлуудыг хийж, төрийн зарим ачааг хамтдаа үүрэлцэж байна. Хэдийгээр эмэгтэйчүүдийн хөдөлгөөн газар бүр өрнөж амжилттай ажиллаж байгаа боловч бид цаашид

хөдөлгөөнөө улам бэхжүүлж, нийгмийн өмнө тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэж, илүү их үр дүнд хүрэх зайлшгүй шаардлагатай байна.

Тийм учраас эмэгтэйчүүдийн хөдөлгөөнөө бэхжүүлэхийн тулд зорилго чиглэл, асуудлынхаа хүрээнд бусад байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, хүчээ нэгтгэж ажиллах хэрэгтэй юм. Мөн эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг алслагдсан зах хязгаар нутагт хүргэх, охид эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар мэргэшиж ажиллах, төрийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд нөлөөллийн ажиллагаа явуулах зэрэг ажлуудыг байгаа газар бүртээ санаачлан хариуцлагатай ажиллах нийгмийн хэрэгцээ шаардлага байгаа талаар салбар хуралдаанд оролцогчид онцлон тэмдэглэлээ.



## НЭГДСЭН ХУРАЛДААН: ХӨДӨЛГӨӨН ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮҮЛЭХ НЬ

### ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХӨДӨЛГӨӨН БОЛОН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ

П. Цэвээн, МХЭҮТөвийн тэргүүн, ХХҮС-ний зохицуулагч

Хүүхэд хамгааллын сүлжээ гэдэг гол нь ямар зорилготой байгуулагдсан вэ? гэвэл энэ сүлжээ хүүхдийн эрх, хамгаалал гэдэг 2 үгийг арай өөр утгаар нь хэвшүүлж, ойлгуулахын төлөө ажилладаг. Хүүхдийн эрх гэдэг нэг ойлголт юм, хүүхдийн хамгаалал гэдэг ялгаатай өөр нэгэн ойлголт юм. 2016 онд Хүүхэд хамгааллын хууль батлагдсан. Хүүхдийн эрхийн асуудалд ахиц дэвшил гарсан жил болон өнгөрч байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын/НҮБ/ Хүүхдийн эрхийн конвенцид Монгол улс 1990 онд нэгдсэнээс хойш бие даасан хуультай болж, анх удаа Хүүхдийн эрхийн тухай хуулийг баталсан. **Хүүхэд гэж хэн бэ?** Хүүхэд гэдэг бол НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцид зааснаар 0-18 насны эрэгтэй, эмэгтэй хүүхдийг хэлнэ гэж заасан байдаг.

**Хүүхдийн** тухай ярихдаа яагаад үүрэг гэж ярихгүй, эрх гэж ярьдаг юм бэ? **Хүүхэд гэдэг бол эрх эдлэгч, бид бол үүрэг хүлээгч.**

Хүүхдийн эрх? Хүүдийн хамгаалал гэдэг нь тэгвэл ямар зүйлийг хэлэх вэ? Хүүхэд бол өөрөө 4 багцаар хамгаалагддаг байна. Үүнд: 1.Эсэн мэнд амьдрах, 2. Хамгаалуулах 3. Хөгжих, Оролцох эрхтэй.



Тэгэхээр бид хүүхдээ энэ түвшинд харж хамгаалж, энэ багцад барьж явах үүнийгээ чиг үүрэг болгож байна уу? гэдэг талд дээр анхаарч ажиллах. Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн

бүх орчинд хамгаалагдах эрхтэй.

Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн эрхийг зөрчсөн тохиолдолд хүүхэд тэдэнтэй хууль ёсны харилцаагаа зохих журмын дагуу зогсоох, таслах, тухайн нөхцөл байдал арилсан тохиолдолд уг харилцаагаа сэргээх эрхтэй.

Хүүхэд өөрийн нэр төр, гэр бүлийн амьдрал, эрүүл мэнд, хувийн харилцааны нууц, орон байрны халдашгүй байдал, **хувийн орон зайгаа** хамгаалуулах эрхтэй.

Хүүхэд эрхээ зөрчигдсөн тохиолдолд өөрөө болон итгэмжит төлөөлөгчөөрөө дамжуулан үндэсний болон олон улсын холбогдох байгууллагад гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрхтэй.

Эцэг, эх гэдэг бол хүүхдээ бүгдээс илүү хамгаалдаг гэж бодож байгаа боловч өнөөдөр хуулиндаа эцэг эх өөрөө хүүхдийнхээ эрхийг зөрчөөд байх юм бол бид тусгаарлах ёстой байдаг гэдгийг заагаад өгсөн. Хүүхэд өөрөө хэсэг хугацаанд тусдаа байх хүсэлт гаргаж оролцоогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлжээ. Дараагийн нэг асуудал бол хүүхэд маань тэр тусмаа охидууд маань нь бэлгийн хүчирхийлэлд илүү их өртөж байна. Тэр тусмаа ураг төрөл, садан төрөл, тэр ч байтугай төрсөн эцгийнхээ хүчирхийлэлд өртөж байна. Тэгвэл бид **хувийн орон зай** гэдгийг анх удаагаа хуулинд оруулсан. Хувийн орон зайд эцэг эх, эмч хүрнэ өөр хэн ч хүрэхгүй. Тэр байтугай дотуур хувцсанд хэн хүрэх гэдэг асуудлыг хувийн орон зай гаргаж өгснөөр бид охидоо хамгаалах боломжтой болж байна.

Хүүхдийн эрхийн конвенцид Монгол улс нэгдэн орсоноор манай улс хүүхдийн эрхийн асуудлаа шийдэж чадахгүй бол олон улсын Хүүхдийн эрхийн хороонд саналаа явуулж тэндээс эксперт авчирч өөрийнхөө асуудлыг шийдүүлэх эрхтэй гэж заасан.

**Хүүхэд хамгаалал гэж юу вэ?** Дарамт гэж юу вэ? Хүчирхийлэл гэдгийг юу гэж ойлгох вэ? Мөлжлөг гэдгийг юу гэж ойлгох вэ? Хүүхэд хамгаалал гэдэг нь хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг,



хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх олон талын оролцоо бүхий мэргэшсэн цогц үйл ажиллагаа мөн. Бүх асуудал нэг дор явагдаад өнгөрч байгаа энэ процессыг хүүхэд хамгаалал гэнэ. Яаж хамгаалах юм бэ? Бид нар та бүгдийн оролцоотойгоор хамтын ажиллагаатай мэргэшсэн цогц үйлчилгээ хийдэг болсон. Энд нэг хүн хүүхдийн эрхийг мэддэг гээд дангаар хийх

боломжгүй болсон. Магадлан итгэмжлэлд орно. Би чадаж байна гэж үзвэл төрийн үйлчилгээг авна гэдэг ийм шинэ зарчимтай болсон.

**Хүүхэд хамгааллын үйлчилгээний тогтолцоо** -нд хамрах хүрээг гаргаснаараа онцлог. Өнөөдөр сургууль дээр хүүхэд зодуулсан байвал сургууль хариуцлага хүлээх, эрүүл мэндийн үйлчилгээ, хэвлэл мэдээлэл, олон нийт арга хэмжээнд анхаарах.

Эмэгтэйчүүдийн болон хүүхдийн байгууллагуудын хамтран харах өнцөг бол Охидын асуудал. Бид охидыг ямар өнцгөөс харж байна. Вэ? Хүчирхийлэлд өртөж байгаа талаас уу? Өнөөдөр өсвөр насны охид маань хүсээгүй жирэмслэлтийн улмаас үр хөндүүлж байна уу? , Өсвөр насандаа ээж болсон охидод ямар асуудал байна вэ? Мөн охид архи, тамхи, мансууруулах бодисонд донтож байна уу? Хүний наймааны хохирогч болж байна уу зэрэг маш олон асуудал байна. Жишээ нь охидын асуудлаар хийсэн судалгаа байна уу? Тэдний хэрхэн хамгаалах ёстой вэ? Тэдэнд тулгамдаж байгаа асуудал, хамгаалуулах шаардлага, хүйсийн талаасаа ямар онцлогтой вэ?

Охид гэж хэн бэ? асуувал магадгүй 10-18 гэж хариулахыг үгүйсгэхгүй. Гэтэл 4, 5, 6 настай охид бэлгийн хүчирхийлэлд өртөөд байгааг юу гэж харах вэ? Охидын эрх гэдгийг ялгавартайгаар харах шаардлага байна уу? Гэтэл бид дагнасан, нэрлэсэн, олон төрлийн судалгаанд охидын талаарх аливаа асуудлыг тусгайлан, товойлгон гаргаж байна уу? Энэ асуудал дээр тулгуурлан яривал гаргавал бидний хамтран ажиллах үндсэн чиглэл маань гарах магадлалтай. Дээрх асуудал руу чиглэж ажиллавал бид охидын аливаа асуудал дээр ойлголт хандлагаа нэг болгох, арга зүй туршлагаа нэгтгэж мэргэшсэн цогц үйлчилгээ үзүүлэх боломжтой.

## ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-ТУЛГАМДСАН АСУУДАЛ-ХАМТЫН ШИЙДЭЛ

*Н.Баярсайхан , Хил хязгааргүй алхам ТББ-ын Захирал*

Бид асуудлыг Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудал болон хамтын шийдлүүдийн ямар асуудал байх вэ, хоорондоо ямар хамааралтай вэ? Гэдгийг авч үзсэн.

**Нэгдүгээрт, байгаль орчны салбарт:** Агаарын бохирдол, уур амьсгалын өөрчлөлт, уул уурхайн сөрөг нөлөө, бэлчээр хөрсний доройтол, цөлжилт, усны болон ойн хомсдол, засаглалын хямрал чадавхи,

**Хоёрдугаарт, нийгмийн салбарт:** Ядуурал , ажилгүйдэл , эрүүл мэндийн хамгаалалт хангалтгүй , эх хүүхэд, эрх мэдэл багатай хэсэг хүчирхийлэлд өртөмтгий байна. Хүний эрхийн болон хүний эрхийг хамгаалагчийн хамгаалал/ИН-ийн таагүй орчин, Засаглал, шийдвэр гаргах түвшний авилга, хүнд суртал, хямрал зэргийг нилээд тогтвортой хэлэлцсэн үндсэн дээр үе шатуудыг гаргаж ирсэн.

**Тогтвортой хөгжил** гэдгийг улс орон эдийн засгийн агуулгаар харж байсан бол сүүлийн жилүүдэд дэлхийн нийтэд 1970 оноос байгалийн нөөцөд түшиглэсэн байгаль экологийг хайрлах хамгаалах замаар тогтвортой хөгжлийг бий болгох ёстой гэсэн тэр өнцгөөс харж байна. Хөгжил гэдэг бол байгаль орчноос салангад ойлголт биш юмаа. Тэгэхээр **нийгмийн хөгжил, эдийн засгийн хөгжил, байгаль орчны хөгжил огтлолцол бол тогтвортой хөгжил** юм аа. Энэ гурвыг салангад авч үзэх юм бол хөгжил гэдэг юм бий болохгүй.

Үе хоорондын нөөц шударга ёс: өмнөх үе, одоо үе, хойч үе

**Үе хоорондын** асуудлыг гаргаж өгч байгаа. Өнөө үеийнхэн өнгөрсөн үеэсээ ямар экологи, эдийн засгийн загварыг хүлээж авсан юм вэ? Хойч үе ирээдүйнхээ эрхийг хөндөхгүй байх ёстой юм. Ирээдүйнхээ эрх, боломжийг өнөөдөр хязгаарлахгүй байх ёстой юм гэдэг ийм ойлголтоор тогтвортой хөгжилд хандаж байгаа. Байгаль орчны ТББ-ууд зөвхөн байгалиа хамгаалдаг ууган төрхөөр нь хадгалаад хойч үедээ үлдээх үзэл санаа үзэл баримтлалтайгаар үнэт зүйлээ болгож явж байсан юм бол одоо энэ биш юмаа. Тэгэхээр өнөөдрийг хүртэл байгаль орчны байгууллагуудын хөгжлийн асуудлыг танилцуулъя:

Байгаль орчны ТББ-ууд үүсэл, хөгжил 5 үе шаттайгаар хөгжиж ирсэн байна. Үүнд:

**1-р шат: 1990 он хүртэл.** Ойн нөхөрлөл, ТХГН-ийн асуудлаар цөөн бүр ТББ. (МБХХ)

**2-р шат: 1993- 2002 оныг хүртэл.** "АЛТ" хөтөлбөр хэрэгжсэнтэй холбоотой. (АР: Цэнхэр нутгийн дуудлага, Онги голынхон хөдөлгөөнүүд)

**3-р шат: 2002-2010 он.** Гол нуур дагасан уул уурхайн хууль бус үйл ажиллагааг эсэргүүцсэн уугуул иргэдийн үүсгэл санаачлага бүхий 8 аймгийн 12 хөдөлгөөн, тэд эвсэл сүлжээ, холбоонд нэгдсэн, (БОХТББ-уудын холбоо. МНМЭ, ТАН)

**4-р шат: 2010-2013 он.** Усны, ойн, уул уурхайн, Иргэний оролцоо, салбарын ил тод нээлттэй байдал гэх мэт мэргэшиж, бодлогын нөлөөлөл, төлөөлөн нэхэмжлэх шүүхэд хандах, стратегийн өмгөөлөл хийх, гарын авлага удирдамж болосвруулах зэрэг төрөлжиж эвсэл холбоод болсон. (МБОИЗ, ХЭТТБФ, Хүнс Эвсэл)

**5-р шат: 2013 оноос хойш.** ОУ-ын байгууллага, ХЭ-ийн хороод, ОУСК-д хүргэх, ХЭҮК нөлөөлөл, засаглалд нөлөөлөл хийх хууль гаргах, хэрэгжилтэд үнэлгээ өгөх, эвсэл холбоод илүү нарийсан асуудлаар ажиллах ( МБОИЗ- 700, ТАН-30, ГННХ- 20, ГНХ- 20 )

Энэ үеэс ТББ-ууд бодлогын нөлөөлөл хийх гэсэн илуу уул уурхайн кампаниудтай, газар тариалан эрхлэгчидтэй, мянгат малчидтай ажиллаж эхэлсэн. Байгаль орчны асуудлаар ажиллахад хүний эрхэд суурилсан хандлагаар хандах хэрэгтэй юм гэдгийг бид ойлгож хүний эрхийн ТББ-тай нэгдэж хүний эрхэд суурилсан хандагыг түгээн дэлгэрүүлэхийн төлөө ажиллаж байна.

Байгалийн нөөцийн эх үүсвэр нь нийгмийг ядуурлаас гаргах, тогтвортой хөгжлийн баталгаа тул түүний ил тод нээлттэй байдлыг хангах, иргэд иргэний нийгмийн байгууллагын үнэн зөв, бодитой мэдээлэлтэй хяналт дор үр ашигтай зарцуулдаг байхад, байгалийн нөөцийг барьцаалсан аливаа зээл, хөрөнгө босгох, түүнийг зарцуулах шийдвэрт хүчтэй нөлөөлөл чадавхаа хамтдаа эрс нэмэгдүүлэхэд тууштай, тогтвортой хамтран ажиллах хэрэгтэй байна.

## ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ДҮР ТӨРХ БА ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

*Т.Аюушжав, Глоб Итернэйшнл Төв ТББ-ын Хэвлэл мэдээллийн хөтөлбөрийн ажилтан*

Би эхлээд та бүхэнд Глоб Интернэшнл Төвийн талаар товч танилцуулъя. Тус төв нь 1999 онд байгуулагдсан. Манай үзэл баримтлал: Мэдээлэлтэй иргэн хүчирхэг. Иймээс мэдээллийн боломжит бүх сувгийг ашиглан иргэдэд мэдээлэл түгээх манай үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг юм.

Дараахь гурван стратегийн хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

1. Хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих - Хэвлэл мэдээлэл өөрөө хараат бус улс төр, эдийн засаг, бизнесийн аливаа бүлгээс ангид байж иргэдэд үнэн зөв бодит мэдээлэл өгдөг.
2. Ил тод, сайн засаглалыг дэмжих
3. Мэдээллээр дамжуулан иргэдийг чадавхжуулах

1-р хөтөлбөрийн хүрээнд Жендэр ба хэвлэл мэдээлэлтэй холбоотой асуудалд 2001 оноос анхааралаа хандуулан дараахь төслүүдийг хэрэгжүүлсэн юм. Үүнд: Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээ хийх турших төсөл хэрэгжүүлээд зөвлөлдөх уулзалтаар оролцогсдын саналаар MYONТелевиз, UBS телевиз, Монголын сэтгүүлчидын нэгдсэн эвсэл гурван байгуулагуудын жендэрийн цогц үнэлгээ хийсэн. 2017 онд цогц үнэлгээнээс гарсан зөвлөмжүүдээ хэрэгжүүлэхэд 3 байгуулагадаа жендэрийн бодлогын үйл ажиллагаа нэвтрүүлэхэд техникийн туслалцаа үзүүлнэ.

MYONТелевиз, UBS Телевизийн жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт бодлого, үйл ажиллагаа, бичиг баримт, хөдөлмөрлөх орчин, цалин хөлсний асуудалд ямар байна гэдэг үнэлгээ хийхээс гадна санамсаргүй түүврийн аргаар сонгосон цаг үеийн мэдээны агуулга цагийн хүрд, UBS телевизийнн жендэрийн дүр төрх-д нь үнэлгээ хийсэн. Эдгээр үнэлгээнээс доорх санал зөвлөмж гарсан. Үүнд:

- Жендэрийн бодлоготой байх
- Ёс зүйн код батлах хэрэгтэй юм байна
- Эмэгтэй, эрэгтэйчүүдийн төлөөллийн тэнцвэртэй байдлыг хангах
- Мэдээ нийтлэлийн агуулгыг жендэрийн мэдрэмжтэй болгох гэсэн зөвлөмжүүд өгсөн.

Жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу хэвлэл мэдээлэл дэх эмэгтэйчүүдийн эерэг дүр төрх гэж юу вэ? яаж авч үздэг юм "А", "Б" 2 ангилалтай

Цаг үеийн мэдээний хөтөлбөрт -Улс төр, эдийн засаг, нийгмийн асуудлыг мэдээлэхдээ

Эмэгтэй, эрэгтэйчүүдийн төлөөлөл тэнцвэртэй - Сэтгүүлч ярилцлага авахдаа

Жендэрээр ялгаварлан гадуурхахгүй;

Хэвшмэл ойлголтоос ангид;

Жендэрийн тэгш байдал, тэгш эрхийн талаарх мэдээ сурвалжлага хийж байна уу

Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх мэдээ сурвалжлага жендэрийн мэдрэмжтэй. Хүмүүсийн зөвшөөрөлтэй, хувийн орон зайд халдахгүй байх.

2-рт нь Зар сурталчилгааны агуулга. Энэ нь Шударга дүр төрх (тоон харьцаа тэгш, ажил мэргэжлийн байдал, хүлээсэн үүрэг, зан араншин шинж чанараар ялгаварлан гадуурхахгүй байх)

Жендэрт суурилсан хэвшмэл ойлголтоос ангид байх.

Асуудал, бэрхшээлийн тухайд авч үзвэл эмэгтэйчүүдтэй холбоотой мэдээлэл харьцангуй бага, жендэрийн тэнцвэр байдлыг хангах явдал хангалтгүй; агуулгын хувьд патриархат шинжтэй; эмэгтэйчүүдийг жендэрээр ялгаварлах хандлага давамгайл, мэдээллийн эх сурвалж сэтгүүлч өөрөө болдог, тиймээс хувь хүний хандлага, үзэл бодол илэрхийлэгдэж, мэдээлэл нь өрөөсгөл болдог. Манай ихэнх сэтгүүлчид жендэрийн мэдрэмжгүй байдал ажиглагддаг, ярилцлага авахдаа тайлбарлаад байхад асуудаг. Ялангуяа зар сурталчилгаанд хэвшмэл ойлголтыг лавшруулдаг.

Эмэгтэйчүүдийн тухай материалын өнгө аяс (судалгаанаас) гүйцэтгэх үүргээр нь, зан араншин шинж чанаар нь ялгаварлан гадуурхдаг.

Харин эмэгтэйчүүдийн эрхийн байгууллагуудын хувьд? ХМХ-тэй ажиллахдаа - дамжуулагч хэрэгсэл, нийгэм дэх сургалт сурталчилгаа хангалтгүй, идэвхтэй хамтын оролцоо хэрэгтэй.

## ХҮНИЙ ЭРХИЙН САЛБАРТ МОНГОЛЫН ТББ-ЫН ОРОЛЦОО

*Б.Хишигсайхан, Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын хөтөлбөрийн менежер*

Эмэгтэйчүүдийн талаар статистикийн товч мэдээллийг та бүхэнд хүргэе.

Хүний эрхийн ТББ-ын форум гэж ямар бүтэцтэй, ямар үйл ажиллагаа явуулдаг хөдөлгөөн вэ? танилцуулъя. 2010 онд байгуулагдсан. Нэгдэх болсон шалтгаан нь Хүний эрхийн зөвлөлд явуулах тайлан илтгэл маш олон салбарын асуудлууд байсан. Гэтэл нэг ТББ ганцаараа сууж тайлан бичих боломжгүй байсан. Тэгэхээр нэгдэж байгаад тодорхой асуудлаар хамтарсан мэдээлэл явуулах нь зүйтэй юмаа гэсэн стратеги баримталсан. Энэ үйл ажиллагаанд Форум Ази байгууллага тухайн үед ихээхэн үүрэг гүйцэтгэсэн. Яаж тайлан илтгэл хамтарч явуулдаг туршлагаасаа хуваалцсан.

Үүний тулд Монголын Хүний эрхийн 30-аад байгууллага эвлэлдэн нэгдэж анхны үүсэл санаачлагыг байгуулсан. Анхны байгуулагдсан гол шалтгаан нь Хүний эрхийн хэрэгжилтийн механизмд нөлөөлөх нь Монголын ТББ байгууллагууд ажиллах ёстой юм байна гэдгийг хэлж байсан.

Монгол улс маань өөрөө нилээд тодорхойгүй байр суурьтай байсан. Энэ үүднээс зөвлөлдөх нөлөөллийн үйл ажиллагааг өөрийнхөө улсад өрнүүлэх ёстой юм байна гээд энэ чиглэлээр 2013 оноос нилээд эрчимтэй ажиллаж байгаа. Тэгээд бид нар зөвлөлдөөд тайван замаар асуудлыг шийдээд яваад байсан чинь бас болохгүй байсан. Манай төр засаг байж байгаад ямар нэгэн шийдвэрээ гэнэтийн гаргадаг. Гэнэт гаргаж байгаа шийдвэр нь ямар учиртай, ямар судалгаа шинжилгээн дээр тулгуурлаж байгаа нь тодорхойгүй.

### ДЭЛХИЙН СТАТИСТИКТ ЭМЭГТЭЙЧҮҮД

- Нийт газар эзэмшигчдийн **1%**.
- Ядуурлын түвшинд амьдарч буй **1 тэрбум** хүний **70%**.
- Нийт эмэгтэйчүүдийн **47%** хөдөлмөр эрхэлж, эрэгтэйчүүдээс **25-40%** бага хөлс авдаг.
- Хөлсгүй гэрийн хөдөлмөрийн **62%**.
- **173** улсын **155** улсад эмэгтэйчүүдийн эдийн засгийн боломжийг хязгаарласан ядаж нэг эрх зүйн зохицуулалт байна.
- Өдөр бүр төрөхийн хүндрэлээр **1 440** эмэгтэй нас барж байна.
- **3** эмэгтэй тутмын **1** нь хүчирхийлэлд өртдөг.
- Амь насаа алдсан эмэгтэйчүүдийн **38%** хамтран амьдрагчийнхаа гарт амь үрэгджээ.
- Нийт менежерийн **21%**.
- Нийт парламентын гишүүдийн **22%**.

<https://www.womankind.org.uk>  
<http://www.independent.co.uk>

**ШИНЭ** СӨРИЛТ  
СТРАТЕГИ  
ЧУУЛГА УУЛЗАЛТ

Янз бүрийн байдлаар асуудлаар шийдвэрүүд гараад байгаа нь өөрөө хүний эрхэд суурьлаагүй учраас буцаад маш их үр дагаварыг бий болгох гээд байдаг тул зөвхөн зөвлөлдөөд яваад байхаас илүү шаардлаг, зөвлөмж, асуулга хүргүүлж ажиллах хэрэгтэй гэдэг дээр нэгдсэн. Форумын үйл ажиллагаа нь үндсэндээ олон улсын түвшинд хийдэг нөлөөллөөс гадна үндэсний хэмжээний нөлөөллийн үйл ажиллагаанууд

үүний зэрэгцээ бид нар нөлөөллийн гэж харж байсан бол хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэж эхэлж байна.

Ерөнхийдөө бид нар НҮБ-ын хүний эрхийн зөвлөлд явуулсан хүний эрхийн төлөв байдлын мэдээлэлээр мэдээллийн хуудас бэлтгэдэг. Энэ мэдээллийг хүний эрхийн Зөвлөмжөөс авсан



зөвлөмжүүдтэй харьцуулвал бид ямар их хувь нэмрээ оруулж байгааг харах боломжтой. Яагаад гэхээр бид нарын гаргаж дэвшүүлэн байгаа асуудлууд, бэрхшээлүүд, зөвлөмжүүдийг НҮБ-ын гишүүн улсууд шууд тэр чигээр нь хүлээн авдаг. Нэг ёсондоо үг үсгийн найруулгын нь өөрчлөхгүйгээр манайд өгөгдөж байсан зөвлөмжүүд олон байгаа. Энэ бол бид нар өөрсдийгөө олон улсын тавцанд бий болгосон түүх гэж хэлж болно.

Түүнээс гадна бас нэг төвөгтэй механизм бол Гэрээний хороодод Засгийн газраас томилогдсон хүмүүс тэнд ажилладаг. Гэрээний хороод бол илүү хүний эрхийн чиглэлээр илүү мэргэшсэн хүмүүс байдгаараа онцлогтой. Гэрээний хороодод нөлөөлнө гэдэгт тийм итгэлтэй биш байсан. Хамгийн сүүлд бид нийгэм соёлын эрхийн хороонд явуулсан Зөвлөмж дээрээ “Бизнес өдрийн хоол” гэж хийгээд, хорооны гишүүдэд Монгол улсад нийгэм соёлын ямар тулгамдсан асуудлын талаар ярьсан. Дараа нь Монголын засгийн газрын төлөөлөгчидтэй засгийн газрын гишүүд уулзаж эхэлсэн. Үүний дараа хорооноос өгсөн дүгнэлт зөвлөмжид бид нарын хүсээд оруулаасай гэж бодсон зөвлөмжүүд өгсөн. Бид нар бол энэ төвшинд мэргэшсэн, чадварлагаар НҮБ-ын механизмд нөлөөлж чаддаг болсон. Энэ бол бид нарын энэ хугацаанд олсон гол амжилт.

Энэ үйл явцыг Форумын гишүүд гээд дөч, тавин байгууллагууд байгаа боловч Форумд идэвхтэй ажилладаг хөдөлгөөнүүд:

- Хүүхэд хамгааллын сүлжээ
- Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ
- Монфемнет
- Боловсрол эвсэл
- Хүнс эвсэл
- Байгаль орчны эвсэл
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эвсэл, холбоо нар идэвхтэй хамтран ажилладаг. Үүний үр дүнд дүгнэлт зөвлөмжүүд илүү яг амьдралд дээр тулгамдсан асуудалуудыг гаргаж ирдэгээрээ онцлогтой.

Миний итгэлийн хамгийн гол хэсэг нь бид нар бусад хөдөлгөөнтэй хамтран ажиллаж байгаа дээр ямар амжилт, сургамж байгаа дээр тулгуурлаж хэлий

Амжилт:

- НҮБ бид нарыг сонсдог болжээ
- Ямар нэгэн байдлаар Засгийн газартай зөвлөлдөг болсон
- Хүний эрхийн асуудлаар ОУ-ын болон үндэсний түвшинд хамтарсан нөлөөлөл хийх бид нараар дамжиж

Сургамж:

- Тогтвортой биш
- Нөөцийг үр дүнтэй ашиглаж чаддаггүй

## **САЛБАР ХУРАЛДААНЫ ДҮГНЭЛТҮҮД: ХӨДӨЛГӨӨН ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ**

### **1) Хүүхэд хамгаалал ба эмэгтэйчүүдийн хөдөлгөөний хамтын ажиллагаа- Салбар хуралдааны дүгнэлт**

*Чиглүүлэгч: П.Цэвээн, Л.Жаргалсайхан*

Охидын тухай ярихын тулд Хүүхэд гэдэг асуудлыг тодорцуулан харах нь зүйтэй байх. Учир нь Хүүхэд гэж хэн бэ гэвэл НҮБ-ын Хүүхдийн Эрхийн конвенцид 0-18 насны эрэгтэй, эмэгтэй хүүхдийг хэлнэ гэж заасан байдаг юм. Иймэс охидын асуудлыг ярихын өмнө Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын асуудлын эрх зүйн орчны тухай ярих гэсэн юм.

- “Хүүхдийн эрх тухай болон Хүүхэд Хамгаалалын тухай хуулийг 2016 онд батлагдаад одоо хэрэгжих шатандаа явж байгаа одоо сурталчлах өргөн олон түмэнд хүргэх шаардлагатай байна.
- Хүүхэд хамгааллын асуудал нь эрсдэлд нөхцөлд суурилсан хандлагаар мэргэшсэн үйлчилгээ үзүүлэх тогтолцоонд суурилсан байдлаар хандлага соёлыг бий болгох
- Хууль хэрэгжих орчин, нөхцөл байдалд мониторинг хийж дүгнэлт гаргах
- Эмэгтэйчүүдийн байгууллага, Хүүхэд хамгааллын сүлжээ хамтарч ажиллах
- Охидын талаархи гарч байгаа асуудлыг тодорхойлохын тулд Эмэгтэйчүүдийн Сан.ХХҮСүлжээ хамтарч асуудлаа өөрсдөөн боловсруулан Үндэсний хэмжээний судалгааг энэ ондоо багтаан хийх шаардлагатай. Энэхүү чуулганаар Шинэ Сорилт Шинэ Боломж гэж харвал Охидын талаархи асуудлын цөм асуудлыг олж харах нь чухал үүнийг хийсний дараа

**Ойлголт хандлага нэг болно.** /өнөөдөр хүн бүрийн гаргаж ирсэн асуудлууд цэгцлэгдэнэ

- Хандлага зөв тодорхойлж чадвал хэн юу хийх нь тодорхой болно.
- Арга зүй, туршлага нэгтгэх /давуу, сул тал/
- Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд зориулсан үйлчилгээг шинэ шатанд гаргах /
- Нийгмийн хүрээлэлээс зарим талаараа ангилагдаад байгаа охидын асуудалд анхаарлаа хандуулж нөлөөллийн үйл ажиллагааг шат дараатай хийж төрийн анхааралд аваачин шийдвэрлүүлэх/жишээ нь” 00” асуудал дотуур байрны асуудал гэж санал гарсан

Хүүхэд бол эрх эдлэгч Томчууд бид бол ҮҮРЭГ ХҮЛЭЭГЧ гэж тодорхойлогдсон байдаг. Үүрэг хүлээгч нарын хувьд хүүхдүүдийн хувьд ижил тэгш хариуцлага хүлээх ёстой. Иймээс эмэгтэйчүүдийн нэг хэсэг бол ОХИД гэж үзвэл ямар хүрээлэлд энэ асуудлыг анхааралдаа авч ажиллах ёстой юм бол гэдэг дээр хүн бүр бодоосой, сэтгээсэй, хамтраасай гэж хүсч байна.

**Охид:**

Гэр бүлийн гишүүн

Гэр бүлийн боловсролыг иргэний боловсролтой холбох тусгай хөтөлбөрийг боловсруулах

- ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт оруулахаас өөр шинэлэг аргуудыг эрэлхийлэх /сошиал , хэвлэл мэдээлэл, гэр бүлийн радио/
- Судалгаа хийх /охидын тулгамдсан асуудлыг илүү тодорхойлох /
- Оролцоог тодорхойлох

Хамтын ажиллагаа/төр, иргэний нийгмийн байгууллага, олон нийт, гэр бүл /

Гэр бүл гишүүн хэмээн үзвэл:

Кейс: Одоо 11 дүгээр ангид сурдаг охины талаархи асуудал дээр анхаарлаа хандуулаад хамтын ажиллагаагаа тодорхойлох нь хамгийн ойлгомжтой байх. Охиныг төрсөн аав нь хүчиндсэн.Тухайн үед ээж,аав 2 нь салсан байсан.Ээж нь ааваасаа очиж мөнгө авчир гэж хөөж явуулдаг байсан байна.Аав нь тухайн үед ТҮЦ ажиллуулдаг байсан эхний үед гуйсан мөнгийг нь зүгээр өгөөд явуулдаг байсан бол 5 дугаар ангид байхад нь мөнгө авахаар ирхэд нь анх удаа хүчиндсэн түүнээс хойш очих бүрдээ бэлгийн харьцаанд ордог байж байгаад 1 удаа ээждээ болон бусад хүмүүст хэлсэнээр уг асуудал сөхөгдөж аавд нь хуулийн дагуу шийтгэл хүлээлгэн одоо шоронд байгаа.Гэтэл энэ хэрэг нэг мөр болсоны дараа төрсөн ээж нь төрсөн аавыгаа шоронд хийсэн өөдгүй янхан гээд хүүхдээн гэрээсээ хөөн гаргасан одоо 17 охин хамгаалах байранд амьдарч байна.Үүнээс хархад хүүхдийг хамгаалах байранд байлгаж үйлчилгээ үзүүлж байна.Гэтэл ээжидтэй хэн ажиллах ёстой билээ.Бидэнд энэ эмэгтэйтэй ажиллах байгууллага хүн хэрэгтэй байна.Эмэгтэй хүнийх нь хувьд ээж хүнийх нь хувьд алдаж онож яваа гэр бүлээ тэжээн тэтгэх өрх толгойлсон 3 хүүхдийн ээжийг ажил төрөлтэй болгох энэ гэр бүлийг эргээд нэгтгэх халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлэх дэмжих туслах,холбон зуучилах гээд хамтын үйл ажиллагаа шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Ээж, охиныг эвлэрүүлэх, сэтгэл зүйн үйлчилгээ ,ажил олгогч,сургууль, эрүүл мэндийн байгууллага гээд мэргэшсэн цогц үйлчилгээг үзүүлж болно.

Үр дүн 100 хувь болно.

Энэ бүгдийг хэрэгжүүлэхэд :

- 1) Эрх зүйн орчин
- 2) Бодлого
- 3) Стратеги
- 4) Төлөвлөлт
- 5) Санхүүжилт
- 6) Хүний нөөц, мэргэшүүлэх, чадавхжуулах

Иймээс охины асуудлыг авч үзэхдээ асуудлаас нь хамаарах уу аль өнцөгөөс харах вэ гэдэг нь хамгийн чухал юм.

Ер нь бол аливаа хүүхдийн асуудлыг эрэмбэлж авч үзэх нь өөрөө хүүхдийн хамгаалагдах эрхийг зөрчиж байна гэсэн үг иймээс 1 асуудал байна нилээд газар авч нийгмийн анхааралд орсон асуудал уу гэдэгээс үл хамаарч гарч байгаа ил болсон асуудал бүрийг анхаарч үзэх эрхийг зөвхөн хүүхэд л эдэлнэ.

## 2) Байгаль орчны болон эмэгтэйчүүдийн хөдөлгөөний хамтын ажиллагаа – Салбар хуралдааны дүгнэлт.

ЧИГЛҮҮЛЭГЧ: Н.Баярсайхан

**ЗОРИЛГО:** Байгаль орчны хөдөлгөөний түүхэн замнал, өнөөгийн хүрсэн амжилт, үр нөлөөтэй арга хандлагын талаар мэдээлэл авч түүндээ тулгуурлан бидний хөдөлгөөн, зорилттой нийтлэг зүйлсээ тодорхойлох эхлэлийг тавина. Үүнд нийтлэг сонирхол /зорилтот бүлгээ хамруулах, үйл ажиллагаагаа оновчтой, тогтвортой болгох, чадавхиа бэхжүүлэх г.м./, нийтлэг сорилт, боломжийн талаар ярилцана. Ялангуяа бодлого, түүний хэрэгжилтийн талаар өнөөгийн шаардлага, боломж, механизмууд, санхүүгийн эх үүсвэрийн талаар төвлөрч ярилцана. Байгаль орчны хөдөлгөөний давуу талд түшиглэн хэрхэн хамтын ажиллагаагаа хөгжүүлэх асуудлаар ярилцаж, цаашид хамтын ажиллагааг эхлүүлэх алхамуудыг тодорхойлох.

### САЛБАР ХУРАЛДААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Салбар хуралдаанд нийт 28 эмэгтэйчүүд оролцлоо. Салбар хуралдааны хэлэлцүүлэг үндсэн 2 хэсэгтэй байсан бөгөөд аль болох бүгдийн саналыг оруулах, ингэхдээ тодорхой бодитой ажил хэрэгч санал гаргуулахыг хичээсэн болно. Үүний тулд оролцогчдыг задгай асуудал ярьж цаг алдахаас сэргийлж 3 багт хуваан өөр өөр агуулга бүхий даалгавар дээр ярилцах, тодорхой шийдэл боломжийг гаргаж ирэхээр ажиллуулсан болно.

Салбар хуралдааны 1-р хэсэг /. Хэлэлцүүлгийг өдөөх илтгэл 5 мин- ХИЛ хязгааргүй алхам ТББ-ын хийж байгаа “Малчин эмэгтэйчүүдийн эрх ба байгаль орчны шударга ёсыг хангах нь” судалгааны явцын товч танилцуулга хийж оролцогчдын анхаарлыг төвлөрүүлэх, өдөөх илтгэл – Н.Баярсайхан /Судалгааны танилцуулгыг хавсаргав./

Салбар хуралдааны 2-р хэсэг /. Бүлгийн ажил 30 мин+ оролцогчид 3 хэсэг болно.

- 1-р хэсэг: БО-ны салбарт тулгамдаж буй асуудлууд нь нийгмийн тэр дундаа эмэгтэйчүүдийн ямар ямар эрхүүдийн зөрчил үүсэхэд нөлөөлж байна вэ?
- 2-р хэсэг: БО болон эмэгтэйчүүдийн хөдөлгөөнүүдийн хамтын ажиллагааг хөгжүүлэх СВОТ шинжилгээ хийх
- 3-р хэсэг: Хамтын ажиллагааг эхлэлийг тавих алхамуудыг тодорхойлох нэг багт 6-9 хүн оролцож ажилласан болно.

3/. Хэсгийн танилцуулга тус бүр 5 мин 15 мин

### БҮЛГИЙН АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА:

*А. БО-ны салбарт тулгамдаж буй асуудлууд нь нийгмийн тэр дундаа эмэгтэйчүүдийн ямар ямар эрхүүдийн зөрчил үүсэхэд нөлөөлж байна вэ? Танилцуулгыг Байгаль орчин Эрүүл мэнд төв ТББ-ын тэргүүн Л.Долгормаа танилцууллаа.*

БО өмнө тулгамдаж байгаа асуудлууд	Эмэгтэйчүүдийн эрхийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байгаа илрэлүүд
<ul style="list-style-type: none"> <li>• Хөрсний бохирдол</li> <li>• Усны чанар, нөөц</li> <li>• Агаарын бохирдол /тоосжилт, химийн хорт бодис/</li> <li>• Байгалийн нөөцид түшиглэсэн эдийн засгийн үйл ажиллагаа</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Нийгмийн амьдралын хэв маяг</li> <li>• Зөрчигдсөн эрх</li> <li>• Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх</li> <li>• Уугуул иргэдийн эрх</li> <li>• Газар нутаг эзэмших эрх</li> <li>• Мал төрийн хамгаалалтад байх эрх</li> <li>• Оршин амьдрах газар нутгаа сонгох</li> <li>• Нөхөн үржихүйн эрх</li> <li>• Хүүхдээ эрүүл өсгөж, хүмүүжүүлэх эрх</li> <li>• Хөдөлмөрлөх эрх /орлого олох/</li> <li>• Гэр бүлийн үнэ цэнэ алдагдаж байна</li> <li>• Сонгох, сонгогдох эрх</li> </ul>

**В. БО болон эмэгтэйчүүдийн хөдөлгөөнүүдийн хамтын ажиллагааг хөгжүүлэх үйл ажиллагааны СВОТ шинжилгээ хийх дүгнэлт гаргах. Бүлгийн танилцуулгыг Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн дэмжих холбооны тэргүүн Ш.Ариунаа танилцууллаа.**

Давуу тал	Боломж
<ul style="list-style-type: none"> <li>• Ур чадвартай</li> <li>• Судалгаатай</li> <li>• БО-оо дэмжиж Эрхийг хангаж чадна</li> <li>• Эмэгтэйчүүд БО-ны төлөө чин сэтгэтэй</li> <li>• Эмэгтэйчүүд БО ахуй амьдралд өндөр мэдрэмжтэй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ур чадвараа нэгтгэвэл ҮР ДҮН илүү</li> <li>• Судалгааг нэгтгэвэл илүү нөлөө үзүүлнэ</li> <li>• БО-оо хамгаалах замаар</li> <li>• Эрхийг хангах эрх эдлэх чадалтай болно</li> <li>• Олон нийтийн дэмжлэг авч чадна</li> <li>• Агаарын бохирдол – эмэгтэйчүүд</li> <li>• Амьдрах орчин -эмэгтэйчүүд</li> </ul>
Сул тал	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> <li>• Хамтран ажиллах чадвар сул</li> <li>• Тогтвортой ажилладаггүй</li> <li>• Үнэт зүйл-эрхэм зорилго ойлгол</li> <li>• Бид өөрсдөө мэдлэг мэдээлэл сул</li> <li>• Үзэл бодлын зөрчилтэй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хамтын ажиллагаа байхгүй</li> <li>• Нэгдсэн үр дүнгүй</li> <li>• Нэгдэхгүй байгаа шалтгаан олон нийтийн дэмжлэг авч чадаагүй</li> <li>• Асуудлаараа нэгддэггүй</li> </ul>

Дүгнэлт:

- Танилцах, ойлголцох
- СОНСОХ, хүлээн зөвшөөрөх
- ХАМТРАН АЖИЛЛАХ, багаар ажиллах ур чадварт суралцах
- ХАРИЛЦААНЫ УР ЧАДВАРТ суралцах
- Сэтгэл зүйн мэдрэмжээ дээшлүүлэх

**С. Хамтын ажиллагааг эхлэлийг тавих алхамууд тодорхойлох. Бүлгийн ажлын танилцуулгыг Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн хөгжил сан ТББ-ын тэргүүн н.Мэндээ танилцууллаа.**



- Зөвлөлдөх уулзалт зохион байгуулах
- Санамж бичиг байгуулах
- ХАМТАРСАН ажлын хэсэг гарч эхлэлийг тавих
- Талуудад ямар боломжууд байгааг тодруулах судалгаа хийх
- Талуудад байгаа нөөц боломжийн талаарх мэдээллийн нэгдсэн сан байгуулах
- Эмэгтэйчүүдийн зөрчлийн кейсд тулгуурлаж талууд хамтран ажилаж шийдэх замаар хамтран ажиллах эхлэлийг тавих
- БО ба эмэгтэйчүүдийн Ажиллах эрх, ЭМ эрх боловсролын эрх, усны эрх гэх мэт өргөн хүрээнд ажиллах
- Чуулганы зөвлөмж, уриалгыг хамтдаа сурталчлан таниулах хэрэгжүүлэх

## **САЛБАР ХУРАЛДААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ:**

Салбар хуралдааны чиглүүлэгчийн хувьд багийн гишүүдтэй ярилцсан дүгнэлт:

1. Байгаль орчны ТББ-ууд болон орон нутгийн байгаль хамгаалах нөхөрлөлүүд эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар ажилладаг ТББ-ууд хамтран ажиллах цаг нь болсон гэдэгтэй санал нэгдлээ.
2. Байгаль орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлт нь хүний эрх, эрх чөлөө хангагдахад, хүний хөгжих эрхэд, орон нутгийн тогтвортой хөгжилд сөрөг нөлөөлөл үзүүлж байна. Энэ нь илүү эмэгтэйчүүдэд хүндээр тусч байгааг, эмэгтэйчүүдийн өдөр тутмын эрхийг бүрэн хөндөж, эрхийн хэрэгжилтэд шууд хязгаарлат хийж байгаа нь илэрхий байдлаар мэдрэгдэж илэрч байгаад онцгойлон анхаарах ёстой гэдэгтэй санал нэгдлээ.
3. Дэлхий нийтээр тодорхойлсон тогтвортой хөгжлийн зорилтууд, МУ-ын тогтвортой хөгжлийн болон ногоон хөгжлийн зорилтууд, дэлхийн хүмүүсийн эв санааны нэгдэлтэйгээр санал нэгдсэн Эх дэлхийгээ хайрлах хөдөлгөөнд эхчүүд, эмэгтэйчүүдийн хөдөлгөөнүүд хүчин зүтгэж бодитой оролцох, байгалийн нөөцөд түшиглэсэн эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт тавих, олон нийтийг соён гэгээрүүлэх зэрэг үйл ажиллагаанд өргөн суурьтай хамтын ажиллагаа чухал гэдгийг онцлон тэмдэглэлээ.
4. Гэвч БО- ЭМ-ийн хөдөлгөөн хамтын ажиллагаа чухал хэдий ч талуудын ялангуяа БО-ны ТББ-уудын үнэт зүйл, ёс зүй төлөвлшөөгүй, засаглалын хувьд тодорхой бус, нийгмийн дунд нэр хүнд төдийлөн сайн биш байгаа тохиолдолд зарим талаар болгоомжтой хандах шаардлага бий. Гэхдээ эгээр олон янз байдал нь иргэний нийгмийн төлөвшилийн процесс, карманы ТББ-ыг хянах боломжгүй байгаа манай нийгмийн онцлог гэж эерэгээр харж болох ч зайлшгүй болгоомжтой хандах ёстой.
5. Ингээд цаашид:
  - Эхний ээлжинд БО ны болон эмэгтэйчүүдийн хөдөлгөөнүүд хоорондын дундын дэд ажлын хэсэг гарч зөвлөлдөх, тодорхой арга хэмжээнүүдийг эхлүүлэх боломжуудын талаар зөвлөлдөх;
  - Нийслэлийн түвшинд тодорхой асуудал дээр, тухайлбал Агаарын бохирдол зэрэг нийгмийн дэмжлэг авахуйц, нөлөөллийг өргөн хрээнд хэрэгжүүлж болохуйц арга хэмжээг эхлүүлэх, орн нутгийн түвшинд тодорхой бүс нутгаас БО- ЭМ-ийн хөдөлгөөний хамтын ажиллагааг эхлүүлэх байж болох юм.
  - ХЭ-ийн ЭМ-ийн болон БО-ны эрхийн талаар НҮБ-ын гэрээний хороодоос өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хүрээнд хамтран ажиллах;
  - Чуулганы зөвлөмжийг тодорхой эзэнтэйгээр боловсруулан гаргах: ОУБ-уудад, Төрийн байгууллагуудад, ХЭҮК-т УИХ-ын ХЭДХ гэх мэт, харин БО болон орон нутгийн БО болон ЭМ-ийн ТББ-уудад хамтран ажиллах уриалга гаргах байж болох юм.



## 1) Хэвлэл мэдээллийн салбартай хамтын ажиллагааг хөгжүүлэх нь - Салбар хуралдааны дүгнэлт

Чиглүүлэгч: Т. Аюушжав

### 1. Товч мэдээлэл

Эхлээд оролцогчдод хэвлэл мэдээллийн салбарт тулгарч буй асуудал, бэрхшээл, салбарын онцлог тал, хэвлэл мэдээллийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, цаашдын хэрэгцээ шаардлагын талаар товч танилцуулав. Үүнд, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд цаг зав багатай, шахуу хугацаанд мэдээ бэлтгэдэг, мөн аливаа нийтлэл, нэвтрүүлэг, сурвалжлага хийхдээ удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу ажилладаг. Сэтгүүлчдийг бэлтгэдэг сэтгүүл зүйн их дээд сургуулиудын чанар хангалтгүй бөгөөд хүний эрхийн талаар суурь мэдлэг олгох тал дээр дутмаг байдаг. Хэвлэл мэдээллийн байгууллагууд хоорондоо өрсөлдөөн ихтэй тул төсөв санхүүгийн боломж дутмаг, зар сурталчилгааг агуулгаар нь төдийлөн ялгаварлалгүй нэвтрүүлж, хүргэдэг.

Монголын нийгэмд хэний дуу хоолой (эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль нь) давамгайлж байна гэж оролцогчдоос асуухад эрэгтэйчүүдийнх гэж бүгд хариулав. Учир нь шийдвэр гаргагчид дийлэнх нь эрэгтэйчүүд байдаг тул цаг үеийн мэдээнд тэднээс ярилцлага авах, хэлэлцүүлэгт оруулах зайлшгүй шаардлагатай байдаг. Мөн хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсдын дийлэнх нь эмэгтэйчүүд байдаг гэж хариулав. Үндсэндээ, эмэгтэй сэтгүүлчид эрэгтэйчүүдийн дуу хоолойг дамжуулагчид болоод байна.

Хэвлэл мэдээлэл нь олон нийтийг мэдээ, мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх, төрийн үйлчилгээнд хяналт тавих үүрэгтэй. Харин энэ үүргээ хангалтгүй биелүүлж байна гэж оролцогчдын дийлэнх нь үзэж байна.

Хэвлэл мэдээллийн байгууллага жендэрийн тэгш байдлыг дэмжих, таниулан сурталчлах, нийтлэл, нэвтрүүлгээ жендэрийн мэдрэмжтэй болгохын тулд нэн тэргүүнд жендэрийн тэгш байдлын бодлого болон ёс зүйн код баталж, баримтлах ёстой. Жендэрийн мэдрэмжтэй, хүний эрхийн хандлагатай нэвтрүүлэг бэлтгэхэд найруулагч, продюсеруудад зориулсан зарчим, удирдамж боловсруулж, мөрдүүлэх нь чухал. ИНБ-ууд сэтгүүл зүйн мэргэжлийн эвлэл холбоод, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл зэрэг байгууллагуудтай хамтарч ажиллах нь зүйтэй. Мөн сэтгүүлчид, рекламны студиуд, зар сурталчилгаа бэлтгэн нийлүүлдэг компаниудын маркетингийн ажилтнуудад сургалт явуулах хэрэгтэй. Түүнчлэн дан ганц сэтгүүлчидтэй ажиллах биш, ХМБ-ын удирдлага, шийдвэр гаргагчдын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх шаардлагатай. ИНБ-ууд олон улсын сайн туршлага судлах, үүн дээр түшиглэн хэвлэл мэдээллийнхэнтэй хамтрах нь дөхөмтэй. Жишээлбэл, ABC буюу Australian Broadcasting Corporation жендэрийн сайн бодлоготой, IFJ буюу Олон улсын сэтгүүлчдийн холбоо нь хүүхэд эмэгтэйчүүдийг сурталчлах ёс зүйн кодтой гэх мэт. Манай МСНЭ нь ОУСХ-ны гишүүн юм.

### 2. Бүлгийн ажил, хэлэлцүүлэг

Товч мэдээлэл хийсний дараа оролцогчид 3 бүлэгт хуваагдан, дараах асуудлыг хэлэлцэв. Үүнд:



Асуулт 1. Бидэнд хэвлэл мэдээллийнхэнтэй ажиллах ямар ямар туршлага байна вэ? Ололт амжилт

Асуулт 2. Бид юу юун дээр алдсан бэ? Алдаа дутагдал

Асуулт 3. Бидэнд юу дутагдаж байна, цаашид хэрэгтэй ямар чадавх, мэдлэг байна вэ?

Асуулт 4. Шаардлагатай мэдлэг, мэдээлэл юу байна? Хаанаас хэрхэн олж авах вэ? Хэрэгцээ шаардлага

Асуулт 5. Цаашид хэрхэн хамтран ажиллах вэ? Шинэ арга барил юу байна, шинэ боломж юу байна? Хамтын ажиллагааны ямар хэлбэр байж болох вэ? Шийдэл, гарц

**Бүлгийн оролцогчдын санал бодлоос:**

Б.Алтантуяа,Эмнести: Бид сэтгүүлч, ХМБ-ын удирдлагыг сургадаг, хүний эрхийн хандлагатай болгодог, асуудлыг сурвалжлаад өгөөч гээд яг бодлого барьж байгаа, шийдвэр гаргаж байгаа хүн рүү ханддаггүй, редакцийн дарамт их байдаг, захиалгат зүйл нийтэлдэг, цаг зав багатайгаасаа болоод дээрээс нь бид хамтарч ажиллах талаас л боддог болохоос, өөрсдийг нь хариуцлагатай болгох гэж, ёс зүйтэй болгох гэж шаардлага тавьж дуугардаггүй. Нэг арга хэмжээн дээр очоод, нэг хүнээс ярилцлага аваад л нэг өнцгөөс хуймгай мэдээлэл өгдөг. Тэгэхээр бид нар энэ дээр л алдаад байх шиг. Шаардлагатай мэдээлэл дээр асуудалтай биш. Цаашид яах вэ гэдэг дээр удирдлагуудад хандсан нөлөөллийн ажил, сургалтуудыг түлхүү хийх нь чухал. Эмэгтэйчүүд, хүний эрхийн, байгаль орчныхон нийлж байж тэднийг уриад, тал талаас нь нэг хоолойгоор дуугарах хэрэгтэй, зөвхөн Эмнести хандвал яагаад Эмнести шаарддаг юм, хэн бэ гэж хүлээн авна, бид зэрэг шаардаад, зэрэг дуугарвал их олон хүн бидний араас шаардах юм байна гээд асуудалд анхаарч эхэлнэ. Энэ үүднээс хамтарч дуугарах, дуу хоолойгоо нийлүүлж өргөх чухал юм байна.

Мөнхнасан: эргэх холбоо, байнгын харилцаатай байж чадаагүй, харилцдаг, сургалт мэдээлэл өгсөн, редакц удирдлагуудад нөлөөлөх арга хэмжээ авах, жишээ нь Монголын Үндэсний ТВ бидний асуудлыг ерөөсөө авч хэлэлцдэггүй, бид ийм юм ярихгүй гээд редакцияс шууд хаадаг. Нэг удаа бид уралдаан зарлахад, нэг сэтгүүлчийг бүтэн 2 өдөр гуйж байж, нэвтрүүлгээр цацахгүй, богино хэмжээний юм хийх, нэвтрүүлэхгүй гэсэн гэрээ хийж байж, уралдаанд орж байх жишээтэй. Энгийн сэтгүүлчтэй ажиллах биш, дарга удирдлагатай гэрээ хийдэг юм уу, хамтрахгүй бол сэтгүүлчид энд тэнд арга хэмжээний мэдээ хийдэг, мэдээгээр шахуулдаг, хаана юу болж байгааг мэдээлдэг ч нэг хүнийг дуудаж мэдээлэл авангуут өөрөө агуулгыг нь ойлгоогүй цацдаг.

**Бүлгийн дүгнэлт:**

Бүлэг 1

1 асуулт: туршлага, зарим нэг байгууллага дэргэдээ сэтгүүлчийн клубтэй байдаг, түүгээр дамжуулан ажиллаж, чадавхжуулах ажил хийдэг юм байна. ХМ сургалтанд оролцуулж, хамтын ажиллагаагаа бэхжүүлдэг. Ихэнх ХМХ төлбөртэй нэвтрүүлэг цацдаг, ашиглаад төлбөртэй нэвтрүүлэг хийх замаар хамтарч ажилладаг, цуврал, зохиомжит нэвтрүүлгүүд, урт хугацааны эсвэл сарын гэрээ хийж байгаад, чиглэлээр ажилладаг

2: юун дээр алдаж байна гэвэл, ХМБ-ын удирдлагуудтай ажиллаж чаддаггүй, бидний хүргэх гээд байгаа зүйлийг сэтгүүлч дур мэдэн гаргаж чаддаггүй тохиолдол байдаг. Тэгэхээр удирдлагуудтай ажиллаж, удирдлагуудад мэдээ, мэдээлэл хүргэх тал дээр алдсан. Мөн ХМ-ийнхэнтэй тогтмол харилцаа холбоо байдаггүй, нэг хүнтэй харьцаж байснаа дараагийн удаа өөр хүнтэй харилцах жишээтэй.

3: Өөрсдийгөө чадавхжуулах шаардлагатай, байгууллага бүр дотроо ХМ хариуцсан ажилтантай байж болно, бид шаардлагатай мэдээ мэдээлэл авч чаддаггүй, яаж мэдээгээ хүргэх вэ гэдэг чиглэлээр дутмаг байна. Мэдээ, мэдээлэл дутмаг, жишээ нь ТВ-үүдийн ямар ямар чиглэлээр мэдээлэл хийдэг, тэр чиглэлийн ТВ-үүдийн шатлалын ангилал байдаг, тэр чиглэлийг нь мэдэхгүй учраас боломжуудыг алддаг

4: юу дутагдаж байна гэхээр хамгийн түрүүнд санхүүжилтийн асуудал, ихэнх ТВ хөрөнгө мөнгө хардаг, төлбөртэй цацдаг, мэдлэг, мэдээлэл дутмаг

Шаардлагатай мэдлэг мэдээлэл юу байна, хаанаас олж авах вэ гэхээр ХМБ-уудтай шат дараалсан уулзалт хийж байж, тэндээсээ мэдлэг мэдээлэл олж авах боломжтой. ХХ-гээс судалгаа хийдэг, ХМ-ийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг байгууллагуудад судалгааны материалуудтай танилцаад мэдээ мэдээлэл авах боломжтой.

5: хамтын ажиллагаагаа яаж өргөжүүлэх, бартердаж ажиллаж болно, жишээ нь мэдээ мэдээлэл нэвтрүүлэг хийлгэсний төлөө тухайн сэтгүүлч, редакц, албаны дарга нарт чиглэсэн сургалт хийж болно. Ингэж хамтын ажиллагаагаа бэхжүүлж ажиллах боломжтой. Хэн хэнд нь ашигтай байдлаар. Хамтарсан гэрээ, санамж бичигтэй болох. Сардаа, улиралдаа энэ чиглэлийн мэдээ мэдээлэл цацах тал дээр, асуудал дагнасан сэтгүүлч бэлдэх шаардлагатай. Асуудал чиглэл дагнасан сэтгүүлч байвал тэднээр дамжуулах боломжтой. Ойрын боломж заавал ХМ гэхгүй, интернэт орчин ашиглаад, өөрсдийн нөөц боломжид тулгуурлаад ажиллах боломжтой. Сэтгүүлчдийн группээр дамжуулан хамтрах боломжтой.

## Бүлэг 2:

Туршлага: ХМ-ийн чиглэлээр ажиллаж байгаа сонин, ТВ, мөнгө хөрөнгө, төсөвгүй учраас танил талаараа лобби хийж, төсөв байдаг бол тэрнээсээ хэтэрсэн юм хийхийн тулд танил талаа харж ажиллаж байсан, олон нийтийн сүлжээгээр тараадаг байсан, байгууллагын дэргэд ХМ алба, хэвлэмэл хуудас, үйл ажиллагаа сурталчлаад гаргаж байсан, энэ нь явцуу байсан, эмэгтэйчүүдийн асуудал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, зорилтот бүлгийн асуудлыг бичлээ гэхэд сонирхох хүрээнд эхэндээ захиалаад, яваандаа редакц алдагдалтай ажиллаж байсан

Алдаа, өөрсдөө хариуцлагатай байх, юуны тухай ярих гээд байгаа юм, юунд анхаарал хандуулах гээд байгаа юм, шийдвэр гаргагчдад юуг нь хүргэх гээд байгаа юм, юуг мэдээлэх юм, гэдгээ бичих гэж байгаа хүмүүс нь нийгэмд юуг хүргэх вэ гэдэг талаар ойлгож байж, чанартай мэдээ бэлдэхгүй бол хүрэхгүй, хүний эрх, эмэгтэйчүүдийн асуудал гээд бидний хүргэх гээд байгаа мэдээллийг сэтгүүлч бичээд, бичлэгийн шагнал нь бага үнэлгээтэй байвал дараагийн удаа татгалздаг, үнэлгээ өндөртэй мэдээ бичих болдог, энэ бас бодуштай зүйл.

Алдаад байна, лобби танил талаа ашигладаг учраас мэдээлэл тогтмол гарч чадахгүй байна, танидаг хүнээ нэг гуйна, хоёр гуйна, 3 дахаасаа нөгөөх нь татгалзаад эхэлдэг, мөн мэдээллийн хүртээмж хязгаарлагдмал байна, олон нийтийн сүлжээ ашигласнаар зарим хүмүүст хүрэхгүй, мэдээллийг сонирхолтой болгохгүй бол үнэлгээ муу, байдаг л хэдэн хүүхнүүд эрхээ шаардаж байдаг юм шиг ийм ойлголт төрүүлээд байна, хэт явцуу, байгууллагын дэргэд ХМХ ажиллуулахаар хөгжлийн бэрхшээлтэй иргэд тэглээ, эмэгтэйчүүд тэглээ гээд байхаар хүмүүс залхана, ТВ-ээр жишээлбэл, эмэгтэйчүүдийн эрхийн цаг байлаа гэхэд заавал 2 хүн суугаад эрх нь зөрчигдөж байгаа тухай ярих биш, кино жүжиг гэх мэт олон талын мэдээллийг ашиглахгүй бол нэг л байдаг хэлбэрээр яваад байвал сонирхолгүй, явцуураад эхэлнэ. Бид хязгаарлагдмал орон зайд хязгаарлагдмал ажиллаж байна. Энэ цар хүрээг тэлэх ёстой юм байна.

Цаашдаа, бид бодлоготой байх ёстой, алсын хараа хэтийн зорилго гэхээс илүү өнөөдөр хүний эрхэнд суурилад явж байгаа ажлаа шийдвэр гаргах түвшинд нь яаж хүргэх вэ гэдгээ бүгдээрээ сайн дуу хоолойгоо нэгтгээд бодох ёстой. Зарчимтай байх ёстой, бид техник тоног төхөөрөмжийн зайлшгүй дэмжлэгтэй байж л бид ХМ-тэй хамтрах өөрсдийнхөө үйл ажиллагааг сайжруулж чадна. Санхүү, эх үүсвэртэй байж л, цаашид төсөл бичлээ гэхэд ИНБ, эмэгтэйчүүдийн, орон нутгийн бүх л байгууллагууд ХМ-тэй харилцах төсөв тусгаж өгөх хэрэгтэй, гол нь мөнгөтэй байлаа гээд, жишээ нь ТВ зон сэтгүүлийг аваад үзэе, хайрын Хонгорзул сэтгүүлчийг аваад үзэе, хэчнээн мундаг ПиАр хийгээд явж байтал редакц солигдвол, боловсон хүчин унадаг, сэтгүүлч өөр юм хийгээд явбал бодлого алдагдаад, боловсон хүчний нөөц, хүний нөөцөд бид байнга анхаарах хэрэгтэй. ТББ-уудын дэргэд өөрсдийгөө илэрхийлэх нэг хүнийг, сонин сэтгүүлтэй харьцдаг ХМ ажилтан бэлтгэе гэж бодвол, байгууллагын ПиАр яаж өсгөж чадах юм, ХМБ-уудтай яаж хамтарч ажиллаж чадах юм, урт хугацааных байх, яаж урт хугацаагаар харилцан ашигтай хамтарч ажиллах юм гэдгээ бодох нь зүйтэй.

4: мэдлэг, сэтгүүлч мэдээг хам хум бичдэг, арга хэмжээнд бүтэн оролцдоггүй учраас юу ч ойлгохгүй гардаг, мэдээлээд л өнгөрдөг, бидэнтэй баг болоод суух юм бол төрийн бодлого нь ямар юм, ТББ бодлого юу юм, хөрөнгө босгож байгаа хүмүүсийн, гадна дотны донор спонсорууд юу өгч байгаа юм гэсэн энэ болгоныг мэдэж байж, ОУ хэм хэмжээ, хэлтэй устай байж SWOT дүн шинжилгээ хийж, хүний эрхийн мэдрэмжтэй байж, ХМБ сайн ажиллаж чадна. Мэдээлэл сургалт уулзалт байнга сэтгүүлчдийн бүлэг эсвэл шийдвэр гаргах түвшний хүмүүсийг энд байлгахгүй бол бид мянга яриад нэмэргүй, сэтгүүлч нь бичээд очдог, шийдвэр гаргач нь хувийн ТВ, радио, сонин байна, сонирхолтой материал бичихгүй бол хасагдана. Бидний хүссэн хэмжээгээр гарахгүй.

5: бид сая хууль хэрэгжүүлэхдээ ч гэсэн, Радио, телевизийн зохицуулах хороо (*Харилцаа холбооны зохицуулах хороо*) гэж байгууллага байгаа, хэчнээн сэтгүүлчийг танидаг байлаа гэхэд, редакцийн төсөв ч багасаад, материал, нийгэмд хандсан нийгмийн хариуцлагатай реклам явлаа гэхэд ямар ач холбогдолтой байсан юм гээд бүгдийн хасаад танаад, тэр арилжааны өргөн нэвтрүүлгийн ТВ-үүд бидэнтэй ажиллаж чадахгүй байна. Нийгмийн шинжтэй асуудлаа ганц Үндэсний ОНРТ рүүгээ л яв гэдэг, тэнд хэчнээн, 3000 гаруй ТББ байлаа гэхэд бүгд албан бичиг өгөөд манай реклам үнэгүй явуулаад өгөөч гэвэл бидэнтэй ажиллах хэцүү болдог. Тэгэхээр радио телевизийн зохицуулах хороонд бид нөлөөлж чадах ёстой, аливаад нэгдсэн арга хэмжээгээр нөлөөлөх ёстой. Хэвлэлийн хуулинд ТББ-уудын хумигдаад байгаа асуудлуудыг тусгаж өгөх ёстой, хуульчлаад өгвөл өөр. УИХ, ЗГ, Ерөнхийлөгчийн

хэвлэлийн алба, бодлогын яамдуудын ХМА гэж байдаг, ЗДТГ-т мөн хэвлэлийн албатай, тэр болгонтой бид зохицож, очиж, ярьж байж, бодлогоороо хамтарч ажиллаж байж үр дүн гарна. Парламентын сэтгүүлчдийн бүлэг гэж байдаг, 7 хоногт 2 удаа хуралдаанаар юу юу ярьсаныг мэдэхийн тулд бид энэ бүлэгтэй ажиллах ёстой. Тухайн ХМ-ийн шийдвэр гаргагчдыг энд суулгаад уулзаж байсан бол арай өөр. Шат бүрт нөлөөлөх хамгийн чухал. Хэвлэлийн кампанит ажил явахад маш хэрэгтэй, нөлөөллийн ажил шаардлагатай, олонд танигдсан, нийгэмдээ хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүстэй нийгмийн шторкуудыг хийж, эмэгтэйчүүдийн эрхийн асуудал, хүүхдийн эрхийн асуудал, асуудал нь орхигдсон хүмүүсийн асуудлаар нөлөөллийн ажлууд маш сайн хийх хэрэгтэй.

### Бүлэг 3

1: манайхны хувьд ХМ-тэй ажиллаж байсан туршлага байхгүй, тохиолдлын чанартай оролцдог, гэхдээ Италийн ЗГ бус хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр 20-иод жил ажиллаж байгаа байгууллага байдаг, тэдний дэргэд сэтгүүлчдийн клуб ажилладаг, төслийн хүрээнийх болохоор төслийнхөө үйл ажиллагааг сурталчлаад, бидний асуудал руу сайн орохгүй байх шиг байна.

2: алдаа, манай ширээнийхэн ихэвчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байгаа болохоор, бидний талаар ХМ-ээр гарч байгаа өнгө төрх өрөвдмөөр, их хэцүү, бараг хүний нулимс гарахаар дандаа тийм нэвтрүүлгүүд байдаг. Бид ярьдаг, уянгын хөгжим яваад л, Гүрбазарын шүлэг ард нь уншаад, бидний дугуй эргээд гээд, их хэцүү дүр төрхтэй, энэ бүр нийтлэг болсон. Энэнээс татгалзмаар байна. Энэ дээр сэтгүүлчид биднийг удирдаад явчихдаг, бид өөрсдөө тэгж гарахыг хүсээгүй байтал сэтгүүлч бидэнд, одоо тийшээ, баруун, зүүн тийшээ 3-4 яваадах гэдэг, чамд юу хэцүү байна гэхээр хэцүү юмаа ярьчихдаг, тэгэнгүүт дараа нь их өрөвдмөөр нэвтрүүлэг гараад, бид өөрсдөөсөө ичдэг. Тэгэхээр бид өөрсдөө удирдлаганд нь ороод байгаа алдаа байгаа.

3: ТББ-ын хувьд сэтгүүлчидтэй ажиллах тогтмол ажилтан гэж байхгүй, хүний нөөцийн хувьд байнга хязгаарлагдмал учраас тэр ажлыг төлөвлөж чаддаггүй, энэ бол бидний алдаа.

4: бидэнд юу дутагдаж байна гэхээр, өөрсдийгөө чадавхжуулмаар байна, хэвлэлийн мэдээ яаж бэлтгэх, яриагаа яаж өгөх, аль өнцгөөс өгөх, ТББ-ууд өөрсдийн ажилтнуудаас гадна гишүүддээ хүртэл сургаж хэлэх, зовлонгоо тоочоод бүгдээрээ гараад байх биш, бас ТВ-үүдийн бодлого чиглэлийн талаар мэдээлэл бидэнд байхгүй учраас энэ ТВ тиймэрхүү ажилладаг гэдэг мэдээлэл барьж байгаад тэр чиглэл рүү нь хандах туршлага бидэнд байхгүй.

Шаардлагатай мэдлэг мэдээлэл, ОУБ-ууд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нийгмийн цөөнх, шилжин суурьшигчид, цагаачдынхаа талаар яаж олон нийтэд зөв хандлага өгч байгаа талаар нэвтрүүлгүүдээс суралцмаар байна. Бидний тухай нэвтрүүлгүүд их хүнд, "Хар цагаан", "Үнэний дэнсэн дээр" гэх мэт хүнд нэртэй. Гадаадад өдөр тутамдаа, өдөр болгон л ямар нэгэн бэрхшээлтэй, бэлгийн цөөнх, цаатны тухай нэвтрүүлэг явж л байдаг, гэхдээ бэрхшээлтэй байгаа талаар гарч байгаа ч өдөр тутмын амьдралыг нь гаргаад, чадаж байгаа зүйлийг нь харуулдаг. Энгийнээр ард нь ажил хөдөлмөр, гэр бүл, хамт олон байдагийг харуулдаг. Манайх тэргэнцэртэй нь явуулаад л, шатан дээгүүр явуулаад л, чирүүлж нэг явуулаад л, хэцүү нэвтрүүлэг болж дуусдаг. Энгийн байдлаар бусдын адил хүн гэдгийн ойлгуулсан нэвтрүүлэг хийхэд анхаарах хэрэгтэй.

5: ХМБ-ын удирдлагууд, сэтгүүлчдэд хүний эрхийн талаар мэдлэг олгох сургалт хийх зайлшгүй шаардлагатай. Зөвхөн нийгэм, эдийн засгийн редакцийн сурвалжлагчид сэтгүүлч бидэнтэй ажиллах биш, соёл урлаг, улс төрийн бүх л албаны сэтгүүлчид бидэнтэй ажилладаг. Байгаль орчны сэдвээр ярьж байгаад л энд тэнд мод тарилаа гэхэд сэтгүүлч нь танайх энэ үйл ажиллагаандаа хэдэн хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулав гэж асуух. Тусдаа нэвтрүүлэг биш, Цагийн хүрдээр, жишээлбэл, хөлтэй хүнээс биш нэг тэргэнцэртэй хүнээс цас орсон талаар яриа авдаг. Тэр хүн заавал бэрхшээлийн тухай биш цаг уурын тухай ярьж нэвтрүүлэгт орж болохоор байгаа. Ингэж тусгаарлахгүй, энгийн байдлаар байдгах чиглэлээр сургалт хиймээр байна. Сургалтыг Хүний эрхийн комисс, ямар нэгэн төрийн байгууллага биш бид өөрсдөө хиймээр байна. Бэлгийн цөөнх, казах тува эмэгтэйчүүд, цаатан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд бид өөрсдөө хиймээр байна. ТВ, сонин, ХМХ-ийн нэвтрүүлгийн тэдээс доошгүй хувь нийгмийн цөөнх рүү чиглэсэн байна гэсэн зарчим гаргаж ирмээр байна. Бодлогын түвшинд нөлөөлмөөр байна.

## 2) ДҮГНЭЛТ

### Бидэнд хэвлэл мэдээллийнхэнтэй ажиллах ямар ямар туршлага байна вэ?

- Зарим нэг байгууллага дэргэдээ сэтгүүлчийн клубтэй байдаг, түүгээр дамжуулан ажиллаж байсан.
- ХМБ, сэтгүүлчдийг сургалтад хамруулж, хамтын ажиллагаагаа бэхжүүлдэг. Мөн ХМХ-тэй урт, богино хугацааны гэрээ хийгээд, төлбөртэй нэвтрүүлэг, цуврал, зохиомжит нэвтрүүлгүүд цацдаг.
- Сонин, ТВ-үүд ихэнхдээ төлбөртэй нийтэлж, нэвтрүүлдэг тул бид төсөвгүй учраас танил талаа лоббидож, ажиллаж байсан. Мөн олон нийтийн сүлжээ ашигладаг.
- Байгууллагын дэргэд ХМ алба байгуулж, хэвлэмэл хуудас гаргаж, үйл ажиллагаагаа сурталчилдаг байсан. Гэвч энэ нь явцуу байсан, тухайн зорилтот бүлгийн асуудлыг бичээд, яваандаа захиалга багасаад, редакц алдагдалтай ажилласан.
- Тохиолдлын журмаар оролцдог, нэвтрүүлэгт ордог, ярилцлага өгдөг байсан.

### Бид юу юун дээр алдсан бэ?

ХМБ-ын удирдлагуудтай ажиллаж чаддаггүй, бидний хүргэх гээд байгаа зүйлийг сэтгүүлч дур мэдэн гаргаж чаддаггүй тохиолдол байдаг. Тиймээс ХМБ-ын удирдлагуудтай ажиллаж, тэдэнд мэдээ, мэдээлэл хүргэх тал дээр алдсан.

- ХМ-ийнхэнтэй тогтмол харилцаа холбоо байдаггүй, эргэх холбоотой ажилладаггүй.
- Бид шаардлагатай мэдээ мэдээлэлгүй тул мэдээгээ хэрхэн хүргэх тал дээр хангалтгүй байна. Жишээ нь, ТВ-үүдийн үйл ажиллагааны чиглэлийг мэдэхгүйгээс болж байгаа боломжуудаа алддаг.



- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд, ХМ-ээр гарч байгаа өнгө төрх хэцүү, өрөвдмөөр байдаг. Энэ асуудал нийтлэг болсон бөгөөд үүнээс татгалзах хэрэгтэй. Тэдгээр хүмүүс олон нийтийн өмнө ийм байдлаар гарахыг хүсдэггүй, харин сэтгүүлчид тэдний хийх үйлдлийг нь заадаг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сэтгүүлчдийн удирдлаганд орсноороо алддаг. Тиймээс өөрсдийгөө бүрэн илэрхийлж ойлгуулах хэрэгтэй.
- Өөрсдөө хариуцлагатай байх, тухайлбал нийгэмд болон шийдвэр гаргачдад хүргэх асуудлаа сайн тодорхойлж, чанартай, мөн сонирхол татахуйц мэдээ, мэдээлэл хүргэх нь зүйтэй.
- Бусдыг лоббидож, танил талаа ашигладаг учраас бидний хүргэж буй мэдээ, мэдээлэл тогтмол биш. Мөн мэдээллийн хүртээмж хязгаарлагдмал байна. Олон нийтийн сүлжээ ашигласнаар, зарим хүмүүст, ялангуяа ахмад настан, интернэтгүй хүмүүст хүрэхгүй байх магадлалтай.
- Хүргэж байгаа мэдээлээ сонирхолтой болгохгүй бол үнэлгээ муу байдаг. Зөвхөн яриад суух биш кино, жүжиг гэх мэт олон төрлийн мэдээллийг ашиглах шаардлагатай. Хязгаарлагдмал орон зайд хязгаарлагдмал ажиллаж байгаа цар хүрээгээ тэлэх ёстой.

#### **Бидэнд юу дутагдаж байна, цаашид хэрэгтэй ямар чадавх, мэдлэг байна вэ?**

- Санхүүжилт, хөрөнгө мөнгө дутагдалтай. Ихэнх ТВ төлбөртэй мэдээлэл цацдаг тул мэдээлээ олон нийтэд тэр бүр хүргэж чаддаггүй.
- Нэн тэргүүнд өөрсдийгөө чадавхжуулах нь зүйтэй. Тухайлбал, хэвлэлийн мэдээ бэлтгэх, ярилцлага өгөх чадвар эзэмшиж, ТББ-ууд өөрсдийн ажилтнуудаас гадна гишүүдээ сургах, чадавхжуулах шаардлагатай. ТВ-үүдийн бодлого чиглэл, үйл ажиллагааны талаар мэдээлэлтэй болох хэрэгтэй.
- Мэдлэг мэдээлээ нэмэгдүүлэх шаардлагатай, олон улсын хэм хэмжээ, сайн туршлагыг судлах
- Нэвтрүүлэгт орох, ярилцлага өгөх гэж байгаа бол сэтгүүлчидтэй урьдчилан харилцан ойлголцох шаардлагатай
- Сэтгүүлчдийн, ХМБ-ын удирдлагын ёс зүйд нөлөөлөх ажил зохион байгуулах
- ИНБ-ууд нэгдээд, ХМБ-тай ажиллах нэгдсэн бодлого, баримтлах зарчимтай болох
- Техник тоног төхөөрөмжийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай
- Байгууллага бүр ХМ хариуцсан ажилтантай байхад боловсон хүчин дутагдалтай.

#### **Шаардлагатай мэдлэг, мэдээлэл юу байна? Хаанаас хэрхэн олж авах вэ?**

- ХМБ-уудтай шат дараалсан уулзалт хийх, ингэснээр шаардлагатай мэдлэг мэдээлэл олж авах боломжтой.



- ХМ-ийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг байгууллагуудын судалгааны материалуудтай танилцаад, мэдээ мэдээлэл олж авах.
- ОУБ-ууд олон нийтэд зөв хандлага өгч байгаа нэвтрүүлгүүдээс суралцах. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг энгийн байдлаар, бусдын адил хүн гэдгийг ойлгуулсан нэвтрүүлэг хийхэд анхаарах хэрэгтэй.
- Хэвлэл мэдээлэлтэй холбоотой хууль тогтоомж, төрийн бодлого судлах
- Техник, технологи ашиглах
- ОУ-ын хэм хэмжээ судлах
- Дүн шинжилгээ хийх чадвар эзэмших
- ИНБ-уудын хамтын ажиллагаа шаардлагатай, бие биенээ чадавхжуулах, мэдлэг, мэдээллээ солилцох шаардлагатай

**Цаашид хэрхэн хамтран ажиллах вэ? Шинэ арга барил юу байна, шинэ боломж юу байна? Хамтын ажиллагааны ямар хэлбэр байж болох вэ?**

- ХМБ-ын удирдлагуудад хандсан нөлөөллийн ажил, сургалтуудыг түлхүү хийх нь чухал. ИНБ-ууд бүгд нэгдсэн дуутай байх, бүгд зэрэг шаардаад, зэрэг дуугарвал их олон хүн бидний араас шаардах юм байна гээд асуудалд анхаарч эхэлнэ. Иймээс хамтарч дуугарах, дуу хоолойгоо нийлүүлж өргөх нь чухал.
- Хамтын ажиллагаагаа өргөжүүлэхдээ, бартерын журмаар ажиллаж болно. Жишээ нь, мэдээ, нэвтрүүлэг хийлгэсний төлөө тухайн сэтгүүлч, редакц, албаны дарга нарт чиглэсэн сургалт хийж болно.
- Мэдээ, нэвтрүүлэг цацах тал дээр, ХМБ-тай хамтарсан гэрээ, санамж бичигтэй болох.
- Асуудал дагнасан сэтгүүлч бэлдэх шаардлагатай. Асуудал, чиглэл дагнасан сэтгүүлч байвал тэднээр дамжуулах боломжтой.
- Ойрын боломж заавал ХМ гэхгүй, интернэт орчин ашиглаад, өөрсдийн нөөц боломжид тулгуурлаад ажиллах боломжтой, тухайлбал, сэтгүүлчдийн группээр дамжуулан хамтрах г.м.
- ХМБ-ын удирдлагууд, сэтгүүлчдэд хүний эрхийн талаар мэдлэг олгох сургалт хийх зайлшгүй шаардлагатай. Сургалтыг ИНБ-ууд өөрсдөө хийх нь зүйтэй.
- ТВ, сонин, ХМХ-ийн нэвтрүүлгүүдэд нийгмийн цөөнх рүү чиглэсэн нэвтрүүлгийн эзлэх хувийг тогтоох хэрэгтэй. Иймээс бодлогын түвшинд нөлөөлөх үйл ажиллагаа явуулах хэрэгтэй.
- Цаашдаа, бид бодлоготой байх ёстой, бүгдээрээ хоолойгоо нэгтгэх ёстой. Өөрсдийн гэсэн зарчимтай байх ёстой.

- Техник, тоног төхөөрөмжийн зайлшгүй дэмжлэгтэй байж л бид ХМ-тэй хамтрах өөрсдийнхөө үйл ажиллагааг сайжруулж чадна. Төсөл бичихдээ ХМ-тэй хамтрах, харилцах төсөв тусгах хэрэгтэй.
- Бид боловсон хүчний нөөц, хүний нөөцөд байнга анхаарах хэрэгтэй. ТББ-уудын дэргэд ХМ ажилтан бэлтгэхдээ, ХМБ-уудтай яаж урт хугацаагаар харилцан ашигтай хамтран ажиллахаа төлөвлөх.
- Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтарч ажиллах. Тогтоол журамд ТББ-уудын бэрхшээлтэй байгаа асуудлуудыг тусгах талаар нөлөөлөх.
- Хэвлэлийн кампанит ажил явуулах, нөлөөллийн ажил шаардлагатай. Олонд танигдсан, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүстэй хамтран, нийгмийн шторкууд хийх, эмэгтэйчүүдийн эрхийн асуудал, хүүхдийн эрхийн асуудал, асуудал нь орхигдсон хүмүүсийн асуудлаар нөлөөллийн ажлууд хийх.
- Туршлагатай байгууллагатай хамтран ажиллах, тэдний туршлага судлах
- Мэдээллийн олон төрлийн суваг, эх үүсвэр ашиглах, судлах
- ХМБ-ын удирдлагын үзэл хандлагыг өөрчлөх. ХМБ-уудын шийдвэр гаргах түвшнийхэнтэй хамтрах, уулзалт зохион байгуулах, нөлөөллийн ажил хийх, тэдний мэдлэг ойлголтыг дээшлүүлэх
- Нэвтрүүлэг, шоу, баримтат нэвтрүүлэг, кинонд нийгмийн орхигдсон бүлгийн төлөөллийг оролцуулах талаар ХМБ-уудтай зөвшилцөх, тэднийг өрөвдөх, гадуурхах өнцөгөөс биш тэдний эрх тэгш байдлыг хангасан мэдээлэл явуулах тал дээр нөлөөллийн үйл ажиллагаа явуулах
- ХМ-ийн тухай хуулиудад хүний эрхэнд суурилсан мэдлэг ойлголтын талаар тусгах, ХМХ-ийг өөрсдийг нь хүний эрхийн мэдрэмжтэй байх талаар хуулинд тусгах талаар зохицуулах болон бусад холбогдох байгууллагуудад нөлөөлж, хамтрах
- ИНБ-ууд хамтын хөрөнгө босгох

Чиглүүлэгчийн санал:

- Сэтгүүл зүйн сургуулиудын сургалтын хөтөлбөрт хүний эрхийн асуудлыг оруулах талаар нөлөөллийн ажил хийх
- Мэргэжлийн эвлэл холбоодтой хамтрах, тухайлбал МСНЭ, Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл г.м.

## НЭГДСЭН ХУРАЛДААН: БИД ХӨГЖЛИЙНХӨӨ ТӨЛӨӨ

### Эрх зүйн чадавхиа нэмэгдүүлэх нь

*Х.Номингэрэл, Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд ТББ-ын үүсгэн байгуулагч, УЗ-ийн дарга*

Эрх зүйн чадавхи гэдгийг бид хэрхэн ойлгох вэ? Иргэд, тэр дундаа хамгийн эмзэг, аливаа хэлбэрээр орхигдсон бүлгийн иргэд өдөр тутамдаа тулгарч байгаа асуудлаа хуулийг ашиглан шийдвэрлэх, төрийн байгууллагыг хариуцлагатай, үр нөлөөтэй ажиллуулахад шахалт үзүүлэх мэдлэг, чадвар, эрхтэй байхыг хэлнэ. Нөгөө талаар иргэд өөрсдөө илүү өөрт ашиглан хууль тогтоомжийг ашиглан аж байдлаа сайжруулах эрх мэдэл, чадавхтай болоход анхаарч байна. Гэтэл өнөөдөр иргэдэд эрх зүйн чадавхиа нэмэгдүүлэхэд хүндрэл учирч байна. Нэг жишээ хэлэхэд Хууль тогтоомжийг ашиглахад хэрэглэхэд улам хэцүү болоод байна.

Тэгвэд иргэдийнхээ эрх зүйн чадавхийг дээшлүүлэх ямар хэлбэрүүд байна вэ?

1. Хууль зүйн суурь мэдлэг мэдээллээр хангах, олж авахад туслах –Сургалтууд хийгддэ г,өдөр тутмын асуудалд хууль хамаардаг
2. Анхан шатны эрх зүйн туслалцаа– хууль зүйн зөвөлгөө
3. Шүүх болон маргаан шийдвэрлэх төрийн байгууллагад төлөөлж оролцох –ТББ Хийгддэг
4. Эвлэрүүлэн зуучлал, маргаан шийдвэрлэх бусад аргууд.
5. Нийтийн эрх ашгийг шүүхэд төлөөлөн хамгаалах/ стратегийн өмгөөлөл. Тухайн нэг иргэний асуудалд биш тухайн орон нутаг бүлгийн хэмжээний асуудал
6. Эмзэг, эрх нь зөрчигдөж буй бүлгийн эрх ашгийн төлөө хууль, бодлогын шинэчлэлийн нөлөөлөл –Нөлөөлөлд өөрсдөө хийх

Жишээ болгон Нээлттэй нийгэм Форумас 2016 онд хийсэн **“Иргэдийн эрх зүйн чадавхийн өнөөгийн байдал”** судалгааны дүнгээс үзэхэд иргэдэд ажил эрхлэлтэй холбоотой нийтлэг эрх зүйн асуудал, зээлтэй холбоотой асуудал, газрын өмчлөлийн талаар энэ бэрхшээл их тохиодож байна

Харин өөрт тохиолдож буй бэрхшээлийг шийдвэрлэх талаар иргэд тодорхой үйдэл хийхгүй байх нь 50 гаруй хувьтай бөгөөд үүний шалтгааныг 60 гаруй хувь нь **“юу ч хийгээд нэмэргүй”, “юу хийхээ мэдэхгүй”** гэжээ.Энэ өөрөө юуг харуулж байна вэ гэхээр иргэд өөрсдөө эрх мэдэлгүй бөгөөд хувьдаа итгэл, эрх мэдэлгүй байна. Үүнийг судалгааны дараахь дүгнэлт нотолж байна Тухайлбал, судалгаанд оролцогдсын 80 хувь нь бэрхшээлээ шийдвэрлэхийн тулд ямар нэг туслалцаа авахаар албан ба албан бус эх сурвалжид хандаагүй байна. Тэд өөрсдийнхөө туслалцаа аваагүй шалтгаанаа хэнд хандаж туслалцаа авахаа мэдээгүй (40 орчим %) хууль зүйн туслалцаа авдаггүй гэжээ.


Энэ нь хуулийг хялбаршуулсан тогтолцоог иргэд хүргэгдээгүйтэй холбоотой юм. Учир нь өнөөдөр хууль тогтоомжийг иргэдэд хялбаршуулан хүргэх цогц, тогтвортой тогтолцоо бүрдээгүй, орон нутаг дах хуульч, өмгөөлөгчдийн тоо хангалтгүй, асуудал хариуцсан төрийн төв болон орон нутгийн

байгууллагад төсөв, нөөц хангалтгүй, төлбөрийн чадваргүй, гэмт хэрэгт буруутгагдсан хүнд л хууль зүйн үнэгүй туслалцаа үзүүлдэг, хуульчдын сайн дурын үнэ төлбөргүй зөвлөгөө, туслалцаа үзүүлэх соёл өргөн дэлгэрээгүй, үйлхууль, эрх зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-нууд тодорхой нэг асуудалд чиглэсэн, тогтвортой нөөц санхүүжилтгүй, төслөөс төслийн хооронд ажиллаж байна. Харин иргэд энэ боломжийг сайн мэдэхгүй байна

## Хууль ТОГТООМЖУУД



Иргэдийн оролцооны  
хэлбэрүүдийг зохицуулсан хууль  
тогтоомжууд



- Бие даасан 500 орчим хуулиас иргэдэд мэдээлэл өгөхөөс эхлээд зөвлөлдөх, идэвхтэй оролцуулах, хяналт тавих зэрэг иргэдийн оролцооны хэлбэрүүдийг 105 хуульд тусгасан байна.

(Хуульч эмэгтэйчүүдийн холбоо, 2016)

Ийм учир бид нарт өдөр тутамдаа хамгийн ойр байх, хэрэгтцээтэй хуулиудыг дурьдвал:

- Үндсэн хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай
- Төсвийн тухай-Орон нутгийн хөгжлийн тухай хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль
- Нийтийн сонсголын тухай хууль
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
- Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль 2012 онд батлагдсан сайн хэрэгжихгүй байгаа.
- Ажилладаг салбарын хууль тогтоомжууд

Нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэх гаргах асуудал 2016 оны 07-р сараас эхлэн хэрэгжижи байна. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь *хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. Ингэж нэхэмжлэл гаргахын тулд дараахь шаардлагыг хангасан байна:*

1. нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх;
2. дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх.

Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжилж байгаа этгээдийг шүүхийн зардлаас чөлөөлнө./Нийтийн ашиг сонирхол учраас/

### **Бид яагаад эрх зүйн чадавхийн тухай ярих ёстой вэ?**

- Эдлэх ёстой эрхээ эдлэх, хүртэх ёстой үйлчилгээгээ хүртэнэ.
- Төрийн бодлого, шийдвэр гарахад бодитойгоор дуу хоолойгоо хүргэнэ.
- Төрийн нөөц боломж, төсвийг зохистой зарцуулахад нөлөөлнө.
- Төрийн алба, албан тушаалтнуудыг хариуцлагажуулна.
- Хөгжлийн үр шимийг тэгш хүртэх, аж байдлаа сайжруулна.
- Эрх зүйн чадавхыг дэмжих тогтолцоо бий болно.

Өнгөрсөн хугацаанд иргэний нийгмийн байгууллагууд ямар амжилт гаргасан вэ?

- Шүүхээс Петрочайна Дачин Тамсаг ХХК-аас байгаль орчныг доройтуулсны нөхөн төлбөрт 1,3 тэрбум төгрөгийг Дорнодын Матад сумын төсөвт оруулахаар шүүхээс шийдвэрлэж биелэгдсэн. 2010- 2013 он. /"Байгаль хамгаалах иргэний хөдөлгөөнүүдийн эвсэл"/
- Хөвсгөл аймгийн Бүрэнхааны фосфоритын ордод хууль бусаар олгосон тусгай зөвшөөрлүүдийг шүүхээс цуцалсан. /ХЭХТ/
- Нийтийн тээврийг үйлчилгээг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй болгох үүргээ биелүүлэхийг Нийслэлийг засаг даргад шүүхээс даалгасан.
- Хуулийн байгууллагууд дотоодод хүний наймааны золиос болж буй охидыг бие үнэлэгч гэж үздэг байсныг өөрчилсөн /2012 оноос хойш/
- Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хууль /ХЭҮТ/-ийг батлуулахын төлөө өрнүүлсэн ажлуудыг дурдаж болно.

Эцэст нь та бүхэнд Хууль зүйн мэдээлэл, туслалцааны хэрэгслүүдийн талаарх мэдээлэл өгье.

- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
- Хүний эрхийн үндэсний комисс [www.mn-nghrc.org](http://www.mn-nghrc.org) Аймаг бүрт ХЭҮК-ийн ажилтнууд ажиллаж байгаа. Хүний эрх зөрчигдсөн тухай асуудлаар гомдол гаргаж болно. Жишээ нь: Жендэрийн тэгш эрх зөрчигдсөн тухай гомдол.
- Хууль зүйн туслалцааны төв [www.lac.gov.mn](http://www.lac.gov.mn) Гэмт хэрэгт яллагдаж буй төлбөрийн чадваргүй иргэн ба эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлнэ. Аймаг, дүүрэг бүрт Улсын өмгөөлөгч ажиллаж байгаа.
- МУИС- Хууль зүйн сургуулийн Практик сургалтын тэнхим [www.mongolianlaws.com](http://www.mongolianlaws.com) Сургалтын тэнхим нь Хууль зүйн сургуулийн оюутнууд багшийн удирдлага дор анхан шатны хууль зүйн зөвлөгөөг уулзаж эсвэл интернетээр өгнө.
- Монголын Хуульчдын холбоо [www.mglbar.mn](http://www.mglbar.mn) . Энэ холбоо төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх, нийт өмгөөлөгчдийн лавлагаа үзэх , нийт өмгөөллийн хуулийн этгээдийн лавлагаа үзэх болон хуульч, өмгөөлөгчийн ёс зүйгүй үйлдлийн талаар гомдол гаргаж болно.

## ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУСГАХ НЬ

*Т.Амгалан, Хөгжлийн Замнал Сан ТББ-ын захирал, Жендэрийн Үндэсний Шинжээч*

Жендэрийн тэгш байдлын ойлголт нийгмийн хөгжлийн бодлогод хэрхэн тусгагдаж ирснийг товч танилцуулъя.

- 1960-70 он: Эдийн засгийн чиг баримжаат хөгжлийн хандлага
- 1970-80 он: Эмэгтэйчүүд хөгжилд хандлага
- 1980-аад оноос Жендэр ба хөгжил хандлага гэсэн байдлаар ярих болсон байна.

“Жендэр”-ийг хэрэглэх нь ямар ашигтай вэ? Яагаад Жэндер гэж яриад байгаа вэ? гээд өөрсдөөсөө хүртэл асуух хэрэгтэй. Яагаад Монголд улсад жэндер асуудал ярих шаардлага байгаа вэ? Анх 1996 онд Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр анхны хөтөлбөр батлагдсан. Хөтөлбөрт эмэгтэйчүүдийг оролцуулъя гэсэн санаа гарч байсан.

Жендэрийн асуудлыг хөндсөнөөр:

- ✓ **Соёл уламжлал, хөгжлийн хэрэгцээг харгалзах**
  - Нийгэм, соёлын хүчин зүйлс, үнэлэмжийг харгалзан үзэж уян хатан хандах, улс орон бүр өөрийн нөхцөл байдал, хэрэгцээнд тохируулах боломж олгодог
- ✓ **Цаг хугацааны хүчин зүйлийг тооцох**
  - Эмэгтэй эрэгтэй хүмүүсийн хэрэгцээ, үүргийн өөрчлөлт ба хөгжлийг олж харах, цаг үеийн хэрэгцээнд тохируулах боломж олгодог
- ✓ **Анги давхраа, амьжиргааны түвшин, ястан үндэстэн, баиршил, насны зэрэг ялгааг тооцох**
  - Нэг хүйсийн доторх эрх мэдэл, хүчний харьцаа, ялгаварт байдлыг авч үзэх боломж олгодог

Жендэр ба Хөгжил хандлага

- Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хэрэгцээнд тулгуурласан
- Төсөл хөтөлбөрт эмэгтэй эрэгтэйчүүд тэгш оролцох, үр ашгийг тэгш хүртэх боломж олгоход зорьсон
- Нийгэм, эдийн засаг, соёлын хүчин зүйлсийг харгалзан үзсэн
- Нийгэм дэх анги давхраа, ястан үндэстэн, бүлгүүдийн хэрэгцээг харгалзсан

Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг үйл хэрэг болгох стратеги (Gender mainstreaming)

ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ гэдэг нь хөгжлийн үйл явцад эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцох, хөгжлийн үр шимийг тэгш хүртэх боломжийг хэлдэг өөрөөр хэлбэл, Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн, охид хөвгүүдийн ялгаатай зан үйл, хүсэл эрмэлзэл болон хэрэгцээг **эн тэнцүү анхаарч, үнэлж** байх, тэдний эдлэх эрх, хүртэх буюу сонгох боломж бололцоо, хүлээх хариуцлага нь **ямар хүйстэй төрснөөс нь үл шалтгаалж** байх, эмэгтэй эрэгтэй **хэн ч болов бүрэн дүүрэн амьдрах** нөхцлийг бүрдүүлэх



Жендэрийн мэдрэмж, Жендэрийн хэрэгцээ гэж байна. Энэ нь хэнд (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүдэд) юу хэрэгтэй вэ? Яагаад?

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлагдсан нь “манай хөдөлгөөн”-ний түүхэн амжилт. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, түүний хэрэгжилт бол бидний бодлого, бодлогын нөлөөллийн сонгодог боломж. Тус хуулийг хэрэгжүүлэх талаар зохистой, оновчтой ажиллаж чадвал бид өөрсдийн хүсэж байгаа ажлаа мэргэжлийн түвшинд хийдэг болно гэсэн үг.

Би 1997 онд Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнд анх хөл тавьж байлаа. Тухайн үеээс хойш одоог хүртэл ажилласаар байна. Энэ чиглэлээр итгэл үнэмшилээрээ мэргэжлийн түвшинд өргөн урт хугацаанд ажилласанаар байна. Эмэгтэйчүүд бид Нийгмийг хөдөлгөгч хүч болгож чадсан. Анх Эмэгтэйчүүдийн хөдөлгөөн энэ чиглэлийн тухай ойлголтууд зөрүүтэй байсан бол одоо ойлголтын хүрээнд ахицтай байгаа бөгөөд ойлголтуудаа нэгтгэх шаардлагатай байна цаашид яах вэ гэдгээ ярилцах хэрэгтэй байна. Тухайн үедээ бид анхдагч болсон лидер эмэгтэйчүүдээ баярлалаа гэдгийг хэлмээр санагддаг. Анхны итгэл үнэмшил, суурийг сайн тавьж өгчээ гэдгийг цаашид энд байгаа эмэгтэйчүүд энэ чиглэлийг өвлүүлэн явуулахад бидний хувьд хариуцлагатай үе ирээд байна.

Жендерийн асуудлыг яагаал ярих болосон вэ? 1996 онд Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр гэж батлагдаж байсан. Тухайн үед Бээжинд болсон чуулганд ЗГ-ийн тэргүүн тухайн үеийн шилдэг эмэгтэйчүүдийг оролцож байлаа. Эмэгтэйчүүдийг хөгжилд оролцуулъя гэсэн дэлхий нийтийн хандлага байсан. Эмэгтэйчүүдийг орхигдсон бүлэг гээд томоохон төсөлд болон тусад нь эмэгтэйчүүдийг хөгжлийг дэмжсэн төсөл тусад нь байлгана гэсэнд дэлхийн эмэгтэйчүүд эсэргүүцэж бид нар бол халамж хүсэгчид биш, нийгмийг хөтөлгөч хүч, бид адил тэгш оролцоогойгоор оролцоно, хариуцлага хүлээн тиймээс өөр арга хэрэгсэл хэрэглэе гээд жендэр ба хөгжил гэсэн хандлагыг нэвтрүүлж үүнийг дагаад манай улс эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөрөө “Жендэр ба Хөгжил” үндэсний хөтөлбөр болгон өөрчлөгдсөн. Бид нар бол нийгмийг хөдөлгөгч хүч учраас эхэнд нь явна, хамтрана, хариуцлагыг нь хүлээн гэж яригдаж Жендэрийн асуудал яригдаж эхэлсэн юм

Зөвхөн бид эмэгтэйчүүдийн асуудлаас гадна гол ойлгох зүйл хийгдэж буй хийгдэж буй Бодлого хөтөлбөр, үйл ажиллагаа нь

- эрэгтэй эмэгтэйчүүдийг хэрэгцээнд нь тулгуурлан шийдэж байна уу үгүй юу
- Хэрэгцээнд нь тулгуурлан асуудлаа шийдэж байна уу
- Хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд эрэгтэй эмэгтэйчүүд бүгд хамрагдаж байна уу
- Тухайн нийгмийн соёлийн хүчин зүйлийг харгалзан үзэж хэрэгцээнд тулгуурлан хийгдэж байна уу гэдгээ шийдэж байж

Монгол эмэгтэй гэж хэн бэ? Өөрсдөө соёлын хүчин зүйл харгалзан үзэж байх хэрэгцээнээс гарч байна. Олон давхаргын хэрэгцээг ярьж эхлэх хэрэгцээ гарч байна. Яаж бид хамтарч ажиллах уу. Хэрэгцээтэй хүмүүст хүрч чадаж байна уу эсвэл бид хэсэг асуудлаа ярьчихаад энэ асуудлаа нийгмийн асуудал гэж эндүүрээд байгаа юм биш гэсэн асуудал гарч ирээд байна. Үүнээс үүдээд Жендэр ба хөгжил хамгийн гол хариулт болдог арга хэрэгсэл. Мөн Жендерийн тэгш байдал гэдэг чухал юм байна. Цаашдаа бид энэ асуудлаа төрийн бодлогод тусгуулахад цаашлаад хууль эрх зүйн орчинд нэвтрүүлэх амархан гэж хараад байгаа.



Эхлээд би жендэрийн мэдрэмжтэй байна уу? гэдгээ өөрөө өөрөөсөө асуух ёстой. Бүх зүйлээс эхлээд өөрийгөө мэдрэмжтэй байна уу гэдгээ өөрчил тэгээд дараа нь байгууллагад яаж жендэрийн мэдрэмжтэй болгох хэрэгтэй вэ? Дараа нь салбар руу орох хэрэгтэй. Тэгж байж бид нийгэмд нөлөөлнө.

Жендэрийн тэгш байдлыг бодлого нийгмийн хүрээнд өргөн хүрээний үйл явц процесс.Тэгвэл бид энэ үйл ажиллагааны **хаана нь** оролцох вэ гэсэн асуулт гарч ирж байна. ЖТБ хангах бодлого нь үндэсний хэмжээний ерөнхий зорилт байдаг учраас шууд хэрэгжүүлэхэд төвөгтэй. Иймд аймаг салбарууд өөрсдийн онцлогт тохируулан ЖТБ хангах дэд зорилт хөтөлбөр дэвшүүлээд эхэлсэн.Баянхонгор аймгийн сайн жишээ байна.Жендэрийн дэд хөтөлбөр боловсруулж бүхий л үйл явцдаа жендэрийн асуудлыг тусгаж байна.

Цаашдаа бид юунд анхаарах ёстой вэ? ЖТБ хамгаалах тухай хуулийг батлуулж чадсан.Олон жил тэмцэсний хүчинд батлуулж чадсан. Одоо бодлогод нөлөөлөх боломж гарч ирж байгаа. Энэ төртэй хамтарч хуулийг хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Төрөөс хэрэгжүүлэх мөнгийг төсвөөс авч хэрэгжүүлэгч байгууллага болж ажиллах хэрэгтэй байна. Хуульд зарим заалтад хэрэгжүүлэгч байгууллага ТББ гэж заасан байгаа хэдий ч хэрэгжиж чадахгүй байгаа.Засгийн газраас 2020 он болтол баримтлах Дэд хөтөлбөрийг боловсруулж байна. Хөтөлбөрийн үнэлгээ хийхэд ТББ-ууд орно гээ заасан байгаа.Энэ үнэлгээ хийхэд хэрхэн оролцож болох вэ гэдгийг бодох хэрэгтэй.

## Жендэрийн мэдрэмж

### Жендэрийн хэрэгцээ

*Хэнд (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүдэд) юу хэрэгтэй байна вэ? Яагаад?*



*Энэ ялгаатай хэрэгцээнд хэрхэн хандах вэ?  
Энэ ялгаатай хэрэгцээг хэрхэн хангах вэ?*

### Жендэрийн хүчин зүйл

*Хэнд юу нөлөөлж байна вэ?  
Энэ нөлөөлж буй хүчин зүйлс хэрхэн өөрчлөгдөж байна вэ?*



*Хүчин зүйлсийг хэрхэн анхаарч тооцох вэ?  
Уг хүчин зүйлсэд хэрхэн нөлөөлөх вэ?*

## ЦАХИМ ОРЧИНД АЖИЛЛАХ ЧАДАВХИА БЭХЖҮҮЛЭХ НЬ

*Л.Золзаяа, Промошн Крафт ХХК-ний Захирал*



Цахим орчин гэж юу вэ? Технологи даган цахим орчин үүсэж байна.Өнгөрсөн хугацаанд бид харилцаагаа телевиз захиа, радио, утас байсан бол энэ цаг үед бид компьютерын ард сууж байгаад цахим орчноор дамжуулан бид өөрсдийн хаанаас ч хэнтэй ч харилцаа холбоо тогтоох,ажил хөдөлмөр эрхлэх боломжтой болсон байгаа. Харин нь онлайн орчныг бид хэдэн хувь ашиглаж байна вэ гэдгээс хамаарч байна. Программ/word excel poirront/-г ашиглан орчинг ороход заримд нь айдас мэдлэггүйгээс орж чадахгүй бас боломжууд байна. Бид өнөөдөр хүмүүстэй биечлэн

уулзахаас илүү цахимаар ажиллах боломжтой. Цахим нь мэдээллээ хоорондоо солилцох, нийгэмд нөлөөлөл үзүүлэх, боломжтойгоос гадна бас санхүүжилт босгох боломжийг олгож байдаг билээ.

ICE BUCKET CHALLENGE –ALS-2014 онд Тархины хажуугийн хатуурал өвчин АНУ –д нэлээд элбэг тохиолддог бөгөөд жилд дунджаар 5000 дээш хүн өвддөг. Энэ өвчний талаарх мэдээ, мэдээлэл, хүмүүст хүргэх судалгааны санхүүжилт босгох гэж онлайн компани ажил өрнүүлжээ. 100,000 мянган хүн тутамд 2 хүн нас барж байгаа.2013 онд ТББ- 20 сая usd төгрөг босгож байсан бол 2014 он 2 сарын хугацаанд 250 тэрбум USD-г цуглуулж чадсан байгаа.Энэ бол цахим орчноор дамжуулан /youtube,fb,twiiter/санхүүжилт босгож чадсан нэг жишээ юм. Мөн хөрөнгө босгох олон вебсайт байдаг Үндсэн сайт нь англи хэл дээр байдаг. Юунд зориулж мөнгө босгох бүх мэдээллээ оруулаад санхүүжилт болгож болохоор байгаа. Энд бас хэлний мэдлэг бас их шаарддаг. Мөн INDIEGOGO, CAUSE VOX зэрэг сайтуудаар дамжуулан төрийн бус байгууллагууд нөлөөллийн ажил хийхэд зориулан санхүүжилт босгох боломж байдаг.

Манай төрийн бус байгууллагууд хамтраад 4 настай хүүхэд хүчирхийлэлд өртсөн хүүхдэд туслах аян өрнүүлээд тусалсан туршлага ч бий. Цахим орчин хэр хүчтэй вэ гэдгээ эндээс харж болохоор байна.

Бас нэг анхаарах асуудал бол цахим орчны аюулгүй байдал. Өнөөдөр цахим ямар арга хэрэгслүүдийг ашиглаж болох вэ? Гэдгийг та бүхэн харж болно. Гэхдээ цахим орчны аюулгүй байдлаа хэрхэн хангах вэ гэсэн асуулт гарч ирдэг. FB- холбоотойгоор олон нийтийн тохиргоотойгоор хийх үү ? Хувийн хаяг ажил утас энэ тэр бүх зүйл ил байлгах үү.Хаана байгаа бичиж өөрсдийгөө эрсдэлд оруулах магадлалтай.

Е-мэйлээр холбоотойгоор таны майл хаяг, дансны дугаарыг авч ямар нэгэн эрсдэл үүсгэж байна уу гэдгээ сайн асууж лавлаж байж илгээх ч юм уу. Үүнтэйгээр холбоотойгоор бид цахим орчноор дамжуулан өөрт ашигтайгаар хэрэглэж чадаж байвал танд баяр хүргэе. Зөв ашигтай зүйлд ашиглаарай

## Онлайн орчны боломж



## САЛБАР ХУРАЛДААНЫ ДҮГНЭЛТҮҮД: ХӨГЖЛИЙНХӨӨ ТӨЛӨӨ

### 1) Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд нэгтгэх нь салбар хуралдааны дүгнэлт

Чиглүүлэгч: Т.Амгалан, Хөгжлийн замнал сангийн захирал

Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх нь хөгжлийн үйл явцад оролцогч талуудын өмнө тулгарч буй чухал асуудлын нэг болоод байгааг хуралдаанд оролцогчид санал нэгтэй хүлээн зөвшөөрсөн.

Эмэгтэйчүүдийн хөдөлгөөний түүхэн амжилтын нэг нь Монгол улсын төрийн бодлогыг жендэрийн мэдрэмжтэй болох нөлөөллийн ажлыг манлайлан явж, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол улсын хуулийг батлуулсан явдал юм. Өнөөдөр бид энэхүү хууль, түүний хэрэгжилт нь бидний бодлого, бодлогын нөлөөллийн сонгодог боломж гэж харж хүлээн авч байна. Тиймээс цаашид тус хуулийг хэрэгжүүлэхэд оролцож, хуулиар бий болсон арга механизмыг ажиллуулахад мэргэжлийн түвшинд түншлэгчийн байр сууринаас хандах нь бидний цаашдын үйл ажиллагааны эхлэл болно гэдэгтэй санал нэгдсэн.

Салбар хуралдаанд оролцогчид өнөөдрийн хувьд дээрх хуулиар бидэнд олгосон орон зайг ашиглан, нэг талаас хуулийг хэрэгжүүлэх, нөгөө төлөөс өөрсдийн нөөц боломжийг үнэлэх, чадавхиа ахиулах боломж хаана байгаа талаар ярилцсан.

Монгол улс нь жендэрийн тэгш байдлыг хангах бодлогоо 2002 онд тодорхойлж Засгийн газраас "Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийг боловсруулан 2015 он хүртэл 3 үе шаттайгаар хэрэгжүүлсэн байдаг. Хөтөлбөрийн 3-р шатанд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлагдсантай холбогдуулан Засгийн газраас 2013-2016 онд хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги, төлөвлөгөөг нэмэлтээр батлан хэрэгжүүлж байна. Энэ онд Жендэрийн үндэсний хорооноос өмнөх үндэсний хөтөлбөрийн үргэлжлэл болгон 2017-2020 онд хэрэгжүүлэх Жендэрийн тэгш байдлыг хангах шинэ үндэсний хөтөлбөрийг боловсруулах, түүнийг хэлэлцүүлэх ажлыг улс орон даяар явуулж байна. Тиймээс салбар хуралдаанд оролцогчид тус бодлогын төлөвлөлтийн эхний шатнаас ИНБ оролцон, ямар асуудлын хүрээнд санал бодлоо тусгуулах талаар ярилцсан.

Жендэрийн үндэсний хорооны Ажлын албанаас хэлэлцүүлэгт зориулан гаргасан шинэ хөтөлбөрийн эхний хувилбарыг салбар хуралдаанд оролцогчидод танилцах боломжийг олгосон юм. Хөтөлбөрийн зорилго, дэвшүүлэн тавьж буй зорилтууд, зорилтуудын хүрээнд хийгдэхээр төлөвлөж буй үйл ажиллагаануудын саналтай танилцаад боловсруулахад болон хэрэгжүүлэхэд хэрхэн оролцох ямар асуудлуудыг тусгах талаар дараах саналуудыг гаргасан. Үүнд:

- Эмэгтэйчүүдийн байгууллага, хөдөлгөөний хүрээнд тодорхой өөрсдийн үйл ажиллагаатай уялдаатай, бид бас хийх боломжтой ажлын саналаа эхнээс нь тусгуулах үүднээс байгууллагуудын төлөөлөл оролцсон ажлын хэсэг байгуулан, хөтөлбөрт санал өгөх
- Жендэрийн үндэсний хорооны Ажлын албанд чуулганы зохион байгуулагчаар дамжуулан Жендэрийн үндэсний механизмыг хуулийнх нь дагуу тодорхой болгох

саналыг тавих, дараагийн хөтөлбөрийн хамгийн эхний үйл ажиллагаа нь жендэрийн асуудлаарх үндэсний механизмаа хуулийн дагуу байгуулах, салбар дундын асуудал хариуцах чадамжтай байлгах үүднээс Ерөнхий сайд ахалж байгаа учраас ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын дэргэд байршуулах асуудлыг шийдвэрүүлэх

- Монгол улсад жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааг олон улсын байгууллагууд маш тууштай дэмжиж, туслаж ирсэн байдаг. Жендэрийн асуудлаарх ихэнх томоохон төсөл, хөтөлбөрүүдийг олон улсын байгууллагуудын санхүүжилтээр хийж ирсэн. Тиймээс эдгээр байгууллагуудын өнөөг хүртэл оруулсан хувь нэмэр, хөрөнгө оруулалтыг олон нийт мэдэж байх ёстой. Тиймээс жендэрийн тэгш байдлыг хангах шинэ хөтөлбөрт олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрүүдээс жендэрийн асуудлаар хийсэн ажлууд болон зарцуулсан төсөв, санхүүжилтэнд үнэлгээ хийх судалгааны ажлыг хийхээр оруулах
- Шинэ хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулахдаа иргэний нийгмийн байгууллагуудаар тусгайлан хэлэлцүүлж санал авах
- Түүнчлэн ЖҮХ-оос бүх шатны засаг дарга нартай байгуулдаг үр дүнгийн гэрээнд нь жендэрийн тэгш байдлыг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тусгах
- Иргэний нийгмийн тэр дундаа орон нутгийн ТББ-аар жендэрийн хөтөлбөрийн хэрэгжилтэнд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг, санхүүжилтийн хамт хөтөлбөрт тодорхой зааж өгөх
- Эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх асуудлыг гол үндэс нь эдийн засгийн нөхцөл байдлыг дээшлүүлэх, тухайлбал, өмчлөх, хөрөнгө эзэмших, нөөцөөс хүртэх боломж зэрэгт байдаг. Тиймээс тус шинээр боловсруулагдаж буй хөтөлбөрт эдийн засгийн тэгш боломж олгох ЖЭТБХТХуулийн заалтыг хэрэгжүүлэхэд зориулсан тусгай зорилт дэвшүүлэх

Мөн салбар хуралдаанаас үндэсний хөтөлбөрийг боловсруулах үйл явцад оролцож, өөрсдийн саналаа тусгуулах ажлыг хийхээс гадна ИНБ, тэр дундаа эмэгтэйчүүдийн хөдөлгөөний хувьд яах вэ? гэдэг талаар ярилцан хэд хэдэн асуудлыг дэвшүүлсэн. Тухайлбал,

- 1) ИНБ-ууд, эмэгтэйчүүдийн ТББ-уудын хувьд ЖЭТБХТХуулиар олгосон чухал орон зай болох төрийн жендэрийн бодлогыг үнэлж, хэрэгжилтэнд нь мониторинг хийх явдал юм. Гэтэл өнөөг хүртэл энэ талаар тодорхой алхамууд хийгдэхгүй байгаа нь бидэнд мониторинг, үнэлгээ хийх чадавхиа дээшлүүлэх хэрэгцээ байгааг харуулж байгааг анхаарах хэрэгтэй байна.
- 2) “Төрийн зарим чиг үүргийг ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлэх” талаарх Засгийн газрын шийдвэрийг бодит байдлаар хэрэгжүүлэхэд манай эмэгтэйчүүдийн хөдөлгөөн нийгмийг манлайлан хөтлөж, өөрдсөө үлгэрлэн үзүүлэх шаардлагатай. Үүнийг жендэрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас эхлэж болно.

## 2) Эрх зүйн чадавхиа бэхжүүлэх нь –салбар хуралдааны дүгнэлт

Чиглүүлэгч: Х.Номингэрэл

Эрх зүйн чадавхийг бэхжүүлэх гэдэг ойлголт нь иргэд, тэр дундаа хамгийн эмзэг, аливаа хэлбэрээр орхигдсон бүлгийн иргэд өдөр тутамдаа тулгарч байгаа асуудлаа хуулийг ашиглан шийдвэрлэх, төрийн байгууллагыг хариуцлагатай, үр нөлөөтэй ажиллуулахад шахалт үзүүлэх мэдлэг, чадвар, эрхтэй байхыг ойлгодог бөгөөд иргэд өөрсдөө хууль тогтоомжийг ашиглан аж байдлаа сайжруулах эрх мэдэл, чадавхтай болоход анхаардаг. Ардчилсан тогтолцоонд шилжиснээс хойш өнөөг хүртэл 500 гаруй хууль тогтоомжууд, үүнээс хоёроос гурав дахин их дүрэм журмууд батлагдан үйлчилж байгаа ч тэр бүр иргэд өөрт тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай мэдээллийг олж авах, хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хангах, хамгаалалахад ашиглаж чадахгүй байна. Нөгөө талаар төрөөс иргэдийг хууль тогтоомжийн талаар мэдлэг мэдээллээр хангах, ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байдлаар хүргэх талаар хангалттай, цогц, тогтвортой арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй байна. Нэгдсэн хуралдааны үеэр танилцуулсан судалгааны энэхүү дүгнэлт салбар хуралдааны оролцогчдын хэлэлцүүлгээр батлагдаж байв.

Эрх зүйн чадавхиа нэмэгдүүлэх нь салбар хуралдаанд орон нутгийн төлөөлөл голцуу 15-16 оролцогчтойгоор дараах асуудлын хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлээ.

- Эрх зүйн чадавхыг дээшлүүлэх аргуудыг ашиглаж ажилласан жишээ?
- Эрх зүйн чадавхыг дээшлүүлэн ажиллахыг хүсч буй асуудал, бэрхшээл?
  - Тулгарсан бэрхшээл нь ямар асуудал байсан бэ?
  - Хэрхэн ажилласан, хаанаас эрх зүйн мэдээлэл, туслалцаа авсан?
  - Ямар байгууллагад хандсан?
  - Амжилт, сургамж?
- Эмэгтэйчүүдийн хөдөлгөөн бид эрх зүйн чадавхиа хэрхэн нэмэгдүүлэх вэ, арга хэлбэр, боломж?

Салбар хуралдааны оролцогчид орон нутагт тохиолдож буй, мөн орон нутгийн төрийн бус байгууллагуудаас иргэдийн мэдээлэл туслалцаа хүсдэг асуудлуудыг газар өмчлөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрх, хамгаалал, орон нутгийн төсөвт оролцох, төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт ба зарцуулалт, төрийн үйл ажиллагаанд мониторинг хийх, хууль, шүүхийн байгууллагуудын үйлчилгээ, төрийн мэдээллийн ил тод байдал, зээлийн хэт өндөр хүү зэрэг болохыг хөндөж, өөрсдийн байгууллагын туршлага, сургамж дээр үндэслэн ярилцлаа.

Орон нутагт болон тодорхой шинжээрээ эмзэг бүлгийн иргэдийн эрх зүйн чадавхыг нэмэгдүүлэхийн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа талаар саналуудыг дэвшүүлээ. Үүнд:

- Хууль тогтоомжийг иргэдэд ойлгоход амар, хялбар арга хэрэгслээр түгээдэг тогтолцоо шаардлагатай байна. Өнөөдөр төрөөс гаргаж Төрийн мэдээлэл, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан /www.legalinfo.mn/ зэрэг мэдээллийн аргууд нь хуулийг батлагсан хэлбэрээр нь нийтэлдэг бөгөөд эдгээр сувгуудыг төр, мэргэжлийн байгууллагууд, мэргэжилтнүүд хэрэглэдэг. Харин энгийн иргэдийн хувьд эдгээр эх сурвалжийг мэргэжилтний тусламжгүйгээр ашиглахад амаргүй хэвээр байна.



- Бүлгүүдийн онцлог хэрэгцээнд тохирсон арга хэрэгслээр мэдээлэл өгөх, чадавхжуулах. Тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүлэг тус бүрийн онцгой хэрэгцээг бодолцож мэдээлэл хүргэх суваг, арга хэрэгслийг тогтоох.
- Иргэдтэй шууд хамтарч ажилладаг ТББ-ыханыг нэн тэргүүнд хууль тогтоомжийн талаар сургалт мэдээлээр хангах, сургалтууд явуулж байх.
- Орон нутгийн ТББ-ханы хувьд төрийн байгууллагууд, ИТХ-тай ойр байгаагаа ашиглах, хамтарч ажиллах
- Монголын Хуульчдын холбоо, орон нутаг дах салбаруудыг иргэний нийгэм, ТББ-уудтай хамтарч ажиллахыг урих, холбоо нийгмийн ашиг сонирхлын төлөө ажилладаг хуульчдаа дэмжих бодлоготой болох.

Мөн оролцогчдоос эрх зүйн мэдээ мэдээллийг хүргэхдээ дараах арга хэрэгсэл иргэдэд хамгийн хүртээмжтэй байх боломжтойг дурдаж ярилцлаа.

- Орон нутагт мэргэжлийн бус ч сайн дурын эрх зүйн ажилтан, эрх зүйн хөтөчүүдийг бэлтгэх, тэдний иргэдэд мэдээлэл түгээх ажлыг дэмжих.
- Иргэдэд зориулсан эрх зүйн хялбаршуулсан мэдээллийн цахим сан бий болгох, бэлдсэн сайн дурын ажилтнууд, ТББ-хан түүгээрээ дамжуулан мэдээлэл авдаг, хоорондоо харилцдаг болох. Иргэдэд шаардлагатай мэдээллийг тус цахим сангаас авч иргэдэд дамжуулж мэдээлдэг байх.
- Хууль зүйн асуудлаар телевизийн тогтмол хөтөлбөртэй болох, зөвхөн нийслэлээс гэхгүй орон нутаг, аймагийн нэвтрүүлэг байж болно.

### **3) Цахим орчинд ажиллах чадавхиа бэхжүүлэх нь-Салбар хуралдааны дүгнэлт**

*Чиглүүлэгч: Л.Золзаяа*

Технологийн хөгжил дэвшил хурдтай нэмэгдэж байгаа өнөө үед бид цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхахгүй байх нь биднийг ажил хэргээ эрчимтэй урагшлуулан явуулахад гол саад, сул тал болох хандлагатай болж байна.

Хэдийгээр цахим орчинд бид өдөр тутамдаа facebook, e-мэйл зэргийг байнга ашиглаж байдаг боловч зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй үүнээс ч олон боломж, давуу тал бүхий програм хангамж, хэрэглүүрүүд нэмэгдсээр байна.

Харилцаа холбооныхоо гол хэрэглэгдэхүүн болсон интернетийн орчинд бид идэвхитэй байж сошиал медиа сувгууд, үүлэн технологид суурилсан онлайн ашиглах боломжтой програм хангамжуудыг ашиглан ажил хэргээ амжилттай явуулж, үр дүнг нь бодитоор мэдрэх хэрэгцээ шаардлага байсаар байна.

Гэвч бид цахим орчинд орохдоо тодорхой хэмжээний айдастай, шинийг туршиж үзэхдээ санаачлага муутай, идэвхигүй байгаа нь бидний хөгжлийг тодорхой хэмжээнд хойш нь татаж байгаа юм.



Иргэний нийгмийн байгууллагуудын хувьд онлайн орчинд идэвхитэй байх хэрэгцээ шаардлага маш чухал бөгөөд дэлхийн дахинаа төрийн бус байгууллагууд үүнийг идэвхитэй ашиглаж, гол давуу талаа болгосоор байна.

Энэ бол хийж буй ажлаа олон нийтэд сурталчлан таниулах, нийгэмдээ нөлөөлөл үзүүлэх, шаардлагатай төслийн санхүүжилт босгох зэрэг наад захын хэрэгцээг хангах боломжийг бидэнд олгож байгаагаараа давуу талтай билээ. Жишээ нь АНУ-д 2014, 7 болон 8-р сард болсон “ICE BUCKET CHALLENGE –ALS” буюу Тархины хажуугийн хатуурал хэмээх өвчний судлагаа шинжилгээний ажилд хөрөнгө босгох зорилгоор цахим орчинд өрнүүлсэн компани ажил 2-хон сарын хугацаанд 250 тэр бум төгрөг босгож чадсан нь өмнөх жилийнхээс даруй 5 дахин их мөнгө босгосон амжилттай түүх байдаг. Өдгөө тус өвчнөөр АНУ-д жилд 5,600-гаас дээш хүн өвчилж жилд 100,000 хүн дутмын 2 нь энэ өвчнөөр үхдэг гэсэн баримт байдаг байна.

Харин манай Монголын хувьд “Лантуун дохио” ТББ тэргүүтэй бусад ТББ, хөдөлгөөнүүд хамтран хүчирхийлэлд өртөж амь насаа алдсан 4 настай охины гэгээн дурсгалд зориулсан Цагаан цуглааныг онлайн орчинд хүмүүсийг уриалан зохион байгуулсан юм. 2015/02/28 болсон уг цуглааны үеэр нийт 15,600 хүн цугласан бөгөөд тэднээс 5600 гарын үсэг цуглуулж, засгийн газарт 8 заалт бүхий шаардлага хүргүүлсэн байна. Энэ мэт маш олон ТББ-ууд цахим орчинд өөрсдийн байр суурийг эзэлж давуу талаа болгон ашигласаар байна.

Гэхдээ онлайн орчин гэхээр зөвхөн фэйсбүүкээр хязгаарлагдахгүй бөгөөд өөрсдийн гэсэн вэбтэй, блогтой, сошиал медиа сувгуудтай, тэдгээр нь хоорондоо уялдаа холбоотой цогцоороо ажиллахыг хэлдэг. Гадаадын ТББ –уудын хувьд өөрсдийн вэб сайтаар дамжуулан бүх мэдээллээ хүргэж, мөн тэндээсээ хандив хүлээн авах хүсэлт, дансны мэдээлэлээ нээлттэй оруулсан байдаг нь давуу талд болдог. Түүгээр ч зогсохгүй цахим орчинд өөрийн хийж буй ажлынхаа үнэ цэнэ, ач холбогдолыг нь танилцуулж ойлгуулж чадваас бид ОУ-ын хандив босгох маш олон янзын вэб сайтуудаас хөрөнгө босгох боломж боллоцоо байсаар байна. Харин манай ТББ-ийн хувьд хэлний асуудал бэрхшээлүүд байдаг нь гол сул тал болж байгаа юм. Үүнийгээ хэрхэн боломж, давуу тал болгох вэ гэсэн асуулт бидэнд тавигдаж байгаа бөгөөд хэрвээ шинэ залуу боловсон хүчнүүдээр хүч сэлбэж, тэдний ур чадвар, мэдлэгийг өөрсдийн ажил хэрэгтээ ашиглах, залуу үетэйгээ хамтран ажиллаж чадсанаар энэхүү асуудлыг давах гарах боломж бидний өмнө байна.

Энэ бүхэнтэй зэрэгцэн дижитал орчны аюулгүй байдал, зөв хэрэглээ гэдэг зүйлийг орхигдуулахгүйгээр давхар ач холбогдол өгөх нь чухал юм. Цахим орчны аюулгүй байдал, тэр дундаа фэйсбүүкийн зохистой хэрэглээ, хувийн болон олон нийтийн тохиргоог зөв хийж сурах бидний хувийн аюулгүй байдал, хувь хүн болон байгууллагын нэр хүндтэй шууд холбогдож байгаа юм.

Салбар хуралдаанаар эдгээр бүх асуудлыг дэлгэрэнгүй хэлэлцэж, Өөрчлөлтийн Төлөөх Залуу Эмэгтэйчүүд ТББ-аас ирсэн хүндэт зочин Уянга бидэнд бодит туршлагаасаа хуваалцаж фэйсбүүкийн үр дүнтэй хэрэглээний талаар ярилцаж, оролцогчдийн асуултанд хариулж байлаа.

Эцэст нь бид цахим орчинд үр дүнтэй ажиллаж, нээлттэй оролцоотой байхад тулгамдаж буй биднээс шалтгаалах болон үл шалтагаалах асуудлуудыг ярилцаж дараах нэгдсэн дүгнэлтэнд хүрсэн юм:

Тэдний хувьд тулгамдаж буй асуудал нь Хөдөө орон нутгийн интернетийн хурд муу, цахим орчинд үр дүнтэй ажиллах талын мэдлэг мэдээлэл мөн дутмаг байдаг байна. Өөрсдийн бэлтгэсэн мэдээлэл агуулгаа хэрхэн үр дүнтэй олон нийтэд хүргэх арга барилаа мэдэхгүй байх зэрэг асуудлууд байна. Мөн цахим орчинд ажиллахад хэлний мэдлэг дутмаг байгаа нь бас нэгэн асуудал болж байна.

Энэ бүхнээс гадна Иргэний нийгмийн байгууллагуудын дундын нэгдсэн мэдээллийн санатай болж чадвал өөр хоорондоо хамтран ажиллах, холбоотой байх боломжтой гэсэн нэгэн санаачлага гарсан юм.

Эндээс бидний эхний удаадаа шийдвэрлэж чадах хамийн энгийн арга хэмжээ бол:

- 1) Иргэний нийгмийн байгууллагуудын дундын фэйсбүүк групптэй болох. Хоорондоо холбоотой байх
- 2) Цахим орчинд үр дүнтэй, зохистой хэрэглээний талаар сургалт авах, боломжгүй тохиолдолд хэвлэмэл болон онлайн орчинд үзэж болох видео гарын авлагатай болох.
- 3) Иргэний нийгмийн байгууллагуудын мэдээллийг нэг дороос авах боломжтой вэб сайттай байх зэрэг шийдвэрүүдэд ач холбогдол өгөн хэлэлцлээ.

## ЧУУЛГАНААС ГАРСАН БАРИМТ БИЧИГ

Бид энэ чуулганаар өөрсдийгөө хүчтэй болсноо мэдэрч бахархахдаа, хурдан хувьсаж өөрчлөгдөж байгаа орчин нөхцөлд өөрсдийгөө хэрхэн илүү сайн нийцүүлж, ухаанаа хурцалж, уран арга боловсруулан, илүү оновчтой, илүү үр дүнтэй ажиллах талаар илэн далангүй, нухацтай, бүтээлч шүүмжлэлтэй хэлэлцье гэж зорьсон. Өмнө цугларч уулзахдаа бид эрхэм зорилгынхоо төлөө яаж өөрсдийгөө илүү их дайчлах вэ гэдэг талаар ярьдаг. Харин энэ удаа юу хийх вэ гэхээсээ ЯАЖ илүү сайн хийх вэ гэсэн талаар дотроо, хоорондоо ярилцая гэж хүссэн билээ. Яаж хийх вэ гэсэн арга хандлагаа өөрчлөгдөж буй орчин, нөхцөлдөө илүү нийцүүлж, нийгэмдээ ч үр нөлөө гаргая, өөрсдөө ч өсөж хөгжие гэж эрмэлзсэн.

Бид илтгэгч, идэвхжүүлэгч, хөтөлгөчиддөө энэ талаар удирдамж өгч урьдчилан ярилцаж байхад ийм ярилцлага хийх цаг нь болсон, хойш нь тавьж болохгүй гэж, гардан ажиллаж хуримтлуулсан мэдлэг, туршлагаа уудалж, хоорондоо солилцож, бие биенээ баяжуулья гэж зорьсон.

Чуулганаа дүгнэх цаг боллоо. Бид өөрсөддөө илүү их ажил, үүрэг авч чаддаг билээ. Бидний ажилладаг асуудлууд олон, улам даяаршиж байгаа орчинд улам нарийн төвөгтэй болж байна. Жендэрт суурилсан, гэр бүлийн, бэлгийн хүчирхийлэл, ажлын байран дахь бэлгийн дарамт хэвээр, эмэгтэйчүүд, охидын эрхийн зөрчил гарсаар. Хүйсээр ялгаварлан гадуурхалтын нас улам залуужиж, хараа хяналтгүй охидын асуудал гарсаар байгаа тул бидэнд амсхийх чөлөө гарахгүй нь ээ. Үүнийг манай 13 салбар хуралдаанаас гарсан ажлын урт жагсаалтууд гэрчилнэ.

Эдгээр их ажлыг бид ЯАЖ? хийх, ямар мэдлэг чадвараар, ямар арга хандлагаар, ямар нөөц хөрөнгөөр хийх гэдэгт анхны удаа төвлөрч, цаашдын нухацтай хэлэлцлэгийг эхийг тавихыг зорилоо. Олон оновчтой, шинэ ажлын талаар санаа гарлаа.

Нийгэм орчин улам нягтарч, бид дан ганцаараа энэ ажлыг дийлэхгүй. Тэгэх шаардлага ч байхгүй. Шинэ, өөр хэвшил, салбарын түншүүдтэй мөн амжилттай ажиллаж ирсэн. Эдгээрийн дотор бид төрийн байгууллагыг онцлов. Бидний анхаарч ажиллах асуудалтай холбоотой асуудлаар батлагдан гарсан хууль тогтоомж нь бидний барих зэвсэг. Жишээ нь хууль, бодлогын хэрэгжилтэнд иргэний нийгмийн хараат бус мониторинг үнэлгээ бол бидний үйл ажиллагааны том талбар. Юуны өмнө гэр бүлийн хүчирхийллийн болон жендэрийн тэгш байдлын хууль, бодлого, журмыг эн тэргүүнд авч үзэн, хэлэлцэж, жендэрийн дунд хугацааны стратегийн агуулгыг дэлгэрэнгүй хэлэлцлээ.

Төр хууль, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөвт суулгадаг болсон нь бидэнд өмнө гарч ирж буй их том боломж. Үүнийг бүрэн ашиглахын төлөө бид ур ухаанаа дайчлах нь гарцаагүй. Цаашид бусад хууль, бодлого журмыг нягталж харвал бидэнд үйл ажиллагааны бүх ч том талбар бий. Зарим нь холбогдох санхүүжилтийн эх үүсвэртэйгээ байгаа. Нөгөө талаас, төрийн байгууллагатай нэг зорилгоор нэгдмэл ажиллахад асуудлуудаар зохистой, үр ашигтай шийдвэр гаргуулахад нөлөөлөх ажил улам ихсэж байгааг онцлон тэмдэглэв. Ингэснээр төрийн ч, бидний ч зорилго хэрэгжиж, охид, эмэгтэйчүүдэд, бүгдэд илүү их ашиг тус болно. Энэ бол биднээс ихийг шаардсан том сорилт боловч, томоохон эерэг боломж гэж үзлээ.

Бид хөдөлгөөн дотроо олон янз. Тэдгээрийнхээ ямар онцлог давуу талыг бид товойлгон түшиглэх вэ? Ахмад үе бидний нөөц боломж гэсэн санааг хэлэлцлээ. Бидний залгамж халаа залуу үед маань хангалттай орон зай, дуу хоолой, манлайлал өгөх хэрэгтэй талаар мөн ярилаа.

Өөр талаас нь харвал, бидний адил эрмэлзэлтэй, бидэнтэй төстэй өөр олон хөдөлгөөн байдгийг бид өдийн хүртэл төдийлөн анзаарсангүй.

Бидний чадавхийг сорьдог ажил бол хууль зүйн эрх мэдэлжүүлэлт. Бид өөрсдийн ийм эрх мэдлээ бэхжүүлэхийн сацуу эмэгтэйчүүд, хохирсон, гадуурхагдан орхигдсон бүсдын ийм эрх мэдлийг сайжруулахыг зорьдог. Нэлээн хэдэн амжилттай туршлага гарсан. Үүний нэг томоохон үр дүн бол төрийн алба, албан тушаалтнуудыг хариуцлагатай болгох. Энэ чухал сайн засаглалын үр нөлөөтэй ажил нь байгаль орчны хөдөлгөөнөөс гарсан ба манай хөдөлгөөнд ч нэвтэрч байна. Бид энэ чадварыг гарамгай эзэмшиж, зөрчигдсөн эрхийг сэргээж, бүруутанд хариуцлага тооцож, шудрага ёсыг тогтооно. Энэ бол өдөр тутам хийх том ажил. Манай эмэгтэй хуульчид, эрхийн идэвхтнүүд энд манлайлж байна. Энэ чиглэлийн ажлыг төрөөс мөн хувийн хэвшлээс санхүүжүүлэх шинэ боломж, эх үүсвэр улам өргөжиж байгааг анхааралдаа авлаа.

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог үндэсний болон орон нутгийн түвшинд тусад нь ярилцаад голлож анхаарах гурван шинэ түнш хамтрагчдыг онцлов: хэвлэл мэдээлэл /ялангуяа шинэ нэр дэвшигчийн танигдах боломжийг сайжруулахад/, сонгуулийн хороотой, улс төрийн намуудын өндөр албан тушаалтнуудтай ажиллах, тэдгээрийн дэргэдэх ахмад, эмэгтэйчүүд, залуучуудын байгууллагуудтай ажиллах асуудлаар ярилцлаа.

Орон нутагт төлөөлөлийн оролцооноос чанарт илүү анхаарья гэж үзээд шинээр анхаарах хамтрагчдын дунд намууд болон сум дүүргийн ИТХ, Засаг дарга, баг хороодын анхан шатны дарга нарыг тэмдэглэв. Эрчүүдийг элсүүлэх, “Намын харьяалаар намайг битгий хараач” хөдөлгөөн өрнүүлэх, залуу эмэгтэйчүүдийг түлхүү гаргаж ирэх зэрэг шинэлэг ажлын санаа гарлаа. Анхан шатны эмэгтэйчүүдийн зөвлөл, хороодын сүлжээ үүсгэх, эмэгтэй лидер гаргаж ирэх чиглэсэн зорилготой ажил хийх нь зүйтэй гэж үзэв. Бид хүчээ нэгтгэх ажил бол “Эмэгтэйчүүд- эмэгтэйчүүдээ дэмждэг” гэдэг мессежийг нийгэмд дэлгэрүүлэх явдал гэдэгт санал нэгдлээ.

Жендэрт суурилсан хүчирхийлэл бол салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагааг ихээр шаардана, ялангуяа төрийн албанд үүнээс сэргийлсэн журам нэвтрүүлэхэд түлхэх, шаардах, нөлөөлөх нь чухал. Орхигдсон нэг асуудал бол шашны салбарууд дахь эмэгтэйчүүдийн ялгаварлан гадуурхалт бөгөөд тэдгээр байгууллагад ажилладаг хүмүүсийн дунд ЖСХ-ийн ойлголтыг сайжруулахад анхаарах нь зүйтэй.

Хөдөлгөөний залгамж холбоо бий болж, шинэ үеэр манай хөдөлгөөн хүчээ амжилттай сэлбэж байна. Гэвч зарим зөрчил, үл зохицол байгааг тэмдэглэв. Хоёр, гурван үе мөр зэрэгцэж байгаа орчинд бие биенээ хүндлэн, нэг нь нөгөөгөө нөхдөг, баяжуулдаг гэдэг уур амьсгалыг бэхжүүлж, орчин үеэ төлөөлсөн залуу үедээ илүү орон зай гаргах, ялангуяа шийдвэр гаргалт, боловсруулах шатанд хамруулах талаар анхаарахыг чухалчлав. Тэд нийгмийн гэгээрэл, сурталчилгааг гайхамшигтай хийж чадахаа тогтмол нотолж байна. Залуучуудад зориулсан төрөл бүрийн зорилтот хөтөлбөр бий болгох, харин тэд өмнөх сайн туршлага, замналыг гүн гүнзгий мэдэж, залгамж чанарыг хадгалахад анхаарах ёстойг тэмдэглэв. Үе хоорондын ялгаа бидний ажлыг сааруулах ёсгүй.

Охидын эсрэг үе тэнгийн дарамт, залуу эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоо, манлайллыг асуудлыг эн тэргүүн рүү шилжүүлэх хэрэгцээ бий болжээ. Үндэсний хэмжээний суурь судалгаа үүнд хэрэгтэй юм.

Эдгээр ажил тус бүр өөр оновчтой хандлага, шинэлэг аргачлал /урлаг, сэтгүүл г.м./ шаардах тул ур ухаанаа хамтран хүчээ сорино. Эдгээр санаа, бодол, жишээ чуулганы дараа ч бидний бодлын том мухарт өдөр тутам байж, бидний хандлага, арга барилд эерэг сайнаар тогтмол нөлөөлж, чиглүүлж байна гэж найдаж байна. Бид нийгэм, эмэгтэйчүүддээ сэтгэл зүрхээ өгсөн. Үүнээс цааш бид тэдэндээ мэргэжилтний өндөр түвшинд хүрсэн, оновчтой, үр ашигтай гүйцэтгэлээ зориулна.

Та бүхэндээ идэвхтэй 2 өдрийн турш идэвхтэй ажилласанд талархлаа илэрхийлье. Цаашдын ажил, амьдралд чинь өндөр амжилт хүсэн ерөөе!!

Бид нийгмийн хөдөлгөгч хүчин мөн, цаашдаа улам бэхжин мэргэшинэ !!